



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН 2023 ОНЫ НАМРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН

2023 ОНЫ 12 ДУГААР САРЫН 19-НИЙ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААН

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ХЭЛТЭС

Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дараах
QR кодыг уншуулан танилцах боломжтой.

НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА

2023 оны 12 дугаар сарын 19-ний өдөр, Мягмар гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга	1
Хуралдааны товч тэмдэглэл:	2-29
Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:	30-101
<hr/>	
<i>1.Нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2023.06.28-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/</i>	30-45
<i>2.Хүүхэд хамгааллын тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2023.10.13-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/</i>	45-99
<i>3.Байнгын хорооны тогтоолын төсөл /Хянан шалгах түр хорооны ажиллах хугацааг сунгах тухай/</i>	99-101

**Монгол Улсын Их Хурлын 2023 оны намрын ээлжит
чуулганы Нийгмийн бодлогын байнгын хорооны
12 дугаар сарын 19-ний өдөр /Мягмар гараг/-ийн
хуралдааны товч тэмдэглэл**

Улсын Их Хурлын гишүүн Ж.Чинбүрэн ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 17 гишүүнээс 10 гишүүн хүрэлцэн ирж, 58.8 хувийн ирцтэйгээр хуралдаан 10 цаг 27 минутад Төрийн ордны “Жанжсин Д.Сүхбаатар” танхимд эхлэв.

Томилолттой: Д.Батлут, Б.Саранчимэг;

Чөлөөтэй: С.Ганбаатар, М.Оюунчимэг;

Эмнэлгийн чөлөөтэй: П.Анужин..

Нэг.Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2023.06.28-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Эрүүл мэндийн сайд С.Чинзориг, Эрүүл мэндийн яамны Нийтийн эрүүл мэндийн газрын дарга Д.Баярболд, мөн газрын мэргэжилтэн Э.Баяртулга, мөн яамны Бодлого төлөвлөлтийн газрын ахлах шинжээч Б.Нинж, Хуулийн хэлтсийн мэргэжилтэн Э.Цэрэнчунт, Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төвийн захирал С.Өнөрсайхан, мөн төвийн Стратеги удирдлагын албаны дарга У.Эрхэмбаяр нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Ё.Энхсайхан, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Нийгмийн бодлогын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Б.Цогзолбаяр, референт Г.Нямсүрэн нар байлцав.

Төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Нийгмийн бодлогын байнгын хорооноос гаргасан танилцуулгыг ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Д.Сарангэрэл танилцуулав.

Байнгын хорооны танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ц.Туваан, С.Одонтуяа, Ц.Сандаг-Очир, Б.Бейсен нарын тавьсан асуултад Эрүүл мэндийн сайд С.Чинзориг, ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Д.Сарангэрэл, ажлын хэсгийн гишүүн, Улсын Их Хурлын гишүүн Ж.Чинбүрэн, Эрүүл мэндийн яамны Нийтийн эрүүл мэндийн газрын дарга Д.Баярболд, Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төвийн захирал С.Өнөрсайхан нар хариулж, тайлбар хийв.

Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томьёолоор санал хураалт явуулав.

**Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн
42 дугаар зүйлийн 42.2.1 дэх заалтыг үндэслэн хураах санал:**

Ж.Чинбүрэн: 1.Төслийн 4 дүгээр зүйлийн гарчгийн “Үйл ажиллагаанд баримтлах” гэснийг “Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний” гэж, 4 дүгээр зүйлийн 4.1.3 дахь заалтын “нотолгоонд” гэснийг “судалгааны үр дүн, нотолгоонд” гэж тус тус өөрчилж, 4.1.1 дэх заалтын “, тэгш хүртээмжтэй, чанартай” гэснийг хасаж, мөн зүйлд доор дурдсан агуулгатай дараах заалт нэмэх:

“4.1.8.чанар, үр ашигтай байх;

4.1.9.тэгш хүртээмжтэй байх;

4.1.10.жендэрийн эрх тэгш байдлыг хангах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8

Татгалзсан: 3

Бүгд: 11

72.7 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Төслийн 5 дугаар зүйлийн 5.2 дахь хэсэг, 5.2.1 дэх заалтыг нэгтгэн доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“5.2.Энэ хуулийн 5.1.1-д заасан нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх хүрээнд дараах үйл ажиллагаа явуулна:

5.2.1.халдварт болон халдварт бус өвчний эрсдэлт хүчин зүйлийн тархалтыг тандан судлах, тодорхойлох, урьдчилан сэргийлэх, хянах арга хэмжээг орчин үеийн болон уламжлалт анагаах ухааны судалгааны үр дүн, нотолгоонд суурилан зохион байгуулах;

5.2.2.нийгмийн эрүүл мэндийн мэдээллийн сан бүрдүүлэх, мэдээ, мэдээлэлд дүн шинжилгээ хийх.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8

Татгалзсан: 3

Бүгд: 11

72.7 хувийн саналаар дэмжигдлээ.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн
42 дугаар зүйлийн 42.2.3 дахь заалтыг үндэслэн хураах санал:

Ж.Чинбүрэн: 1.Төслийн 19 дүгээр зүйлийн 19.4 дэх хэсгийн “байгууллагын” гэснийг хасах гэсэн саналаар дахин санал хураалгая гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8

Татгалзсан: 3

Бүгд: 11

72.7 хувийн саналаар дэмжигдлээ.

Ж.Чинбүрэн: 1.Төслийн 19 дүгээр зүйлийн 19.4 дэх хэсгийн “байгууллагын” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8

Татгалзсан: 3

Бүгд: 11
72.7 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн М.Оюунчимэг Улсын Их Хурлын чуулганы хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 11 цаг 15 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр.Хүүхэд хамгааллын тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2023.10.13-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Гэр бүлийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Н.Баярмаа, мөн яамны Хуулийн дарга Д.Ренчиндорж, Хүүхдийн эрхийн хэрэгжилтийн бодлого, зохицуулалт хариуцсан мэргэжилтэн Ж.Азжаргал, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын шинжээч Г.Оюунболд, Хүүхэд, гэр бүлийн хөгжил хамгааллын ерөнхий газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Н.Өлзийхутаг, Боловсролын ерөнхий газрын дарга Т.Ням-Очир, Нийслэлийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын Хүүхдийн хөгжил, хамгааллын хэлтсийн дарга Б.Батсайхан, Боловсрол, шинжлэх ухааны яамны Ерөнхий боловсролын бодлогын удирдлага, зохицуулалтын газрын Сургуулийн өмнөх боловсролын хэлтсийн дарга Ж.Мягмар, мөн яамны шинжээч Б.Дуламсүрэн, Соёлын яамны Соёлын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Д.Наранцэцэг, Эрүүл мэндийн яамны Эмнэлгийн тусламж, үйлчилгээний газрын дарга А.Өнөржаргал, Цахим хөгжил, харилцаа холбооны яамны Хуулийн хэлтсийн дарга Л.Нямдорж, мэргэжилтэн Э.Оюун-Эрдэнэ, Харилцаа холбооны зохицуулах хорооны Зохицуулалтын бодлогын хэрэгжүүлэх газрын дарга Т.Батболд, мөн хорооны ахлах мэргэжилтэн А.Уранчимэг, Хүний эрхийн Үндэсний Комиссын гишүүн Х.Мөнхзул, Цагдаагийн ерөнхий газрын Гэр бүлийн хүчирхийлэл, хүүхдийн эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх хэлтсийн дарга П.Болормаа, Үндэсний аудитын газрын Санхүү-нийцлийн аудитын газрын аудитын ахлах менежер С.Бат-Эрдэнэ, мөн газрын менежер Ч.Болд, аудитын менежер Г.Мөнхчимэг, Хүүхдийн эрхийн сургалт, судалгааны үндэсний хүрээлэнгийн тэргүүн, судлаач, доктор Б.Жавзанхүү, Хуулийн зөвлөх, өмгөөлөгч П.Баттулга нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх М.Отгон, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Нийгмийн бодлогын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Б.Цогзолбаяр, референт Г.Нямсүрэн нар байлцав.

Хуулийн төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх ажлын хэсгийн санал, дүгнэлтийг ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Ц.Идэрбат танилцуулав.

Ажлын хэсгийн санал, дүгнэлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Баярсайханы тавьсан асуултад ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Ц.Идэрбат хариулж, тайлбар хийв.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.10-т заасны дагуу Хүүхэд хамгааллын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг зүйл бүрээр хэлэлцэв.

Хүүхэд хамгааллын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн талаар ажлын хэсгээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын

томъёоллоор санал хураалт явуулав.

Хуулийн төслийн 1.1, 1.2, 1.3 дугаар зүйлүүдтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт гараагүй болно.

Ж.Чинбүрэн: 1. Улсын Их Хурлын гишүүн Ц.Идэрбат, П.Анужин, Б.Баярсайхан, Б.Бейсен, Б.Жаргалмаа /цаашид “Ажлын хэсэг” гэх/ нарын гаргасан, Төслийн 1.3 дугаар зүйлийн 4 дэх хэсгийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн:	5
Татгалзсан:	4
Бүгд:	9

55.6 хувийн саналаар дэмжигдлээ.

Хуулийн төслийн 1.4 дүгээр зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнх-Оргил үг хэлэв.

Ж.Чинбүрэн: 2. Төслийн 1.4 дүгээр зүйлийн 1.3 дахь заалтын “учруулахуйц үл хайхрах” гэснийг “учруулах” гэж өөрчилж, мөн заалтын “сэтгэл санаа,” гэсний дараа “эдийн засаг” гэж, мөн зүйлийн 1.12 дахь заалтын “кейс менежмент” гэсний өмнө “тохиолдлын зохицуулалт” гэж тус тус нэмж, 1.11 дэх заалтын “хүүхдийн эцэг, эх болон хүүхдийн эцэг, эхтэй гэрлэсэн хүн ороогүй, түүнчлэн” гэснийг, мөн зүйлийн 2 дахь хэсгийг тус тус хасаж, мөн зүйлийн 1 дэх хэсэгт доор дурдсан агуулгатай 1.6, 1.15, 1.16 дахь заалтыг тус тус нэмэх:

“1.6. “хүүхдийг үл хайхрах” гэж хүүхдийн аюулгүй байдал, боловсрол, эрүүл мэнд, бие махбод, сэтгэл санаа, хөгжил, оролцооны хэрэгцээг гачигдуулсны улмаас хүүхдэд гэм хор учруулсан болон учруулахаар завдсан, эсхүл энэ нөхцөл байдлыг мэдсээр байж хүүхдийг хамгаалах, урьдчилан сэргийлэх арга хэмжээ аваагүй эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч, хуулиар үүрэг хүлээсэн бусад этгээдийн үйлдэл, эс үйлдэхүйг;

1.15. “хориотой агуулга” гэж хуулиар хориглосон контент, бүтээл, мэдээ, мэдээлэл, зар сурталчилгааг;

1.16. “хүүхдэд хортой агуулга” гэж хуулиар хориглоогүй боловч хүүхдийн эрүүл мэнд, нас, бие махбод, оюун санаа, ёс суртахууны хөгжил, төлөвшил, хүмүүжилд сөргөөр нөлөөлөх контент, бүтээл, мэдээ, мэдээлэл, зар сурталчилгааг; гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн:	6
Татгалзсан:	3
Бүгд:	9

66.7 хувийн саналаар дэмжигдлээ.

Дээрх саналыг найруулгын засвартайгаар дэмжлээ.

Хуулийн төслийн 1.5 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнх-Оргил үг хэлэв.

Ж.Чинбүрэн: 3.Төслийн 1.5 дугаар зүйлийн 1.5 дахь заалтыг хасаж, мөн зүйлийн 2 дахь хэсгийн “хүүхдэд зааж сургахдаа” гэснийг “хүүхэдтэй харилцахдаа” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 3
Бүгд: 9
66.7 хувийн саналаар дэмжигдлээ.

4.Төслийн “ХОЁРДУГААР БҮЛЭГ” гэснийг “ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ” гэж өөрчилж, мөн зүйлийн мөн зүйлд доор дурдсан агуулгатай 5 дахь хэсэг нэмэх:

5.Хүүхдийн эсрэг болон хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг үйлдэж эрүүгийн хариуцлага хүлээсэн хүнийг хүүхдийн эрх, хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлдэг байгууллагад ажиллуулах, хүүхэдтэй холбоотой ажил, үүрэг гүйцэтгүүлэхийг хориглоно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 3
Бүгд: 9
66.7 хувийн саналаар дэмжигдлээ.

Хуулийн төслийн 2.1, 2.2, 2.3 дугаар зүйлүүдтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт гараагүй болно.

Хуулийн төслийн 2.4 дүгээр зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнх-Оргилын тавьсан асуултад ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Ц.Идэрбат, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Гэр бүлийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Н.Баярмаа нар хариулж, тайлбар хийв.

Ж.Чинбүрэн: 5.Төслийн 2.4 дүгээр зүйлийн 1.3 дахь заалтыг хасаж, мөн зүйлийн 1.4 дэх заалтын “этгээдийг” гэснийг “этгээдэд тавигдах шаардлага,” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 3
Бүгд: 9
66.7 хувийн саналаар дэмжигдлээ.

Хуулийн төслийн 2.5 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт гараагүй болно.

Хуулийн төслийн 2.6 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнх-Оргилын тавьсан асуултад ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Ц.Идэрбат, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Х.Бугантуяа, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Гэр бүлийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Н.Баярмаа нар хариулж, тайлбар хийв.

6.Төслийн 2.6 дугаар зүйлийн 1.6 дахь заалтын “судалгаа хөтөлж,” гэсний дараа “хүүхэд хамгааллын нэгдсэн” гэж нэмж, мөн зүйлд доор дурдсан агуулгатай 5 дахь хэсэг нэмэх:

“5.Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан орон нутгийн байгууллагын дарга Төрийн албаны тухай хуульд заасан нийтлэг шаардлагаас гадна хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан төрийн байгууллагад 4-өөс доошгүй жил, үүнээс хүүхэд, гэр бүлийн нийгмийн ажилтнаар хоёроос доошгүй жил ажилласан байна.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 1
Татгалзсан: 8
Бүгд: 9

11.1 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнх-Оргилын “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Ж.Чинбүрэн: Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнх-Оргилын гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 2
Бүгд: 9

77.8 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Ж.Чинбүрэн: Төслийн 2.6 дугаар зүйлийн 1.6 дахь заалтын “судалгаа хөтөлж,” гэсний дараа “хүүхэд хамгааллын нэгдсэн” гэж нэмж, мөн зүйлд доор дурдсан агуулгатай 5 дахь хэсэг нэмэх:

“5.Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан орон нутгийн байгууллагын дарга Төрийн албаны тухай хуульд заасан нийтлэг шаардлагаас гадна хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан төрийн байгууллагад 4-өөс доошгүй жил, үүнээс хүүхэд, гэр бүлийн нийгмийн ажилтнаар хоёроос доошгүй жил ажилласан байна.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулья.

Зөвшөөрсөн: 4
Татгалзсан: 5
Бүгд: 9

44.4 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Хуулийн төслийн 2.7 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

7.Төслийн 2.7 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн “мэргэжлээр дээд боловсролтой,” гэснийг “, эсхүл боловсрол, нийгмийн ухааны чиглэлээр дээд боловсрол эзэмшиж” гэж өөрчилж, мөн зүйлийн 2.3 дахь заалтын “үнэлгээ хийх,” гэсний дараа “дүгнэлт гаргах,” гэж, мөн зүйлийн “кейс” гэсний өмнө “тохиолдол” гэж тус тус нэмж, мөн зүйлд доор дурдсан агуулгатай 2.9 дэх заалт нэмэх:

“2.9.Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд заасны дагуу хүүхдийн хууль ёсны төлөөлөгчөөр оролцох;” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 3
Бүгд: 9
66.7 хувийн саналаар дэмжигдлээ.

8.Төслийн 2.7 дугаар зүйлийн 6, 7 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулж, 6 дахь хэсэг болгон өөрчилж, мөн зүйлд доор дурдсан агуулгатай 8 дахь хэсэг нэмэх:

“6.Сум, хорооны 3000 хүртэлх хүн амд нэг хүүхэд, гэр бүлийн нийгмийн ажилтан байхаар тооцож сум, хороо бүрд ажиллуулна.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 5
Татгалзсан: 4
Бүгд: 9
55.6 хувийн саналаар дэмжигдлээ.

Хуулийн төслийн 2.8 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнх-Оргил, Б.Баярсайхан нарын тавьсан асуултад ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Ц.Идэрбат, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Х.Булгантуяа нар хариулж, тайлбар хийв.

Дээрх санал дээр Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнх-Оргил цөөнх болов.

Ж.Чинбүрэн: 9.Төслийн 2.8 дугаар зүйлийн 1, 2 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“1.Монгол Улсын хэмжээнд Хүүхдийн төлөө үндэсний зөвлөл, орон нутагт хүүхдийн төлөө зөвлөл нь хүүхэд хамгааллын бодлогын хэрэгжилтэд хяналт тавина.

2.Хүүхдийн төлөө үндэсний болон орон нутгийн зөвлөл улирал тутам хуралдаж, хүүхэд хамгааллын талаар хийсэн ажлын тайланг хэлэлцэж, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний талаар төрийн захиргааны төв болон нутгийн захиргааны байгууллага, нутгийн өөрөө удирдах байгууллага, холбогдох бусад хуулийн этгээдэд зөвлөмж өгч, хүүхэд хамгааллын бодлого тодорхойлох, шийдвэр гаргахад талуудын оролцоог хангаж, санал, дүгнэлт гаргана.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 5
Татгалзсан: 4
Бүгд: 9
55.6 хувийн саналаар дэмжигдлээ.

Хуулийн төслийн 2.9, 2.10 дугаар зүйлүүдтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт гараагүй болно.

Ж.Чинбүрэн: 10.Төслийн 2.10 дугаар зүйлийн 1.2 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулж, мөн зүйлд доор дурдсан агуулгатай 2.2 дахь заалт нэмэх:

“1.2.Төсвийн тухай хуулийн 8.5.1-д заасны дагуу тухайн шатны жилийн төсвийн төслийг иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн мэдүүлэхдээ хүүхэд хамгааллын үйлчилгээ, хамтарсан баг болон хууль зүйн хорооны үйл ажиллагааны зардлыг тусгах;

2.2.Төсвийн тухай хуулийн 8.5.3-г заасны дагуу тухайн шатны жилийн төсвийн төслийг иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн мэдүүлэхдээ хүүхэд хамгааллын үйлчилгээ, хамтарсан баг болон хууль зүйн хорооны үйл ажиллагааны зардлыг тусгах;” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 3
Бүгд: 9
66.7 хувийн саналаар дэмжигдлээ.

Хуулийн төслийн 2.11 дүгээр зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнх-Оргилын тавьсан асуултад ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Ц.Идэрбат хариулж, тайлбар хийв.

Ж.Чинбүрэн: 11.Төслийн 2.11 дүгээр зүйлийн 4 дэх хэсгийн “байгуулж болно” гэснийг “байгуулна” гэж, мөн зүйлийн 6 дахь хэсгийн “Засаг даргын орлогч” гэснийг “тухайн аймаг, дүүргийн Засаг даргын ажлын албаны хуулийн асуудал хариуцсан нэгжийн дарга” гэж тус тус өөрчилж, 9 дэх хэсгийн “байгууллага,” гэсний дараа “сум дахь хууль зүйн хорооны нарийн бичгийн даргын үүргийг тухайн сумын хүүхэд, гэр бүлийн нийгмийн ажилтан” гэж нэмж, мөн зүйлийн 3 дахь хэсгийн “олон улсын байгууллагын төлөөлөл,” гэснийг, мөн зүйлийн 5 дахь хэсгийн “аймаг, дүүрэг,” гэснийг, 10 дахь хэсгийг тус тус хасаж, мөн зүйлийн 2 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“2.Хууль зүйн хорооны бүрэлдэхүүн дараах байгууллагын удирдах албан тушаалтнаас бүрдэнэ:

- 2.1.нутгийн өөрөө удирдах байгууллагын ажлын алба;
- 2.2.аймаг, дүүргийн хүүхэд, гэр бүлийн хөгжлийн газар, хэлтэс;
- 2.3.аймаг, дүүргийн боловсролын газар, хэлтэс;
- 2.4.аймгийн эрүүл мэндийн газар, дүүргийн нэгдсэн эмнэлэг, эрүүл мэндийн

төв;

2.5.аймаг, дүүргийн хөдөлмөр, нийгмийн халамжийн үйлчилгээний газар, хэлтэс;

2.6.гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн ажлын алба;

- 2.7.Засаг даргын ажлын албаны хуулийн асуудал хариуцсан нэгж;
- 2.8.аймаг, дүүрэг дэх цагдаагийн газар, хэлтэс;
- 2.9.аймаг, нийслэл, дүүрэг дэх шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, хэлтэс;

2.10.аймаг, дүүргийн прокурорын газар;

2.11.шүүхийн тамгын газар, эсхүл шүүгч зөвшөөрсөн тохиолдолд.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 5
Татгалзсан: 4
Бүгд: 9

55.6 хувийн саналаар дэмжигдлээ.

Хуулийн төслийн 2.12, 2.13, 2.14, 2.15, 2.16, 2.17, 2.18, 2.19 дүгээр зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт гараагүй болно.

Ж.Чинбүрэн: 12.Төслийн 2.12 дугаар зүйлийн 1.2 дахь заалтын “хүчирхийлэл үйлдсэн этгээдийг тогтоох зорилгоор хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа эхлэхээс өмнө” гэснийг хасаж, мөн зүйлийн 1.3 дахь заалтын “зөвлөгөө,” гэсний дараа “эрх зүйн туслалцаа, мэдээлэл өгөх,” гэж, мөн заалтын “саналаа хэлэх,” гэсний дараа “хүсэлт гаргах” гэж тус тус нэмж, мөн зүйлийн 1.7 дахь заалтын “газарт нь” гэснийг “газар, тусгай өрөөнд” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 5

Татгалзсан: 4

Бүгд: 9

55.6 хувийн саналаар дэмжигдлээ.

Хуулийн төслийн 3.1 дүгээр зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнх-Оргилын тавьсан асуултад ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Ц.Идэрбат хариулж, тайлбар хийв.

Ж.Чинбүрэн: 13.Төслийн 3.1 дүгээр зүйлийн 4 дэх хэсгийн “ашиглах,” гэсний дараа “хүүхдийг үл хайхрах,” гэж нэмж, мөн зүйлийн 8 дахь хэсгийг хасаж, мөн зүйлд доор дурдсан агуулгатай 8, 9 дэх хэсэг нэмэх:

“8.Хүүхдийн дэргэд согтууруулах ундаа хэрэглэсэн, эсхүл хэрэглэсэн үедээ орон байранд нэвтэрч хүүхдийг эрсдэлт нөхцөлд оруулсны улмаас гарсан хүүхэд хамгааллын үйлчилгээний зардлыг буруутай этгээдээр төлүүлэх арга хэмжээг хүүхдийн эрхийн улсын байцаагч авна.

9.Эцэг, эх хүүхдээ эрсдэлт нөхцөлд орж болзошгүй соёл, спортын үйл ажиллагаа, урлагийн тоглолтод оролцуулах тохиолдолд гэнэтийн ослын даатгалд даатгуулна.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 5

Татгалзсан: 4

Бүгд: 9

55.6 хувийн саналаар дэмжигдлээ.

Дээрх саналыг найруулгын засвартайгаар дэмжлээ.

Хуулийн төслийн 3.2 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт гараагүй болно.

14.Төслийн 3.2 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 2.7 дахь заалт, 9, 10,11 дэх хэсгийг тус тус нэмэх:

“2.7.хичээлийн жилийн турш хүүхэд эрсдэлт нөхцөлд байгаа эсэхийг үнэлэх, зөвлөгөө өгөх, хүүхэд бүрийн нийгэм, сэтгэл зүйн асуудлыг илрүүлэх, тандан судлах арга хэмжээг тогтмол авч хэрэгжүүлэх;

9.Боловсролын орчин дахь хүүхэд хамгааллын үйлчилгээний нийтлэг шаардлагыг хүүхэд, гэр бүлийн хөгжлийн болон боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран батална.

10.Боловсролын сургалтын байгууллага, насан туршийн суралцахуйн төвд суралцаж байгаа хүүхдийн эрх, хамгааллын нөхцөл байдлын тандалт судалгааг гурван жил тутам Боловсролын ерөнхий хуулийн 17.2-т заасан байгууллагаар хийлгүүлнэ.

11.Боловсролын ерөнхий хуулийн 40.2.8-д заасан эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн төлөөллийн байгууллага хүүхдийн эрх, хүүхэд хамгааллын төлөвлөгөөтэй байна.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 5
Татгалзсан: 4
Бүгд: 9
55.6 хувийн саналаар дэмжигдлээ.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнх-Оргилын тавьсан асуултад Боловсролын ерөнхий газрын дарга Т.Ням-Очир хариулж, тайлбар хийв.

15.Төслийн 3.2 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 2.11 дэх заалт, 4.5.2 дахь дэд заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“1.Боловсролын сургалтын байгууллага, насан туршийн суралцахуйн төв, сүм, хийд, шашны сургууль нь хүүхэд хамгааллын бодлого, түүнийг хэрэгжүүлэх төлөвлөгөөтэй байна.

2.12.хүүхэд тодорхойгүй шалтгаанаар хичээлдээ ирээгүй тохиолдолд гэр бүл, эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчид нэн даруй мэдэгдэх;

2.13.хүүхэд эрсдэлт нөхцөлд өртсөн талаар мэдсэн, таамагласан, илрүүлсэн бол харьяа хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал эрхэлсэн орон нутгийн байгууллага, хүүхэд, гэр бүлийн нийгмийн ажилтанд мэдэгдэх.

4.5.2.сэтгэл зүйн зөвлөгөө, үйлчилгээг үзүүлэх, хүүхдийн төлөвшилд нөлөөлөх сургалт, үйл ажиллагаанд эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн хамт хамруулах.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 5
Татгалзсан: 4
Бүгд: 9
55.6 хувийн саналаар дэмжигдлээ.

16.Төслийн 3.2 дугаар зүйлийн 4.5.1 дэх заалтын “сануулах” гэсний дараа “зөвлөгөө өгөх, хохирогч суралцагчаас уучлалт гуйлгуулах” гэж, мөн зүйлийн 5.5 дахь заалтын “эрсдэлт нөхцөлд” гэсний өмнө “боловсролын сургалтын байгууллага, насан туршийн суралцахуйн төвийн сургалтын хөтөлбөрт” гэж тус тус нэмж, мөн зүйлийн 4 дэх хэсгийн “Боловсролын сургалтын байгууллагын удирдлага, хүүхдийн эрх, хамгааллын үйлчилгээ үзүүлэх нэгж” гэснийг “Боловсролын сургалтын байгууллага, насан туршийн суралцахуйн төв” гэж, мөн хэсгийн “мэдээллийн мөрөөр нэн даруй хяналт шалгалт явуулж” гэснийг “мэдээллийг хүлээн авч,” гэж, мөн зүйлийн 4.5 дахь заалтын “суралцагчийг сургалт, сэтгэл

зүйн зөвлөгөө үйлчилгээнд хамруулах,” гэснийг “хүүхдийг” гэж, мөн зүйлийн 6 дахь хэсгийн “Шашны байгууллага /сургууль/-ын дэргэдэх” гэснийг “Боловсролын сургалтын байгууллага, сүм, хийдийн” гэж, 8 дахь хэсгийн “Шашны байгууллага /сургууль/-д суралцах хүүхэд, түүний гэр бүлд” гэснийг “Боловсролын сургалтын байгууллага, сүм, хийдийн орчны аюулгүй байдалд” гэж тус тус өөрчилж, мөн зүйлийн 4.4 дэх заалтын “, удаа дараа хүчирхийлэл, үе тэнгийн дээрэлхэлтэд өртсөн суралцагч, түүний эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн зөвшөөрснөөр өөр бүлэг, сургууль руу шилжүүлэх” гэснийг, мөн зүйлийн 4.5.3, 4.5.4 дэх дэд заалт, 4.6, 4.7, 5.1, 5.3, 5.6 дахь заалт, 9 дэх хэсгийг тус тус хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 5
Татгалзсан: 4
Бүгд: 9
55.6 хувийн саналаар дэмжигдлээ.

Хуулийн төслийн 3.3 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт гараагүй болно.

17.Төслийн 3.3 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн “байгууллага” гэсний дараа “эрсдэлд нөхцөлд байгаа” гэж нэмж, мөн зүйлийн 5.1, 5.3 дахь заалт, 6 дахь хэсгийг тус тус хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 5
Татгалзсан: 4
Бүгд: 9
55.6 хувийн саналаар дэмжигдлээ.

Хуулийн төслийн 3.4 зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнх-Оргилын тавьсан асуултад ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Ц.Идэрбат, Хөдөлмөр, нийгийн хамгааллын сайд Х.Бугантуяа, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Гэр бүлийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Н.Баярмаа, Цахим хөгжил, харилцаа холбооны яамны Хуулийн хэлтсийн дарга Л.Нямдорж нар хариулж, тайлбар хийв.

18.Төслийн 3.4 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн “мэдээ, мэдээлэл, зар сурталчилгаа” гэснийг “хүүхдэд хортой агуулга” гэж өөрчилж, мөн зүйлийн 3-11 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“3.Хүн, хуулийн этгээд хүүхдийг цахимаар урхидах, дээрэлхэх, дарамтлахыг хориглоно.

4.Хүн, хуулийн этгээд хүүхдийн нэр төр, алдар хүндийг гутаан доромжилсон, эсхүл хүүхдийн эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн зөвшөөрөлгүйгээр хүүхдийн зураг, дуу, дуу-дүрсний бичлэг агуулсан контент, мэдээ, мэдээлэл, бүтээлийг олон нийтэд түгээхийг хориглоно.

5.Хэвлэл мэдээлэл, өргөн нэвтрүүлэг, цахим орчны үйлчилгээ эрхлэгч өөрийн үйлчилгээнд хориотой агуулгыг түгээхгүй байх, хүүхдэд хортой агуулгыг хянах, хязгаарлах, хаах арга хэмжээ авах үүрэгтэй.

6.Интернэтийн үйлчилгээ эрхлэгч нь эрх бүхий байгууллагын дүгнэлт, шийдвэрийн дагуу цахим орчинд түгээсэн хүүхдэд хортой болон хориотой агуулгыг өөрийн сүлжээнд хязгаарлалт хийх технологийн арга хэмжээг авна.

7.Өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэгч контент, бүтээлийг олон нийтэд түгээхийн өмнө насны ангиллын тэмдэглэгээг байршуулна.

8.Олон суваг дамжуулах үйлчилгээ эрхлэгч хүүхдийг хориотой, хүүхдэд хортой агуулгаас хамгаалах зорилгоор насанд хүрэгчдэд зориулсан тохиргоог идэвхжүүлэх нөхцөлийг бүрдүүлсэн байна.

9.Олон суваг дамжуулах үйлчилгээ эрхлэгч Харилцаа холбооны зохицуулах хорооны мэдэгдэлд заасан хориотой, хүүхдэд хортой агуулгыг өөрийн үйлчилгээнд хязгаарлах, хаах үүрэгтэй.

10.Хүн, хуулийн этгээд хэвлэл мэдээлэл, өргөн нэвтрүүлэг, цахим орчинд хориотой агуулга түгээснээс хүүхдийн эрх зөрчигдсөн, зөрчигдөж болзошгүй гэж үзвэл гомдлоо хүүхдийн эрхийн улсын байцаагч, цагдаагийн байгууллагад гаргаж, шийдвэрлүүлнэ.

11.Цахим орчинд хүүхдийг хориотой болон хүүхдэд хортой агуулгаас урьдчилан сэргийлэх, хамгаалах журмыг цахим хөгжил, харилцаа холбооны, хүүхэд, гэр бүлийн хөгжлийн болон хууль, зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран батална.

12.Хэвлэл мэдээлэл, олон суваг дамжуулах болон цахим орчны үйлчилгээ эрхлэгчийн цахим орчин, өргөн нэвтрүүлгээр түгээсэн контент, мэдээ, мэдээлэл, бүтээл нь хүүхдэд хортой агуулгатай эсэх талаар дүгнэлт гаргах чиг үүрэг бүхий орон тооны бус зөвлөл ажиллана.

13.Энэ зүйлийн 12-г заасан орон тооны бус зөвлөлийн бүрэлдэхүүн, ажиллах журмыг Засгийн газар батална.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 4

Татгалзсан: 5

Бүгд: 9

44.4 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Б.Бейсенгийн “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Ж.Чинбүрэн: Улсын Их Хурлын гишүүн Б.Бейсенгийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 6

Татгалзсан: 3

Бүгд: 9

66.7 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Ж.Чинбүрэн: 18.Төслийн 3.4 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн “мэдээ, мэдээлэл, зар сурталчилгаа” гэснийг “хүүхдэд хортой агуулга” гэж өөрчилж, мөн зүйлийн 3-11 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“3.Хүн, хуулийн этгээд хүүхдийг цахимаар урхидах, дээрэлхэх, дарамтлахыг хориглоно.

4.Хүн, хуулийн этгээд хүүхдийн нэр төр, алдар хүндийг гутаан доромжилсон, эсхүл хүүхдийн эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн зөвшөөрөлгүйгээр хүүхдийн зураг, дуу, дуу-дүрсний бичлэг агуулсан контент, мэдээ, мэдээлэл, бүтээлийг олон нийтэд түгээхийг хориглоно.

5.Хэвлэл мэдээлэл, өргөн нэвтрүүлэг, цахим орчны үйлчилгээ эрхлэгч өөрийн үйлчилгээнд хориотой агуулгыг түгээхгүй байх, хүүхдэд хортой агуулгыг хянах, хязгаарлах, хаах арга хэмжээ авах үүрэгтэй.

6.Интернэтийн үйлчилгээ эрхлэгч нь эрх бүхий байгууллагын дүгнэлт, шийдвэрийн дагуу цахим орчинд түгээсэн хүүхдэд хортой болон хориотой агуулгыг өөрийн сүлжээнд хязгаарлалт хийх технологийн арга хэмжээг авна.

7.Өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэгч контент, бүтээлийг олон нийтэд түгээхийн өмнө насны ангиллын тэмдэглэгээг байршуулна.

8.Олон суваг дамжуулах үйлчилгээ эрхлэгч хүүхдийг хориотой, хүүхдэд хортой агуулгаас хамгаалах зорилгоор насанд хүрэгчдэд зориулсан тохиргоог идэвхжүүлэх нөхцөлийг бүрдүүлсэн байна.

9.Олон суваг дамжуулах үйлчилгээ эрхлэгч Харилцаа холбооны зохицуулах хорооны мэдэгдэлд заасан хориотой, хүүхдэд хортой агуулгыг өөрийн үйлчилгээнд хязгаарлах, хаах үүрэгтэй.

10.Хүн, хуулийн этгээд хэвлэл мэдээлэл, өргөн нэвтрүүлэг, цахим орчинд хориотой агуулга түгээснээс хүүхдийн эрх зөрчигдсөн, зөрчигдөж болзошгүй гэж үзвэл гомдлоо хүүхдийн эрхийн улсын байцаагч, цагдаагийн байгууллагад гаргаж, шийдвэрлүүлнэ.

11.Цахим орчинд хүүхдийг хориотой болон хүүхдэд хортой агуулгаас урьдчилан сэргийлэх, хамгаалах журмыг цахим хөгжил, харилцаа холбооны, хүүхэд, гэр бүлийн хөгжлийн болон хууль, зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран батална.

12.Хэвлэл мэдээлэл, олон суваг дамжуулах болон цахим орчны үйлчилгээ эрхлэгчийн цахим орчин, өргөн нэвтрүүлгээр түгээсэн контент, мэдээ, мэдээлэл, бүтээл нь хүүхдэд хортой агуулгатай эсэх талаар дүгнэлт гаргах чиг үүрэг бүхий орон тооны бус зөвлөл ажиллана.

13.Энэ зүйлийн 12-т заасан орон тооны бус зөвлөлийн бүрэлдэхүүн, ажиллах журмыг Засгийн газар батална.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулъя.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 3
Бүгд: 9
66.7 хувийн саналаар дэмжигдлээ.

19.Төслийн 3.4 дүгээр зүйлд доор дурдсан агуулгатай дараах тайлбар хэсэг нэмэх:

“Тайлбар:Энэ зүйлд заасан “цахим орчны үйлчилгээ эрхлэгч” гэж цахим хуудас, цахим хэрэглүүр /аппликэйшн/, платформ, цахим орчин ашиглаж контент, бүтээлийг олон нийтэд хүргэх үйлчилгээ үзүүлэгч этгээдийг ойлгоно.

Энэ зүйлд заасан “цахимаар урхидах” гэж хүүхдийг гэмт хэрэг, зөрчилд уруу татах зорилгоор цахим сүлжээ ашиглан хүүхэдтэй харилцаа тогтоохыг хэлнэ.

Энэ зүйлд заасан “цахимаар дээрэлхэх” гэж цахим орчинд хүүхдийг дээрэлхэж, гадуурхсан, айлган сүрдүүлсэн, доромжилсон зүй бус агуулга бүхий мэдээ, мэдээллийг өөрт нь болон бусдад түгээхийг хэлнэ.

Энэ зүйлд заасан “цахимаар дарамтлах” гэж хүүхдийг тодорхой үйлдэл хийх, хийхгүй байхыг шаардаж өөрт нь, түүний ойр дотны хүний эрх, хууль ёсны ашиг сонирхолд нь хохирол учруулж болохуйц баримт, мэдээлэл тараахаар цахим сүлжээнд сүрдүүлэхийг хэлнэ гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 3
Бүгд: 9
66.7 хувийн саналаар дэмжигдлээ.

Хуулийн төслийн 3.5 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт гараагүй болно.

20.Төслийн 3.5 дугаар зүйлийн 2, 6 дахь хэсгийг тус тус хасаж, мөн зүйлд доор дурдсан агуулгатай 5 дахь хэсгийг нэмэх:

“5.Сум, дүүргийн Засаг дарга, хүүхдийн эрхийн улсын байцаагч худалдаа, үйлчилгээний газар, боловсролын сургалтын байгууллагаас гадуурх сургалтын ажил эрхэлдэг иргэн, хуулийн этгээдийн үйл ажиллагаанд хүүхдийн эрх зөрчигдөж байгаа эсэхэд хяналт тавьж, хүүхдийг эрсдэлт нөхцөлд оруулсан бол уг үйл ажиллагааг хязгаарлах, зогсоох арга хэмжээ авна.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 5
Татгалзсан: 4
Бүгд: 9
55.6 хувийн саналаар дэмжигдлээ.

Хуулийн төслийн 3.6 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнх-Оргилын тавьсан асуултад ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Ц.Идэрбат, Хуулийн зөвлөх, өмгөөлөгч П.Баттулга нар хариулж, тайлбар хийв.

21.Төслийн 3.6 дугаар зүйлийн 9, 10 дахь хэсгийг хасаж, мөн зүйлийн 2 дахь хэсгийн “оролцуулахдаа” гэсний дараа “хүүхдийн амь нас, эрүүл мэнд, аюулгүй байдлыг хангах,” гэж, мөн зүйлийн 4 дэх хэсгийн “дасгалжуулагч,” гэсний дараа “зохион байгуулагч” гэж тус тус нэмж, мөн зүйлийн 5.2 дахь заалтын “хамруулж, өсөлт, хөгжлийн талаар дүгнэлт гаргуулах” гэснийг “хамруулах” гэж өөрчлөн мөн зүйлд доор дурдсан агуулгатай 5, 6 дахь хэсэг, тайлбар хэсгийг тус тус нэмэх:

“5.Хүүхдийг оршин суугаа газраас өөр газарт 24 цагаас дээш хугацаагаар соёл, спортын үйл ажиллагаа, урлагийн тоглолт, спортын тэмцээн, бусад арга хэмжээнд оролцуулахад 15 хүртэлх хүүхэд тутамд нэг багш, дасгалжуулагч ажиллаж, хүүхдийн аюулгүй байдлыг хангана.

6.Үндэсний их баяр наадмын тухай хуульд зааснаас бусад хурдан морины уралдааныг зохион байгуулах тохиолдолд зохион байгуулагч нь хурдан морины уралдааны бэлтгэлийн үе эхлэхээс өмнө харьяа сум, дүүргийн Засаг даргад мэдэгдэж, бүртгүүлнэ.

Тайлбар:Энэ зүйлд заасан “уяач” гэдгийг хурдан морины уралдаанд уралдаж байгаа морины өмчлөгчийг ойлгоно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 6

Татгалзсан: 3

Бүгд: 9

66.7 хувийн саналаар дэмжигдлээ.

Хуулийн төслийн 3.7 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнх-Оргилын тавьсан асуултад Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Гэр бүлийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Н.Баярмаа хариулж, тайлбар хийв.

22.Төслийн 3.7 дугаар зүйлийн гарчгийн “онцгой нөхцөл байдлын нөхцөлд байгаа” гэснийг “гамшгийн онцгой нөхцөл байдлын” гэж, мөн зүйлийн “онцгой” гэснийг “гамшгийн онцгой нөхцөл” гэж тохиолдол бүрд өөрчилж, мөн зүйлийн 5, 6, 7 дахь хэсгийг тус тус хасаж, мөн зүйлд доор дурдсан агуулгатай 6 дахь хэсэг нэмэх:

“6.Гамшиг, гамшгийн онцгой нөхцөл байдлын үед хүүхдийг насанд хүрсэн хүнд харгалзуулалгүйгээр орхих, хүүхдийн амь нас, эрүүл мэнд, аюулгүй байдлыг хангахаас бусад тохиолдолд хүүхдийг байгаа газраас нь авч явах, тээвэрлэхийг хориглоно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 6

Татгалзсан: 3

Бүгд: 9

66.7 хувийн саналаар дэмжигдлээ.

Хуулийн төслийн 3.8 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнх-Оргилын тавьсан асуултад Хуулийн зөвлөх, өмгөөлөгч П.Баттулга дарга П.Баттулга нар хариулж, тайлбар хийв.

23.Төслийн 3.8 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн “нас,” гэсний дараа “хүйс,” гэж нэмж, мөн хэсгийн “таатай орчинд” гэснийг “тусгай өрөөнд” гэж өөрчилж, мөн зүйлийн 7 дахь хэсгийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 5

Татгалзсан: 4

Бүгд: 9

55.6 хувийн саналаар дэмжигдлээ.

Хуулийн төслийн 4.1, 4.2, 4.3, 4.4, 4.5, 4.6, 4.7, 4.8, 4.9, 4.10, 4.11, 4.12, 4.13, 4.14, 4.15, 4.16, 5.1, 5.2, 5.3 дугаар зүйлүүдтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт гараагүй болно.

24.Төслийн “ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ” гэснийг “ХОЁРДУГААР БҮЛЭГ” гэж өөрчилж, 4.1 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 2
Бүгд: 9
77.8 хувийн саналаар дэмжигдлээ.

25.Төслийн 4.2 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн “30.1.1, 30.1.3” гэснийг “30.1” гэж өөрчилж, мөн зүйлийн 4 дэх хэсгийн “нөхцөл байдалд ороогүй” гэсний дараа “ нь аюулын зэргийн болон эрсдэлийн үнэлгээгээр тогтоогдсон” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 5
Татгалзсан: 4
Бүгд: 9
55.6 хувийн саналаар дэмжигдлээ.

26.Төслийн 4.4 дүгээр зүйлийн 4 дэх хэсгийн “хүүхдийг гэр бүлээс нь түр тусгаарлах” гэснийг “Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 30.1-д” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 3
Бүгд: 9
66.7 хувийн саналаар дэмжигдлээ.

27.Төслийн 4.7 дугаар зүйлийн 5 дахь хэсгийн “гэрээ байгуулж болохгүй хүн болох нь хожим илэрсэн,” гэснийг “гэрээг цуцлах үндэслэл” гэж, мөн хэсгийн “цуцалж, хүүхдийг буцаан авна” гэснийг “цуцална” гэж, мөн зүйлийн 6 дахь хэсгийн “цуцалж, хүүхдийг буцаан өгч” гэснийг “цуцалж” гэж тус тус өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 3
Бүгд: 9
66.7 хувийн саналаар дэмжигдлээ.

28.Төслийн 4.9 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн “орон нутгийн байгууллага,” гэсний дараа “хамтарсан баг” гэж нэмж, мөн хэсгийн “кейс менежмент” гэснийг “тохиолдлын зохицуулалт” гэж, “кейс” гэснийг “тохиолдол” гэж тохиолдол бүрд өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 3
Бүгд: 9

66.7 хувийн саналаар дэмжигдлээ.

Хуулийн төслийн 6.1 дүгээр зүйлтэй холбогдуулан ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Ц.Идэрбат, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Гэр бүлийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Н.Баярмаа нар үг хэлэв.

29.Төслийн 6.1 дүгээр зүйлд доор дурдсан агуулгатай 6 дахь хэсэг нэмэх:

“6.Засгийн газрын гишүүн бүр эрхлэх асуудлын хүрээнд салбарын хүүхэд хамгааллын үйлчилгээ, хүүхэд хамгааллын бодлогыг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлыг жил бүрийн төсөвтөө тусгуулах арга хэмжээ авна.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 6

Татгалзсан: 3

Бүгд: 9

66.7 хувийн саналаар дэмжигдлээ.

Хуулийн төслийн 6.2, 6.3, 7.1, 7.2, 7.3, 7.4 дүгээр зүйлүүдтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт гараагүй болно.

30.Төслийн 6.3 дугаар зүйлийн 1 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“1.Хүүхэд хамгааллын хууль тогтоомжийн хэрэгжилтэд дараах журмаар хяналт тавина:

1.1.аймаг, нийслэлийн Засаг дарга харьяалах нутаг дэвсгэрийн хэмжээнд, төрийн захиргааны төв болон нутгийн захиргааны байгууллага өөрийн хариуцсан салбарын хүрээнд хүүхдийн эрх, хүүхэд хамгааллын чиглэлээр тухайн жилд гүйцэтгэсэн ажлын тайланг дараа оны 2 дугаар сард багтаан хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад хүргүүлэх;

1.2.хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага энэ зүйлийн 1-д заасны дагуу ирүүлсэн тайланд дүн шинжилгээ хийж, жил бүрийн 3 дугаар сард багтаан Хүүхдийн төлөө үндэсний зөвлөлөөр хэлэлцүүлэх;

1.3.Хүүхдийн төлөө үндэсний зөвлөл шаардлагатай тохиолдолд Засгийн газрын гишүүн, аймаг, нийслэлийн Засаг дарга, холбогдох төрийн байгууллагад чиглэл өгч, хэрэгжилтийг хангуулах.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 6

Татгалзсан: 3

Бүгд: 9

66.7 хувийн саналаар дэмжигдлээ.

31.Төслийн 7.4 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“1.Энэ хуулийг 2024 оны 09 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 6

Татгалзсан: 3
Бүгд: 9
66.7 хувийн саналаар дэмжигдлээ.

НАЙРУУЛГЫН САНАЛ

Ж.Чинбүрэн: 1.Төслийн 3.4 дүгээр зүйлийн гарчгийн “мэдээлэл,” гэсний дараа “өргөн нэвтрүүлэг,” гэж нэмэх.

2.Төслийн 1.4 дүгээр зүйлийн 1.11 дэх заалтын “тодорхой” гэснийг “гэрээнд заасан” гэж, 2.9 дүгээр зүйлийн 1.3 дахь заалтын “жил бүрийн 4 дүгээр улиралд багтаан” гэснийг “жилд хоёроос доошгүй удаа” гэж, 3.2 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн “Боловсролын сургалтын байгууллагын хүүхдийн эрх, хамгааллын үйлчилгээ үзүүлэх нэгж нь хүүхэд сургалтын” гэснийг “Энэ зүйлийн 1-д заасан байгууллагын” гэж, мөн зүйлийн 2.3 дахь заалтын “хайрцаг байрлуулах” гэснийг “нээлтэй суваг ажиллуулах” гэж, мөн зүйлийн 5.5 дахь заалтын “агуулгыг бүх шатны боловсролын байгууллагын багш бэлтгэх, давтан сургах сургалтын хөтөлбөрт тусгаж,” гэснийг “агуулга туссан эсэхэд” гэж, 3.6 дугаар зүйлийн 7 дахь хэсгийн “дүүргийн” гэснийг “баг, дүүрэг, хорооны” гэж өөрчилж, 7.3 дугаар зүйлийн гарчгийн “Шилжилтийн үеийн” гэснийг “Хууль дагаж мөрдөх журмын гэж тус тус өөрчлөх.

3.Төслийн 2.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн “хууль тогтоомж” гэснийг, мөн зүйлийн тайлбар хэсгийн “тухайн хуулийн этгээдийн ажилтны болон үйлчлүүлж байгаа” гэснийг, 2.2 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн “хувийн эрх зүйн” гэснийг, мөн зүйлийн 1.4 дэх заалтын “тогтмол хугацаанд” гэснийг, 4.3 дугаар зүйлийн 2.4 дэх заалтын “хөгжлийн, амьдрах ухааны” гэснийг, мөн заалтын “тохиромжтой үйл ажиллагаанд” гэснийг тус тус хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 4
Татгалзсан: 5
Бүгд: 9
44.4 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Б.Бейсенгийн “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Ж.Чинбүрэн: Улсын Их Хурлын гишүүн Б.Бейсенгийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 5
Татгалзсан: 4
Бүгд: 9
55.6 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Ж.Чинбүрэн: 1.Төслийн 3.4 дүгээр зүйлийн гарчгийн “мэдээлэл,” гэсний дараа “өргөн нэвтрүүлэг,” гэж нэмэх.

2.Төслийн 1.4 дүгээр зүйлийн 1.11 дэх заалтын “тодорхой” гэснийг “гэрээнд заасан” гэж, 2.9 дүгээр зүйлийн 1.3 дахь заалтын “жил бүрийн 4 дүгээр улиралд багтаан” гэснийг “жилд хоёроос доошгүй удаа” гэж, 3.2 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн “Боловсролын сургалтын байгууллагын хүүхдийн эрх, хамгааллын үйлчилгээ үзүүлэх нэгж нь хүүхэд

сургалтын” гэснийг “Энэ зүйлийн 1-д заасан байгууллагын” гэж, мөн зүйлийн 2.3 дахь заалтын “хайрцаг байрлуулах” гэснийг “нээлттэй суваг ажиллуулах” гэж, мөн зүйлийн 5.5 дахь заалтын “агуулгыг бүх шатны боловсролын байгууллагын багш бэлтгэх, давтан сургах сургалтын хөтөлбөрт тусгаж,” гэснийг “агуулга туссан эсэхэд” гэж, 3.6 дугаар зүйлийн 7 дахь хэсгийн “дүүргийн” гэснийг “баг, дүүрэг, хорооны” гэж өөрчилж, 7.3 дугаар зүйлийн гарчгийн “Шилжилтийн үеийн” гэснийг “Хууль дагаж мөрдөх журмын гэж тус тус өөрчлөх.

3.Төслийн 2.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн “хууль тогтоомж” гэснийг, мөн зүйлийн тайлбар хэсгийн “тухайн хуулийн этгээдийн ажилтны болон үйлчлүүлж байгаа” гэснийг, 2.2 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн “хувийн эрх зүйн” гэснийг, мөн зүйлийн 1.4 дэх заалтын “тогтмол хугацаанд” гэснийг, 4.3 дугаар зүйлийн 2.4 дэх заалтын “хөгжлийн, амьдрах ухааны” гэснийг, мөн заалтын “тохиромжтой үйл ажиллагаанд” гэснийг тус тус хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулъя.

Зөвшөөрсөн:	5
Татгалзсан:	4
Бүгд:	9

55.6 хувийн саналаар дэмжигдлээ.

Хүүхэд хамгааллын тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дуусав.

Хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд:

Нэг.Хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийн талаар:

Хуулийн төслийн 1, 2 дугаар зүйлүүдтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт гараагүй болно.

Хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дуусав.

Хоёр.Хүүхдийн эрхийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Хуулийн төслийн 1, 2, 3, 4, 5 дугаар зүйлүүдтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт гараагүй болно.

Ж.Чинбүрэн: 1.Төслийн 1 дүгээр зүйлийн 7 дахь заалтын 20.8 дахь хэсгийн “хяналт шалгалт хийхдээ Төрийн хяналт шалгалтын тухай хуулийг баримтлах” гэснийг “хүүхэд аюултай нөхцөл байдалд орсон, орсон байж болзошгүй тохиолдолд хяналт шалгалт явуулах аж ахуйн нэгж, байгууллага, барилга байгууламж, ажлын байр, орон байранд урьдчилан мэдэгдэхгүйгээр чөлөөтэй нэвтрэх эрхтэй” гэж өөрчилж, мөн зүйлийн 7 дахь заалтад доор дурдсан агуулгатай 20.9 дэх хэсэг нэмэх:

“20.9.Хүүхдийн эрхийн улсын байцаагчийн ажиллах дүрмийг Засгийн газар батална.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	6
Татгалзсан:	3
Бүгд:	9

66.7 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Төслийн 1 дүгээр зүйлд доор дурдсан агуулгатай 8 дахь заалт нэмэх:

8/20¹ дугаар зүйл:

“20¹ дугаар зүйл.Хүүхдийн эрхийн олон нийтийн байцаагч

20¹.1.Сум, дүүргийн Засаг дарга баг, хороо бүрд хүүхдийн эрхийн олон нийтийн байцаагч ажиллуулж болно.

20¹.2.Хүүхдийн эрхийн олон нийтийн байцаагч тухайн сум, хорооны байнгын оршин суугч байна.

20¹.3.Сум, дүүргийн Засаг даргын захирамжийг үндэслэн Тамгын газрын дарга хүүхдийн эрхийн олон нийтийн байцаагчтай гэрээ байгуулах бөгөөд гэрээнд талуудын эрх, үүрэг, хариуцлага, ажил тайлагнах журам, урамшуулал, гэрээ цуцлах үндэслэлийг тусгана.

20¹.4.Хүүхдийн эрхийн олон нийтийн байцаагчтай байгуулсан гэрээг ажлын үр дүнг харгалзан жил бүр сунгана.

20¹.5.Хүүхдийн эрхийн олон нийтийн байцаагч дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

20¹.5.1.эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдийг илрүүлэх, мэдээлэх;

20¹.5.2.хүүхэд эрхээ хэрэгжүүлэхэд нь зөвлөгөө өгөх, туслалцаа үзүүлэх;

20¹.5.3.хүүхдийн сайн сайхан байдлыг хангахад чиглэсэн санал, санаачилга гаргаж хэрэгжүүлэх;

20¹.5.4.хүүхдийн эрх зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх, гарсан зөрчлийг арилгуулах арга хэмжээ авах;

20¹.5.5.хүүхдийн эрхийн зөрчлийн талаар эрх бүхий этгээдэд мэдэгдэж, шийдвэрлүүлэх.

20¹.6.Хүүхдийн эрхийн олон нийтийн байцаагч чиг үүргээ хэрэгжүүлэхдээ хамтарсан баг, хүүхэд, гэр бүлийн нийгмийн ажилтантай хамтран ажиллана.

20¹.7.Хүүхдийн эрхийн олон нийтийн байцаагч нь ажлын улирал тутмын төлөвлөгөөг сум, дүүргийн Засаг даргаар батлуулна.

20¹.8.Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан орон нутгийн байгууллага хүүхдийн эрхийн олон нийтийн байцаагчийг чадавхжуулах сургалтыг зохион байгуулна.

20¹.9.Хүүхдийн эрхийн олон нийтийн байцаагч сум, дүүргийн Засаг даргаас олгосон албаны үнэмлэхтэй байна. Албаны үнэмлэхийн загварыг хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага батална.

20¹.10.Сум, дүүргийн Засаг дарга хүүхдийн эрхийн олон нийтийн байцаагчид олгох урамшууллын зардлыг орон нутгийн төсвийн төсөлд тусгаж, тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар батлуулж, үр дүнг тайлагнана.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 3
Бүгд: 9
66.7 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Төслийн 4 дүгээр зүйлийн “15 дугаар зүйлийн 15.1.9 дэх заалтын дугаарлалтыг “15.1.10” гэж,” гэснийг хасаж, мөн зүйлийн ““20.5, 20.6, 20.7” дахь хэсгийн дугаарлалтыг “20.9, 20.10, 20.11”” гэснийг “20.5 дахь хэсгийн дугаарыг “20.9” гэж, 20.7 дахь хэсгийн дугаарыг “20.11” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 3
Бүгд: 9
66.7 хувийн саналаар дэмжигдлээ.

4.Төсөлд доор дурдсан агуулгатай 5 дугаар зүйл нэмэх:

“5 дугаар зүйл.Хүүхдийн эрхийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.6 дахь хэсгийг хүчингүй болсонд тооцсугай.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 3
Бүгд: 9
66.7 хувийн саналаар дэмжигдлээ.

Хүүхдийн эрхийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дуусав.

Гурав.Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Төслийн 1, 2, 3, 4 дүгээр зүйлүүдтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Ж.Чинбүрэн: 1.Төслийн 1 дүгээр зүйлд доор дурдсан агуулгатай 2, 3 дахь заалт нэмэх:

“2/30 дугаар зүйлийн 30.11 дэх хэсэг:

“30.11.Хүүхдийн түр хамгаалан байрлуулах үйлчилгээг төрөлжүүлэн зохион байгуулж болно.”

3/35 дугаар зүйлийн 35.2 дахь хэсгийн 2 дахь өгүүлбэр:

“Төрийн байгууллагын харьяанд байгуулсан түр хамгаалах байрны урсгал зардал, түр хамгаалан байрлуулж энэ хуульд заасан үйлчилгээ үзүүлэх зардлыг тухайн байгууллага хариуцна.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 3

Бүгд: 9
66.7 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Төслийн 2 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 1, 2 дахь заалт нэмэх:

1/18 дугаар зүйлийн 18.1.2 дахь заалт:

“18.1.2.Засаг даргын өргөн мэдүүлснээр харьяалах нутаг дэвсгэртээ хэрэгжүүлэх гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх үйл ажиллагааны зардал, нэг цэгийн үйлчилгээний төв, түр хамгаалах байрны урсгал зардал, хамтарсан багийн үйл ажиллагааны зардал, хохирогчид үйлчилгээ үзүүлэхтэй холбоотой зардлыг тухайн орон нутгийн төсөвт тусган батлах, гүйцэтгэлийн тайланг хэлэлцэх;”

2/19 дүгээр зүйлийн 19.1.5 дахь заалт:

“19.1.5.тухайн шатны жилийн төсвийн төсөлд нэг цэгийн үйлчилгээний төв, түр хамгаалах байрны урсгал зардал, хамтарсан багийн үйл ажиллагааны зардал, хохирогчид үйлчилгээ үзүүлэхтэй холбоотой зардлыг тусгаж иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн мэдүүлэх, гүйцэтгэлийг тайлагнах;” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 3
Бүгд: 9
66.7 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Төслийн 2 дугаар зүйлийн 20.1 дэх хэсгийн “сургуулийн,” гэсний дараа “нийгмийн” гэж, мөн хэсгийн “тухайн сум,” гэсний дараа “баг,” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 3
Бүгд: 9
66.7 хувийн саналаар дэмжигдлээ.

4.Төслийн 3 дугаар зүйлийн “хуулийн” гэсний дараа “5 дугаар зүйлийн 5.1.4 дэх заалтын “гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх хамтарсан баг” цаашид “хамтарсан баг” гэх/” гэснийг “хамтарсан баг” гэж,” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 3
Бүгд: 9
66.7 хувийн саналаар дэмжигдлээ.

5.Төслийн 4 дүгээр зүйлийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 5
Татгалзсан: 4
Бүгд: 9
55.6 хувийн саналаар дэмжигдлээ.

Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай

хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дуусав.

Дөрөв.Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт гараагүй болно.

Ж.Чинбүрэн: 1.Төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалтын 5.2.5 дахь заалтын “байгуулах” гэснийг “байгуулж, ажиллах журмыг батлах” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 3
Бүгд: 9
66.7 хувийн саналаар дэмжигдлээ.

Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дуусав.

Тав.Нийгмийн халамжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Төслийн 1, 2, 3, 4, 5 дугаар зүйлүүдтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Ж.Чинбүрэн: 1.Төслийн 1 дүгээр зүйлийн 19¹.2 дахь хэсгийн “хувь хүн,” гэснийг хасаж, мөн зүйлд доор дурдсан агуулгатай 2 дахь заалт нэмэх:

“2/13 дугаар зүйлийн 13.13, 13.14 дэх хэсэг:

13.13.Нийгмийн халамжийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага дараах тохиолдолд хүүхдийн тэтгэмжийг эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчид олгохыг түдгэлзүүлэх шийдвэр гаргана:

13.13.1.эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч нь сураггүй алга болсон;

13.13.2.эцэг, эх нь хүүхдээ асран хамгаалах, тэжээн тэтгэх үүргээ биелүүлээгүй, эсхүл эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч нь хүүхдийн эрхийг зөрчсөн талаар аймаг, дүүргийн хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан байгууллага, хүүхдийн эрхийн улсын байцаагчийн дүгнэлт гарсан, хүүхдийн эсрэг гэмт хэрэг үйлдсэн нь тогтоогдсон.

13.14.Энэ хуулийн 13.1.6-д заасан хүүхдийн мөнгөн тэтгэмжийг зээл, өр төлбөрт суутгахыг хориглоно гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 6

Татгалзсан: 3
Бүгд: 9
66.7 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Төслийн 4 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулж, 3 дугаар зүйл болгох:

“3 дугаар зүйл.Нийгмийн халамжийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.9 дэх заалтын, 19 дүгээр зүйлийн 19.1.3, 19.2.3 дахь заалтын “хүнд нөхцөлд” гэснийг “эрсдэлт нөхцөлд” гэж, 13 дугаар зүйлийн 13.13 дахь хэсгийн дугаарыг “13.15” гэж тус тус өөрчилсүгэй.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 3
Бүгд: 9
66.7 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Төслийн 5 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулж, 4 дүгээр зүйл болгох:

“4 дүгээр зүйл.Энэ хуулийг 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 3
Бүгд: 9
66.7 хувийн саналаар дэмжигдлээ.

Нийгмийн халамжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дуусав.

Зургаа.Гэр бүлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Ж.Чинбүрэн: 1.Төслийг хууль санаачлагчид нь буцаах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 4
Татгалзсан: 5
Бүгд: 9
44.4 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Х.Булгантуяагийн “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Ж.Чинбүрэн: Улсын Их Хурлын гишүүн Х.Булгантуяагийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 3
Бүгд: 9
66.7 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Ж.Чинбүрэн: Төслийг хууль санаачлагчид нь буцаах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулъя.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 3
Бүгд: 9
66.7 хувийн саналаар дэмжигдлээ.

Гэр бүлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дуусав.

Долоо.Эрүүл мэндийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт гараагүй болно.

Ж.Чинбүрэн: 1.Төслийн 1 дүгээр зүйлийн “сурагчдад” гэсний өмнө “оюутан,” гэж, мөн зүйлийн “хүүхдэд” гэсний өмнө “дээд боловсролын сургалтын байгууллагын суралцагч, эрсдэлт нөхцөлд байгаа” гэж тус тус нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 4
Татгалзсан: 5
Бүгд: 9
44.4 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Б.Баярсайханы “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Ж.Чинбүрэн: Улсын Их Хурлын гишүүн Б.Баярсайханы гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 3
Бүгд: 9
66.7 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Ж.Чинбүрэн: Төслийн 1 дүгээр зүйлийн “сурагчдад” гэсний өмнө “оюутан,” гэж, мөн зүйлийн “хүүхдэд” гэсний өмнө “дээд боловсролын сургалтын байгууллагын суралцагч, эрсдэлт нөхцөлд байгаа” гэж тус тус нэмэх гэсэн санал хураалтыг дахин явуулъя.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 3

Бүгд: 9
66.7 хувийн саналаар дэмжигдлээ.

Эрүүл мэндийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дуусав.

Найм.Хууль зүйн туслалцааны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт гараагүй болно.

Хууль зүйн туслалцааны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дуусав.

Ес.Гамшгаас хамгаалах тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Хуулийн төслийн 1, 2 дугаар зүйлүүдтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт гараагүй болно.

Гамшгаас хамгаалах тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дуусав.

Арав.Онц байдлын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт гараагүй болно.

Ж.Чинбүрэн: 1.Төслийг хууль санаачлагчид нь буцаах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 3
Бүгд: 9
66.7 хувийн саналаар дэмжигдлээ.

Онц байдлын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дуусав.

Арваннэг.Төрийн хэмнэлтийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Хуулийн төслийн 1, 2, 3 дугаар зүйлүүдтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт гараагүй болно.

Ж.Чинбүрэн: 1.Төслийн гарчгийн “, ӨӨРЧЛӨЛТ” гэснийг “ОРУУЛАХ” гэж өөрчилж, 2 дугаар зүйлийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 3

Бүгд: 9
66.7 хувийн саналаар дэмжигдлээ.

Төрийн хэмнэлтийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дуусав.

Арванхоёр.Иргэний улсын бүртгэлийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Ж.Чинбүрэн: 1.Төслийг хууль санаачлагчид нь буцаах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 3
Бүгд: 9
66.7 хувийн саналаар дэмжигдлээ.

Иргэний улсын бүртгэлийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дуусав.

Арвангурав.Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Төслийн 1, 2 дугаар зүйлүүдтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт гараагүй болно.

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дуусав.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ц.Идэрбат Улсын Их Хурлын чуулганы хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 14 цаг 50 минутад хэлэлцэж дуусав.

Гурав.Байнгын хорооны тогтоолын төсөл /Хянан шалгах түр хорооны ажиллах хугацааг сунгах тухай/

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Нийгмийн бодлогын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Б.Цогзолбаяр, референт Г.Нямсүрэн нар байлцав.

Түр хорооны дарга Ж.Чинбүрэн тогтоолын төслийн талаар танилцуулав.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Ж.Чинбүрэн: “Хянан шалгах түр хорооны ажиллах хугацааг сунгах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 5
Татгалзсан: 4
Бүгд: 9

55.6 хувийн саналаар Байнгын хорооны тогтоол батлагдлаа.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ж.Чинбүрэн Улсын Их Хурлын чуулганы хуралдаанд танилцуулахаар тогтов.

Байнгын хорооны хуралдаанаар 3 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 4 цаг 27 минут үргэлжилж, 17 гишүүнээс 12 гишүүн хүрэлцэн ирж, 70.6 хувийн ирцтэйгээр 14 цаг 54 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:
НИЙГМИЙН БОДЛОГЫН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА

П.АНУЖИН

Тэмдэглэл хөтөлсөн:
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ ХӨТЛӨХ
АЛБАНЫ ШИНЖЭЭЧ

П.МЯДАГМАА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

Мягмар гараг Төрийн ордон “Жанжин Д.Сүхбаатар” танхим 10 цаг 27 минут

**БАЙНГЫН ХОРООНЫ
ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ
ТЭМДЭГЛЭЛ**

Ж.Чинбүрэн: Байнгын хорооны гишүүдийн олонх хүрэлцэн ирж Байнгын хорооны ирц 52.9 хувьтай бүрдсэн тул Нийгмийн бодлогын байнгын хорооны 2023 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн хуралдаанаа нээснийг мэдэгдье. Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн дагуу хуралдаанд хүрэлцэн ирсэн болон ирээгүй гишүүдийг танилцуулна аа.

Анужин гишүүн өвчтэй 28 дугаар тойрог, Баярсайхан гишүүн 9 дүгээр тойрог ирсэн, Батлут гишүүн томилолттой 20 дугаар тойрог, Бейсен гишүүн ирж байгаа гэсэн. Алга байна. Булгантуяа гишүүн ирсэн байна 23 дугаар тойрог, Ганбаатар гишүүн 20 дугаар тойрог ирээгүй байна, Жаргалмаа гишүүн 27 дугаар тойрог ирсэн байна, Мөнх-Оргил гишүүн 24 дүгээр тойрог ирж байгаа, Оюунчимэг гишүүн 25 дугаар тойрог ирсэн байгаа. Бүртгэлд тэгэхдээ ороогүй байна шүү. Сандаг-Очир гишүүн 21 дүгээр тойрог ирсэн байна, Сарангэрэл гишүүн 29 дүгээр тойрог ирж байгаа, Саранчимэг гишүүн 22 дугаар тойрог ирж байгаа гэсэн байна. Одонтуяа гишүүн 26 дугаар тойрог ирсэн байна. Туваан гишүүн 14 дүгээр тойрог ирсэн байна. Чинбүрэн 23 дугаар тойрог ирсэн байна. Чинзориг гишүүн 10 дугаар тойрог ирсэн байна. Идэрбат гишүүн 18 дугаар тойрог ирсэн байна.

Ирц танилцууллаа.

Байнгын хорооны хэлэлцэх асуудлыг танилцуулъя. 3 асуудал байгаа.

Эхний асуудал Нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн бусад хуулийн төсөл. Эцсийн хэлэлцүүлэг, Засгийн газраас 2023 оны 6 сарын 28-ны өдөр өргөн мэдүүлсэн,

Хоёр дахь асуудал. Хүүхэд хамгааллын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл, анхны хэлэлцүүлэг. Засгийн газраар 2023 оны 10 сарын 13-ны өдөр өргөн мэдүүлсэн.

Гурав дахь асуудал. Эмийн үнийн өсөлтийн шалтгаан нөхцөлийг хянан шалгах түр хорооны ажиллах хугацааг сунгах тухай Улсын Их Хурлын тогтоолын төсөл. Ингээд 3 асуудал хэлэлцэнэ ээ.

Хэлэлцэх асуудлаар саналтай гишүүн байна уу? Саналтай гишүүн байвал саналаа өгнө үү. Хэлэлцэх асуудал дээр.

Саналтай гишүүд алга байна. Хэлэлцэх асуудалдаа орё.

Эхний асуудал хэлэлцэхтэй холбоотойгоор Нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн бусад хуулийн төслийн хэлэлцэх хэлэлцүүлгийг хийнэ. Ажлын хэсгээ танилцуулъя.

Нэрсүүд нь хаана байна. Ажлын хэсгийн гишүүд орж ирсэн байна танилцуулъя. Баярболд Эрүүл мэндийн яамны Нийтийн эрүүл мэндийн газрын дарга, Ганхуяг Эрүүл мэндийн яамны Халдварт бус өвчний хэлтсийн дарга Өнөрсайхан НЭМҮТ-ийн захирал, Баяртулга Эрүүл мэндийн яамны Нийтийн эрүүл мэндийн газрын мэргэжилтэн, Цэрэнчунт Эрүүл мэндийн яамны Төрийн захиргаа, удирдлагын газрын мэргэжилтэн, Нинж Эрүүл мэндийн яамны Бодлого төлөвлөлтийн газрын ахлах шинжээч. Ажлын дэд хэсэг. Ажлын хэсэг бүрэн бүрэлдэхүүнтэй иржээ. Эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх танилцуулгыг уншиж танилцуулъя.

Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2023 оны 6 дугаар сарын 28-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг чуулганы нэгдсэн хуралдааны 2023 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн хуралдаанаар явуулсан билээ.

Нэгдсэн хуралдаанаар төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулах үед ажлын хэсгээс бэлтгэсэн зарчмын 51, найруулгын 3 багц хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн талаарх 10 санал тус бүрээр санал хурааж шийдвэрлэсэн бөгөөд 2 зарчмын санал дээр хуралдаан даргалагчаас гүйцээн боловсруулах чиглэл өгсөн.

Ажлын хэсэг 2023 оны 12 дугаар сарын 18-ны өдөр хуралдаж дээр дурдсан асуудлыг хэлэлцэн дараах саналыг танилцуулж байна.

Үүнд:

1.Нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний зарчмыг тусгасан төслийн 4 дүгээр зүйлтэй холбогдуулан 4.1.1 дэх заалтын тэгш, хүртээмжтэй, чанартай байх гэсэн зарчмуудыг Хууль, тогтоомжийн тухай хуульд хуулийн төслийн заалтад бие даасан нэг санаа байхаар заасныг үндэслэн тусдаа заалт болгох мөн жендерийн эрх тэгш байдлыг хангах гэсэн зарчмын төсөлд шинээр нэмэх нь зүйтэй гэж үзлээ.

2.Төслийн 5 дугаар зүйлийн 5.1.1 дэх заалтаар зохицуулсан асуудал нь тусдаа бие даасан 2 санаа байх тул дээр дурдсан Хууль тогтоомжийн тухай хуулийн заалтыг үндэслэн 2 заалт болгон салгаж томъёолох нь зүйтэй гэж үзлээ. Түүнчлэн энэ хэсэгт тусгагдсан нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээг орчин үеийн болон уламжлалт анагаах ухааны судалгааны үр дүн нотолгоонд суурилан зохион байгуулах нь зүйтэй гэж үзлээ.

3.Төслийн зүйл, хоорондох нэр, томъёоны нийцлийг хангах үүднээс төслийн 19 дүгээр зүйлийн 19.4 дэх заалтын байгууллагын гэснийг хасах нь зүйтэй гэж үзлээ.

Эрхэм гишүүд ээ,

Улсын Их Хурлын чуулганы 2023 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн нэгдсэн хуралдаанаар анхны хэлэлцүүлгийг явуулах үед дэмжигдсэн саналуудыг төсөлд нэмж шигтгэж төслийн эцсийн хувилбарыг бэлтгэн та бүхэнд хүргүүлсэн болно.

Мөн ажлын хэсгээс бэлтгэсэн 3 зарчмын саналыг томъёолон та бүхэнд хүргүүлснийг хэлэлцэн шийдвэрлэж өгнө үү гэсэн байна аа.

Сарангэрэл гишүүн орж ирсэн байна. Эцсийн хэлэлцүүлэгтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу? Нэрсээ өгнө үү? Одонтуяа гишүүнээр тасаллаа. Туваан гишүүний микрофоныг нээе.

Ц.Туваан: Тэгээд энэ Нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний тухай хуулийг дэмжиж байгаа. Энэ яаралтай ингээд батлагдаад явах нь зүйтэй. Энэ дээр нэг асуулт байгаа. Тэгээд бас нэг хэлэх санал байгаа. Тэгэхээр энэ нийгмийн эрүүл мэндийн асуудал бол үнэхээр чухал. Юу хэлэх гэж байна гэхээр манай эрүүл мэндийн салбарын өөрөөр хэлбэл бид нар пирамид гэж ярьдаг энэ иргэдэд үзүүлж байгаа тусламж үйлчилгээний хуваарилалтын пирамид уруугаа харчхаад байгаа юм. Тэр нь юу гэхлээр эмчилгээ талдаа хамаг мөнгөө өвчилсөн хойно нь хамаг мөнгөө зарцуулдаг энэ байдал бол маш өндөр хувьтай. Бараг 80 гаруй хувьтай ингээд яваад байгаа юм.

Тэгэхээр энэний эсрэг нөгөө талд нь өвдсөн хойно нь эмчлэх биш өвчлөхөөс нь өмнө урьдчилан сэргийлэх гэдэг концепц энэ нь өөрөө маш чухал дээрээс нь үр дүн сайтай зардал багатай ийм зүйл байгаа юм. Тэгэхээр энэ асуудлуудыг энэ нийгмийн эрүүл мэндийн тухай хуульд бол ингээд тусгаж өгсөн. Энэ бол нэлээн тийм боломжийн туссан гэж ингэж харж байгаа юм. Тэгэхээр энэ дээр нэг хэлэх гээд асуух гээд байгаа зүйл нь бид нар өөрсдөө Монгол хүмүүс. Эртний уламжлалт, өөрсдийн гэсэн анагаах ухаантай, өөрөө өөрсдийгөө эмчлээд явдаг.

Дээрээс нь Ази гэдэг утгаараа энэ Европын зүйлээс бол зарим зүйлээрээ онцлог өөр байдаг. Ийм үндэстэн хүмүүс л дээ. Тэгээд энэ дээр энэ уламжлалт анагаах ухааны энэ асуудал яг энэ хуулийн дотор ямар ямар

заалтуудад яаж шигтгэж оров оо? Энэ зүйлүүдийг бас надад нэг хэлээдхээч.

Хоёрдугаарт энэ хуулиа нэгэнт хэлэлцэж байгаа юм чинь хэдүүлээ бас энэ зүйлээ шигтгээд албан албан ёсны болгоод ингээд оруулаад явах нь зүйтэй. Монгол анагаах ухаан Монголдоо болохоор мэдээж Анагаах ухааны Их Сургууль дээр гэхэд уламжлалт анагаах ухааны анги гээд л ингээд л эмч нараа бэлтгээд л ингээд л явдаг. Гадаадад болохоор манай уламжлалтынхныг бүр шүтчихсэн газрууд ч байгаа энэ европынхон. Польш, Герман гээд л бүр баруун тийшээ Канад, Америк ч гэдэг юм уу. Ингээд энэ арга маань зөв ийм байгаад байдаг. Тэгэхээр энийгээ бид хэд бас энэ хуульдаа одоо нэгэнт хэлэлцэж байгаа энэ шатан дээрээ эцсийн хэлэлцүүлгээс өмнө бол оруулаад авсан нь дээр байх аа. Орчин үеийн анагаах ухаан дээр чинь энэ 2 уламжлалт болон энэ Европ маягийн орчин үеийн анагаах ухаан 2-ыг чинь хослуулаад хэрэглэж байгаа маш олон орон улсууд байгаад байна. Тэгэхээр бид нар энэ дэлхийн чиг хандлага энэ юмнаас бол хоцрох ёсгүй.

Дээрээс нь маш олон уламжлалтын эмч нар хөдөө орон нутгаар явж байх ч ч гэсэн бид нарт хууль, эрх зүй дутагдалтай байна аа. Уламжлалт анагаах ухааны талаар бас хууль эрх зүйн бие даасан бичиг баримттай болгож өгөөч. Бид нарын энэ эрүүл мэндийн гүйцэтгэлийн санхүүжилтийн тогтолцоо энэ тэр рүү бас бид нарыг оруулж өгөөч. Дээрээс нь энэ холбоодтойгоо бас хамтарч ажиллаач гэсэн ийм маш олон саналууд ирдэг. Тэгэхээр энэ зүйлүүдийг бас энэ хуульдаа бид нар тусгаад явах нь зөв байх аа. Тэгээд энэ хуулийн 52.1 дэх заалт дотор орж байгаа энэ орчин үеийн болон уламжлалт анагаах ухааны судалгааны үр дүн нотолгоонд суурилан зохион байгуулах гэдэг энэ хэсэг дотор ингээд орсноор энэ хангалттай юу

манай ажлын хэсгийнхэн надад нэг хариулаад өгөөч ээ.

Баярлалаа.

Ж.Чинбүрэн: Ажлын хэсгийн ахлагч Сарангэрэл гишүүний микрофоныг нээе хариулт өгье.

Д.Сарангэрэл: Баярлалаа. Манай Туваан гишүүн мэргэжлийн хүн учраас асуудалд үнэхээр тийм эрүүл бас маш ухаалаг тэгээд мэдлэгтэй хандаж байна. Тэгээд баярлалаа. Энэ хууль бас харьцангуй чамбай хууль болсон. Тэгэхдээ бүгдээрээ ингээд урьдчилж харах юм уу, төгс бол хууль бас хийх боломжгүй. Дутуу хөтүү зүйл ч байгаа гэдгийг бас бид нар мэдэж байгаа. Тэгэхдээ ажлын дэд хэсгийн хувьд Эрүүл мэндийн яам, Тамгын газрынхан манай Байнгын хорооны нөхдүүд маань маш сайн ажилласан манай Цогзолбаяр ахлах зөвлөх маань ахлаад. Баярболд дарга Эрүүл мэндийн яамнаас, Өнөрсайхан дарга НЭМҮТ гээд. Ингээд мундаг баг ажилласан, их чамбай ажилласан гэж бод бодож байгаа. Нийтдээ 19 удаа хуралдсан ажлын дэд хэсэг. Ингээд ажлынхаа хэсгийг бас зовоохгүй байх талаасаа аль болох тийм бэлэн талаас нь бодсон ийм томъёолол оруулах гэж ингэж хичээж ажилласан.

Тэгээд энийг манай Туваан гишүүн бас уншаад судлаад ингээд харсанд маш их баяртай байна. Сүүлээс нь хариулахад оролцооны хувьд бол яг зөв. Иргэн, аж ахуйн нэгж байгууллага, хамт олон мэргэжлийн болон мэргэжлийн төрийн бус байгууллагууд иргэний нийгэмтэй бид нар ажил хамтарч ажиллаж байж энэ 3.4 сая хүний эрүүл мэндийг хамгаалах дэмжих ийм үйл ажиллагааг явуулж чадна. Энэ ганцхан эрүүл мэндийн салбарын нуруун дээр бууснаар энэ ажил бас явахгүй. Энэ утгаар нь энэ оролцооны асуудлыг Туваан гишүүн маш сайн хийж өгсөн.

Иргэдийн аж ахуй, хамт олон, төрийн бус байгууллага, хэвлэл мэдээллийн хэрэгслүүд гээд бүүр яг оролцоо гэдэг тусад нь заалтыг анх удаа ингээд хийж өгснөөрөө их онцлогтой байгаа. Тэгээд сая уламжлалт анагаах ухаан, орчин үеийн анагаах ухаантай хослуулан бид нар бас ажиллаж байж энэ нийгмийн эрүүл мэндийнхээ чиглэлийг нэлээн хөгжүүлж чадна. Иргэдээ эрүүл мэндийг нь хамгаалах дэмжих энэ үйл ажиллагаа маань бас харьцангуй өргөн цар хүрээг хамарч явахад үр дүнтэй гэж таны хэлж байгаатай бүрэн дүүрэн санал нэг байгаа.

Тэгээд Чинбүрэн гишүүн маань мэргэжлийн хүний хувьд өчигдөрхөн 1 дүгээр хэлэлцүүлгийн үеэр гүйцээн боловсруулах чиглэлийг Улсын Их Хурлын даргаас аваад уламжлалт анагаах ухааны чиглэлийг 5.1.2-т тусгайлан суулгаж өгснөөс гадна мөн бас нэг заалт байгаа. Тэгээд сая манай ажлын хэсгийнхэн Туваан гишүүнийхээ асуултыг анхаарсан саяын хэлсэн заалтуудыг нэг бүрчлэн заалтаар нь уншаад гишүүндээ танилцуулж өгөөч гэж хүсэж байна.

Ж.Чинбүрэн: Тэгэхлээр Туваан гишүүний асуусан уламжлалт анагаах ухааны чиглэл хэр бодитой орсон бэ гэдэг асуултад Баярболд дарга хариулъя. 4 дүгээр микрофон.

Д.Баярболд: Туваан гишүүний асуултад хариулъя.

Нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний тухай хуулийн төслийн 4.1-д нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээг дараах зарчмаар баримтална гэж заасан. Үүний 4.1.5-д үндэсний онцлогт уламжлалд суурилан олон улсын жишиг хөгжлийн чиг хандлагад нийцсэн байх гэсэн зарчмыг оруулж өгсөн.

Мөн 5.2-ын нэгдээ ажлын хэсэг хуралдаад энэ халдварт болон халдварт бус өвчний эрсдэлт хүчин зүйлийн тархалтыг тандан судлах, тодорхойлох, урьдчилан сэргийлэх, хянах арга хэмжээг орчин үеийн болон уламжлалт анагаах ухааны судалгааны үр дүн нотолгоонд суурилан хэрэгжүүлэхээр бас тусгаж өгсөн байгаа.

Ж.Чинбүрэн: Тэгэхээр бид бас энэ ковид цар тахлын үеэр уламжлалт анагаах ухааны тан ямар их тустай байсныг мэдэж байгаа. Мөн томуу, томуу төсөлт өвчний дэгдэлтийн үед бид бас энэ урьдчилан сэргийлэх боломж бас байдаг юм байна аа. Тэгээд зөвхөн эм тангаар биш бид энэ явдал мөр идээ ундаа гэдэг манай уламжлалт анагаах ухааны энэ чухал зүйлүүдийг бид тусгаж өгөх ёстой гэдгийг энд тусгасан гэж харж байгаа. Би бас өөрөө ажлын хэсэгт орж байгаа учраас нэмэлт хариул өглөө.

Туваан гишүүн хариулт хангалттай юу?

Баярлалаа.

Одонтуяа гишүүний микрофоныг нээе. Одонтуяа гишүүн асуултаа асууя.

С.Одонтуяа: Баярлалаа. Тэгэхээр энэ 5.2.2-т Нийгмийн эрүүл мэндийн мэдээллийн сан бүрдүүлэх мэдээ мэдээлэлд дүн шинжилгээ хийх гээд нэг заалт байгаа. Тэгэхээр энэ талаар нэг дахиад дэлгэрэнгүй мэдээлэл өгөхгүй юу? Энэ хувь хүмүүсийн сан байх юм уу эсвэл тэр өвчлөлийн тухай байх юм уу? Энэ яг юутай ямар мэдээлэл агуулсан сан байх юм бэ гэдгийг бас нэг мэдээлэл авъя.

Хоёрдугаарт Чинзориг сайдаа энэ хугацаан дээр би дахин дахин хэлээд л та нар болно оо л гээд байгаа. Энэ 7

сарын 1-нээс л байхгүй бол би энэ 4 сарын 1-нээс яагаад ч амжихгүй санагдаад байгаа юм л даа. Яагаад гэхээр орон нутгууд томоохон эмнэлгүүд чинь энэ нийгмийн Эрүүл мэндийн төвүүд нь байгуулагдаагүй зоонозын асуудал нь шийдэгдээгүй. Тэгээд орон нутгийн зарим лабораториуд байхгүй. Тэгээд л энэ нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний зардал, төсөв, үнэлгээ, журам гээд л түмэн юм батлагдах хэрэг болно. Тэгээд бид нарын яриад байгаа Ерөнхий сайдын дэргэдэх байгуулагдах тэр Үндэсний зөвлөл төлөвлөгөө гээд л маш олон юм байгаа юм л даа. Тэгэхээр энэ 4 сарын 1 гэхэд би зүгээр амжихгүй л санагдаж байна. Тэгээд энэ дээрээ та нар амжина гээд хийж байгаа бол энийг маш яаралтай энэ дээр онцгой анхааралтай.

Хоёр дахь асуудал. Ер нь сая Туваан гишүүн ч хэллээ. Энэ өвдсөн хойно нь биш энэ өвдөхгүй байх тал дээр бид нар энэ гол хууль маань чиглэж байгаа гэж. Хүмүүсийг тэгэхээр энэ өөрсдийгөө өвдүүлэхгүй байнга фитнесээр биеийн тамираар энэ ингээд л алхдаг, биеийн тамир хийдэг энэ эрүүл мэндийн улсад дарамт болдоггүй нэг хэсэг хүмүүс байна шүү дээ. Энэ хүмүүсийн хувьд ямар нэгэн тийм хөшүүрэг дэмжсэн тийм юм орсон уу? Нэг урамшуулал гэж заалт байснаа хасагдчихсан байна лээ.

Тэгэхээр бас чуулган дээр нэг гишүүн ярьж байсан шүү дээ. ЭМД-ын хуулиас ч гэсэн энэ хүмүүст бас уг нь өгөх нь зүйтэй юм гээд. Тэгээд 1 хэсэг хэрэгжиж байгаад больчихсон юм. Яах вэ манайхан нөгөө муу юмандаа бас зарим зүйлд ингээд буруу ашиглаад байдаг гэдэг утгаар тэгсэн юм уу, зарим хүмүүс даатгалд фитнес явахгүй хэрнээ даатгалаас мөнгө гарчихна гэсэн юм уу. Одоо чинь ийм царай таньдаг юунууд програмууд гарчихсан шүү дээ.

Царай таниад л тэр хүн хэдэн цаг фитнес хичээллэж байна. Ингээд энэ хүмүүсийг дэмждэг барьдаг ийм зүйл ер нь орсон уу? Яагаад гэхлээр жишээлэхэд би нэг телевизээр харж байсан юм. Дубайд хүмүүсээ 1 кг илүү жин хасвал тэчнээн грамм алт өгнө өө энэ тэр гэсэн чинь л хүн бүхэн гүйгээд л жигтэйхэн эрүүл мэндээ анхаараад л ингээд л нэг ийм энэ яах вэ дээ нийтдээ ийм хүмүүст ийм хөдөлгөөн өрнүүлж байгаа юм л даа хөшүүрэг.

Тэгэхээр энэ хуульд яг энэ өвдүүлэхгүй байх тал дээр сайхан уриалсан хөшүүрэг нь яг юу орсон юм болоо?

Ж.Чинбүрэн: Одонтуяа гишүүн 3 асуулт асуулаа. Эхний 1, 3 дугаар асуултад Сарангэрэл гишүүн хариулах байх гэж бодож байна. Сарангэрэл гишүүний микрофоныг нээе. Манай Одонтуяа гишүүн Эрүүл мэндийн сайдын зөвлөх байсан хүн. Эрүүл мэндийн чиглэлээр нэлээн ойлголттой болсон байх гэж бодож байгаа би. Тэгээд эрүүл мэндийн салбарын өвчний мэдээлэлдээ иргэний мэдээлэл, улсын бүртгэл дээр л байна шүү дээ. Тэгээд иргэнтэй холбоотой эрүүл мэндийн энэ өвчний мэдээлэл одоогийн байдлаар Эрүүл мэндийн хөгжлийн төв дээр төвлөрдөг юм. Бид нар энэ хуулиараа Өвчний хяналт сэргэлтийн төвийг анх удаа олон улсын жишгийн дагуу Си Ди Си гэдэг ийм төвтэй болох юм байгаа юм.

Тэгээд энэ мэдээллээ энэ төв дээрээ төвлөрүүлэх Монголын иргэдийн эрүүл мэндийн байдал өвчний байдлын талаарх мэдээллүүдийн бүртгэл сан бүрдүүлж ажиллах юм. Үүндээ дүн шинжилгээ хийж үүн дээрээ суурилсан иргэдийн дунд ямар өвчин зонхилон тохиолдоод байна. Үүнээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа явуулахад энэ сан бүрдүүлэх си ди си дээрээ энэ

мэдээллээ төвлөрүүлэх нь чухал байгаа учраас энэ заалтыг олон улсын жишгийн дагуу хийж өгсөн.

Би хугацаатай холбоотой заалтыг ч гэсэн хэлмээр байна. Эрүүл мэндийн салбарт нийгмийн эрүүл мэндийн чиглэлийн үйл ажиллагаа огт байгаагүй гэвэл бас өрөөсгөл болно. Энэ үйл үйл ажиллагаа явсаар ирсэн. Манай эрүүл мэндийн салбарынхан энэ нийгмийн эрүүл мэндийн чиглэлийн тусламж үйлчилгээн дээрээ анхаарах ёстой. Энэ ийм бүтэц бүрдүүлэх ёстой гэдэг дээр бол үе үеийн сайд нар үе үеийн парламентад саналаа тавьсаар ирсэн. Харамсалтай нь санхүү эдийн засгийн хувьд хүндрэлтэй байна гэдэг байдлаас болоод энэ асуудлуудыг нь ишидэж өгөхгүй явсаар ирсэн юм байгаа юм. Ингэснээрээ юу болсон бэ гэвэл түрүүний Туваан гишүүний хэлдэг ерөөсөө эрүүл мэндийн салбарын үйл ажиллагаа бодлого нь буруу харсан байхгүй юу.

Одоогийн байдлаар бол эрүүл мэндийн салбар 1 далавчтай л байгаа юм. Эмнэлгийн тусламж үйлчилгээнийх нь чиглэл нь давамгайлаад нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний асуудал нь орхигдчихсон. Энэ хуулиараа бид нар энэ салбараа 2 далавчтай болгож бас нэг нисэх ийм боломжийг нь өгч байгаа юм. Тэгээд энэ бол хамгийн гол нь эрүүл мэндийн салбар өөрөө үүнийг эхлэх ёстой. Үүнийг манлайлах ёстой. Жинхэнэ утгаараа бүтцээрээ ажиллах ёстой. Тэгэхийн тулд бид нар хууль эрх зүйн орчныг нь бүрдүүлж өгч байгаа юм. Хүний нөөцийнх нь асуудлыг шийдвэрлэх боломжийг нь бүрдүүлж өгч байгаа юм. Нийгмийн эрүүл мэндийн салбарын ажилтнууд бусад эмнэлгийн тусламжийн чиглэлийн ажилтнуудтайгаа нэгэн адил хуулиар нийгмийн баталгаатай болох зэрэг олон боломжийг бүрдүүлж өгснөөрөө энэ хуулийн давуу тал байгаа юм.

Тийм учраас үргэлжилж байгаа нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чиглэлийг тасалдуулахгүй байх үүднээсээ дээр нь Эрүүл мэндийн сайд олон удаа тайлбарлаж байгаа. Санхүүжилтийнх нь асуудлыг тодорхой хэмжээгээр 2024 оны төсөвт суулгаад өгчихсөн учраас бид нар энийг хойшлуулишгүй нэгэнтээ хийгээд дундаа ороод явж байгаа ажлыг үргэлжлүүлээд аль болох цогц хурдан дуусах тал дээр нь явах ёстой гэдэг үүднээсээ салбарын сайд өөрөө энэ салбараа ахалж байгаа. Мэргэжлийн хүмүүсээсээ 4 сарын 1 болно гэдэг ийм хугацааг би оруулж ирж байгаа гэж ойлгож байгаа учраас ажлын дэд хэсэг болон ажлын хэсгийн түвшинд дэмжээд ингээд явж байгаа. Ийм хугацаа байгаад байгаа юм аа.

Харин Одонтуяа гишүүний хэлж байгаа ЭМД-ын шимтгэл төлөөд үүнийгээ огт хэрэглэхгүй байгаа иргэдэд ямар урамшуулал олгох юм бэ? Үүнийг дэмжих ямар боломж байгаа вэ гэдгийг байнга асууж байгаа. Энийг зөвхөн Одонтуяа биш бас бусад гишүүд ч гэсэн асуугаад байгаа учраас манай сайд болон ажлын хэсгийнхэн үүн дээр би хариулах нь зүйтэй гэж бодож байна.

Хугацааныхаа хувьд ч гэсэн сайд өөрийнхөө нэмэлт тайлбарыг өгнө үү. Баярлалаа.

Ж.Чинбүрэн: 3 дугаар микрофоныг тэр юутай урамшуулалтай холбоотой асуулт. Дараа нь Чинзориг сайд хугацааны асуудлаар нэмж хэлье.

3 номерын микрофон нээнэ үү?

С.Өнөрсайхан: Мэдээллийн санд ямар мэдээлэл байх вэ гэдэг дээр Сарангэрэл даргын ингээд хариулсан хариулт дээр нэмье. Энэ дээр нийгмийн

мэдээллийн сан дээр бол тэр Эрүүл иргэдийн эрүүл мэндийн мэдээллийн хөгжлийн төвд байгаа мэдээллүүдээс гадна энэ орчны эрүүл мэндийн тандалтын бүх асуудлууд Засгийн газрын тогтоолоороо бас төвлөрч явагддаг. Энэ мэдээллүүд бүгд орно. Энэ тухайгаа болохоор энэ нийгмийн эрүүл мэндийн асуудал хариуцсан төвийн түр байгууллага нь энэ 12.1.10 дээр тусгаж өгсөн байгаа. Нийгмийн эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн төв байгууллага нь мэдээ, мэдээллийг цуглуулах, нэгтгэн боловсруулах, дүн шинжилгээ хийх, үндсэн үзүүлэлтүүдийг тооцох, эмхэтгэх, түгээх, эргэн мэдээлэх асуудлыг хариуцуулна гэж чиг үүрэг дээр зааснаас гадна, 7.1.1 дээр эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн Засгийн газрын гишүүний бүрэн эрх дээр нийгмийн эрүүл мэндийн мэдээллийн сангийн ажиллах журмыг цахим хөгжил харилцаа холбооны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнтэй хамтран батлах гэж зааж өгснөөрөө энэ журам дээрээ ямар ямар мэдээллүүдийг багтаах вэ, хэзээ хааш нь яаж явуулах вэ гэдэг зүйлээ нарийвчлан тусгаж өгнө өө.

Ж.Чинбүрэн: 4 номер. Тэгээд урамшуулалтай холбоотой мэдээлэл өгөөч?

Д.Баярболд: Одонтуяа гишүүний асуултад хариулъя. Эрүүл мэндийн яамны Нийтийн эрүүл мэндийн газрын дарга Баярболд. Монгол Улс 4 жил тутамд энэ халдварт болон халдварт бус өвчний эрсдэлт хүчин зүйлийн судалгааг хийдэг. Степ судалгаа дээр нийт хүн амын дөнгөж дөрөвхөн хувь нь өвчний ямар нэгэн эрсдэл үүсгэх хүчин зүйлд хамааралгүйгээр амьдардаг. Нийт хүн амын маань 96 хувь нь өвчний эрсдэлт хүчин зүйл 2-оос 5 эрсдэлт хүчин зүйлүүд давхардаж авсан байдлаар тулгардаг ийм судалгаа гарсан байдаг.

Тэгэхээр өнөөдөр өвчлөлийн байдал эрт илрүүлэг үзлэг шинжилгээгээс ч харахад нийт үзлэгт хамрагдсан хүн амын маань 70 гаруй хувь бол ийм өвчний ямар нэгэн сэжигтэй тохиолдол шалтгаантай байгаа. Ийм учраас Эрүүл мэндийн даатгал маань өөрөө одоо бол яг энэ өвчлөлийг эмчлэх, эрсдэлийг үүрээд явж байгаа. Яваандаа Нийгмийн эрүүл мэндийн тухай хууль маань үйлчлээд ирэхээр энэ өвчлөл багасаад ирнэ. Тэгэхээр мэдээж ЭМД-ын сан дээр хуримтлал үүсэх байх. Энэ үед бид нар харин энэ эрүүл биеэ авч явж байгаа иргэддээ урамшуулах энэ асуудлыг ярих байх гэж бид ажлын хэсэг бид нар бол ярьж байсан.

Хамгийн гол нь бид бас энд урамшууллын асуудал дээр энэ нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд олон нийтийн оролцоон дээр энэ урамшуулах журмыг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн энэ журмыг батлахаар бол оруулж ирсэн байгаа.

Ж.Чинбүрэн: Чинзориг гишүүн микрофон өгье. Чинзориг сайд.

С.Чинзориг: Гишүүдийнхээ өглөөний амгаланг айлтгая.

Одонтуяа гишүүний асуултад товчхон хариулахад яах вэ хэр хэрэгжих хугацааг бол бид нар 4 сарын 1-ээс хэрэгжүүлбэ гэсэн ийм л саналтай. Тэгээд Байнгын хороо бас санал дэмжээд чуулган дээр бол дэмжигдчихсэн. Тэгэхээр одоо бол дахиж хөндөх бол асуудал байхгүй болов уу гэж л бодож байна. Миний хувьд бол бас тодорхой хэмжээний санхүүжилттэй холбоотой асуудлууд бас 2024 оны төсөв дээр бас яригдсан. Тавиад орчим тэрбум төгрөг нийгмийн эрүүл мэндийн чиглэлээр бас тус тус

туссан байгаа. Иргэний эрүүл мэндийн боловсролыг дэмжих чиглэлээр бас нэг 5 тэрбум төгрөгийн бас төсөв эд нар ирэх оны төсөв дээр Сангийн яамтай ярьж байгаад тусгуулчихсан юм.

Тийм учраас төсөвт ингээд 4 сарын 1-ээс хэрэгжээд явахад боломжтой болов уу гэж бодоод байгаа юм. Яах вэ тэр бүтэцтэй холбоотой юм эд нар цоо шинээр бол бүтэц бол байгуулахгүй. Одоогийн байгаа Нийгэм эрүүл мэндийн үндэсний төв тэгээд ХӨСҮТ, зоонозын тод зарим нэг тэр тандалт судалгаа сэргээлттэй бас холбоотой хэсгийг нь тэгээд дээ дээр нь Эрүүл мэндийн хөгжлийн төвд байгаа тэр мэдээллийн чиглэлийн хэсгүүдийг нь бол тэр шинээр бас зохион байгуулагдаж байгуулагдах өвчний Хяналт сэргийлэлтийн төв рүү шилжүүлээд ингээд явчихна. Шинээр бол бүтэц орон тоо шинэ цоо шинээр бий болох цалингийн сан нэмэгдэх ийм асуудлууд байхгүй учраас бүтэц зохион байгуулалт дээр нэг их хүндрэл гарахгүй болов уу гэж бодож ж байгаа юм.

Хоёр дахь асуудал дээр ер нь бол цаашдын би хэдүүлээ чуулган дээр ч хэлсэн. Ер нь энэ ЭМД-ын сангийн талаар баримтлах бодлогоо манай Байнгын хороо ч гэсэн цаашидаа бол өөрчилмөөр байгаа юм аа. Бид чинь сүүлийн хэдэн жил ний нуугүй хэлэхэд даатгалын сангийн чинь хөрөнгийг төсвийн цоорхой нөхөх маягаар л явуулаад ирсэн шүү дээ. Ерөөсөө ЭМД-ын сангийн хөрөнгө, үлдэгдэлтэй гарах ёсгүй. Тухайн жилд төвлөрч байгаа хөрөнгийг бүгдийг нь л зарцуулаад 100 хувь зарцуулсан байх ёстой гээд л ингээд л бүх л мөнгөө эмнэлгийн тусламж үйлчилгээнд 100 хувь олгоод л Ингээд л шахаад л. Тэгээд бид нар сүүлийн хэдэн жил үндсэндээ ингээд даатгалын сангийн чөлөөт үлдэгдэл эд нар бол маш багасчихсан.

Анх Сарангэрэл сайдыг Эрүүл мэндийн сайдаар томилогдож даатгалын санд шилжиж байхад 600 тэрбумын үлдэгдэлтэй сан бол тийшээ шилжиж байсан бол одоо үндсэндээ чөлөөт үлдэгдэлгүй л болчихоод байгаа юм л даа.

Тэгэхээр энэ даатгалын сан 100 хувь тухайн жилдээ зарцуулагдаж дуусаж байх ёстой гэсэн энэ бас бодлого, энэ чиглэлийг ч гэсэн бас бид бас жаахан өөрчилмөөр л болов уу. Даатгалын сан гэдэг бол өөрөө ирээдүйд тухайн хүний эрүүл мэндэд учрах эрсдэлийг хуваалцах үүднээс л бид нар даатгал төлж байгаа шүү дээ. Тэгэхээр энэ бол 100 хувь ингээд зарцуулагдаад дуусаад байдаг сан биш. Бас тодорхой хэмжээний бас нөөцтэй байдаг. Тэр нөөцөөр нь тэр эрүүл мэндийн үйлчилгээ аваагүй иргэдэд нь туслалцаа дэмжлэг үзүүлдэг, урамшуулал үзүүлдэг эд нар тийм байх бодлого руу бид орох ёстой гэсэн ийм байр суурьтай бол байгаа юм аа.

Тийм учраас бол энэ тал дээр бол асуудлыг шийднэ.

Хоёр дахь асуудал нь бид нар ингээд хууль эрх зүйн орчин шинэчлэлийнхээ хүрээнд бид нар Эрүүл мэндийг дэмжих тухай хууль, Эмнэлгийн тусламжийн тухай хууль, Даатгалын тухай хуулиудыг бас оруулж ирнэ. Чадвал хаврын чуулганаар хэлэлцүүлэх бодолтой бол байгаа юм. Ингээд одоо бүтэцтэй холбоотой юман дээр бол аймгууд дээр Эрүүл мэндийн газрууд гээд нийслэл дээр байгаа. Дунджаар 40 орчим хүнтэй эрүүл мэндийн газрууд байна аймгууд дээр. Энэ маань нэг хэсэг нь нөгөө Нийгмийн эрүүл мэндийн төв болоод нэг хэсэг нь, нөгөө эрүүл мэндийн.

Ж.Чинбүрэн: Одонтуяа гишүүн тодруулъя.

С.Одонтуяа: Яах вэ ямар ч байсан бид нар энэ хуулиа бас олон жил хүсэн хүлээсэн хууль юм чинь. Ямартай ч хурдан батлахыг дэмжиж байгаа. Тэгэхдээ ер нь зүгээр Чинзориг сайд энэ зөвхөн энэ хууль биш. Би сая одоо эцсийн хэлэлцүүлгийг л харж байна л даа. Зүгээр эрээн мяраан байгаа байхгүй юу. Жишээлэхэд 3 дугаар зүйл тэр чигээрээ. Үгүй ээ энэ хуулийг чинь эхнээс нь оруулж ирэхдээ нэг аятайхан хууль оруулчхаж болдоггүй юм уу? Энэ чинь ажлын хэсэг бол тодорхой хувиудыг л засахаас биш бүгдийг нь ингээд эрээн мяраан. Тэгээд уг нь бол танайх чинь яаман дээрээ хэлэлцээд яам чинь энийгээ удирдлагын зөвлөлөөрөө бүх хүмүүс нь үзээд батлаад наашаа явуулдаг уг нь ийм л баймаар юм. Тэгэхэд эхнээсээ ийм уялдаагүй юм уу? Оруулж ирчихсэн хуулийг нь би санаж байна. Баахан эрээн мяраан зассан. Хэн зассан юм гэсэн яамныхан зассан юм гээд. Үгүй энэ чинь орж ирчихсэн хойно нь ингээд тэгээд энэ чинь ажлын хэсгийг махалж байгаа байхгүй юу.

Тэгээд одоо ингээд зүгээр ингээд л энэ хуулийг л харъя. Зөвхөн би энэ эрүүл мэндийн.

Ж.Чинбүрэн: Чинзориг гишүүн хариулт өгье.

С.Чинзориг: Ажлын хэсэг бол сайн ажилласан. Би бол яамнаас нэг их тийм муу ч хууль оруулчихсан гэж бодохгүй. Намайг очиход бол хуулийн төсөл байсан. Ийм хуулийн төслийн хэмжээнд бол болохгүй гээд зөвхөн бүтэц тогтолцоотой холбоотой л хууль байна. Ийм хууль гээд байж болохгүй гээд яаман дээр очсон хойноо би энэ хуулийг нэлээн өөрчилсөн. Хамгийн гол нь тусламж үйлчилгээ юу үзүүлэх юм гэдгээ тодорхой болгохоор нэлээн өөрчилсөн.

Ажлын хэсгүүд дээр бол нэлээн өөрчлөлт хийсэн юм байна лээ. Гэхдээ нэг зүйл нь бол зарчмын ямар ч тийм өөрчлөлт гараагүй. Зарчмын өөрчлөлт ороогүй. Бүтцийг нь наана нь цаана нь өөрчилсөн. Үг найруулгын л өөрчлөлт оруулсан. Зарчмын тийм томоохон өөрчлөлт ороогүй юм аа. Тэгэхээр тийм нэг их муу хууль болчихсон гэж ойлгохгүй байна. Зарчим нь өөрчлөгдсөн бол энэ чинь шал өөр юм болоод явчихна. Газар тэнгэр шиг юм болно шүү дээ. Тэгэхээр би тийм муу хууль орж ирээд ингэчихлээ гэж бодохгүй л байна.

Ж.Чинбүрэн: Баярлалаа Сандаг-Очир гишүүн.

Ц.Сандаг-Очир: Би зүгээр энэ Нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний хууль хэрэгжих суурь нөхцөл бүрдсэн үү үгүй юу л гэж эргэлзээд байгаа юм. Тэгээд манай Монголчууд чинь хэнэггүй шүү дээ. Өвдөхөөс нь өмнө урьдчилан сэргийлж төсөв мөнгөө тэр талд нь чиглүүлнэ л гэж байна. Яг үнэнээ хэлэхэд ажил амьдралын онцлог нөхцөлөөс хамаараад тэр дундаа манай малчид эд нар бол яг үнэнээ хэлэхэд өвдсөн хойноо л эмнэлгийн бараа харж байгаа юм. Тэрнээс нэг их эрүүл мэндээ бодоод л, эдийн засаг, амьдралаа бодоод л урьдчилан сэргийлэхэд ямар сайндаа л энэ эрт илрүүлэг урьдчилан сэргийлэх үзлэгт хамралт бага байх вэ дээ. Төсвөөс мөнгө гаргаад л хөтөлбөр гаргаад л ингээд байхад л үндсэндээ энэ чинь өөрөө эрүүл иргэдийн эрүүл мэндийн боловсрол сул дорой байгааг л харуулж байгаа юм.

Эргээд өвчилсөн тохиолдолд хүн яг өөр дээрээ ямар нэг өвчнөөр өвчилсөн тохиолдолд л мэдэж байх шиг байгаа юм. Ямар хэцүү юм бэ? Ямар их эдийн засгийн хувьд дарамттай байдаг юм бэ? Ямар хүндрэлтэй байдаг юм бэ? Тэгээд цаашидаа нэг эрүүл мэнддээ анхаарах юм

бодож байх шиг байгаа юм. Тэрнээс ер нь зүгээр явж байгаа бол зүгээр яваад эрүүл байгаа гээд яваад л байгаа юм. Тэгээд манай ЭМД-ын тогтолцоо чинь хамтын удирдлагын гэдэг юм уу өвдсөн улсууд нь л ЭМД-ын шимтгэл төлөөд тэндээсээ үйлчилгээгээ аваад байдаг. Ер нь насаараа ЭМД-ын шимтгэл төлчхөөд тэгээд ямар ч эрүүл мэндийн тусламж үйлчилгээ авахгүй байгаа, эрүүл мэнддээ сайн анхаардаг энэ улсуудад ямар ч хөшүүрэг байхгүй нь үнэн.

Цаашидаа бол энэ хуулийн гол агуулга бол энэ рүү чиглэх ёстой гэж бодож байгаа. Үнэхээр тэр бие хаагаа эрүүл байлгахын төлөө спортоор хичээллэдэг, эрүүл байдаг, урьдчилан сэргийлэх үзлэг оношилгоондоо хамрагддаг энэ иргэд рүү тэр даатгалын тэр үйлчилгээ чиглэдэг байх ёстой.

Тийм учраас би зүгээр энэ яг одоо 4 сарын 1-ээс хэрэгжээд эхлэхэд юу л бол гэж ингэж эргэлзэж байна аа. Нөгөө талаар одоо энэ нийгмийн ЭМТ-үүд байгуулагдчихсан орон нутгууд байгаа шүү дээ сайдаа, байгуулагдчихсан. Одоо энэ Мөнхсайхан сайд, Энхболд сайдын үед, Сараа сайдын үед эд нар зарим газруудад дүүргүүд дээр тэр нийгмийн ЭМТ-үүдийг байгуулчихсан зүйл бий. Гэхдээ одоо тэр төвүүд бол албан ёсоор тэгээд амбулаторитойгоо цуг байгаа, бүтэц зохион байгуулалтын хувьд. Төсөв санхүүгийн хувьд цуг байгаа. Тусдаа гарсан зүйл байхгүй байгаа. Энэ нь эргээд эрүүл мэндийн байгууллагынхаа зардал дээр дарамт болж байгаа зүйлүүд бий.

Тийм учраас энэ цаашидаа энэ байгуулагдчихсан байгаа нийгмийн ЭМТ-үүдийг ер нь яах юм. Яг тусад нь гаргах юм уу. Таны саяын яриагаар ямар нэг бүтэц орон тоо хийхгүй, шинээр бий болгохгүй ийм юм ярьж байна. Тэгвэл

одоо энэ байгуулагдчихсан байгаа нийгмийн ЭМТ-үүдийг цаашид нь энийг улам төгөлдөржүүлж тогтвортой ажиллуулах тал дээр бүтэц орон тооны хувьд төсөв урсгал зардлыг нь, цаашидаа тоног төхөөрөмж, хүн хүч, боловсон хүчний асуудлуудыг нь яг яах юм? Энэ нийгмийн ЭМТ-үүдийг цаашидаа байгуулагдсануудыг улам төгөлдөр, улам боловсронгуй болгож чадвал уг нь яг манай энэ хуулийн гол агуулга зорилго бол энэ рүүгээ хандах л байх гэж би бодож байна.

Тэгэхгүй бол нөгөө л нөгөө амбулатори руугаа гүйдэг, ханиад хүрсэн ч гүйдэг чих, хамар хоолой өвдсөн ч гүйдэг. Нөгөө нийгмийн эрүүл мэндийн төв рүүгээ гүйх энэ урсгал чинь хандлага чинь иргэдийн дотор бага байсаар байгаа нь яг хэвээрээ байгаа. Тийм учраас энэ нөгөө талаар өрхийн анхан шатны эмнэлгүүдийг яах юм? Ачааллыг уг нь энэ том улсын эмнэлгүүдийг ачааллыг хуваалцаж байх юмнууд чинь анхан шатны Өрийн эрүүл мэндийн төвүүд байх ёстой. Иргэд анхан шатандаа очдог байх ёстой. Өрхийн эрүүл мэндийн төвүүд нь анхан шатандаа анхны үзлэг.

Ж.Чинбүрэн: Сандаг-Очир гишүүний асуултад Сарангэрэл гишүүн ажлын хэсгийн ахлагч эхлээд хариулъя.

Д.Сарангэрэл: Сандаг-Очир гишүүн зөв асуудал хөндөж байна аа.

Өөрөө ч бас Багануурын Засаг дарга байсныхаа хувьд эрүүл мэндийн салбартаа илүүтэй анхаардаг байсан. Намайг эрүүл мэндийн сайд байхад их хамтарч ажиллаж бас олон зүйлүүдийг хийсний нэг нь нийгмийн эрүүл мэндийн төв дээрээ анхаарч бас бид нарыг хуулиас өмнө тодорхой асуудлуудыг нь ишидээд ингээд явчихсан байгаа. Тэгэхээр ер нь эрүүл мэндийн боловсрол чиглэлд онцгойлон анхаарах ёстой гэж

Сандаг-Очир гишүүнийхээ хэлж байгаатай санал нэг байгаа. Тийм учраас бол энэ Нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний тухай хуульд эрүүл мэндийн боловсролын асуудлуудыг тусад нь нэлээн сайн шигтгэж өгсөн. Хэвлэл мэдээллийн салбаруудтайгаа хамтарч ажиллах бас тодорхой хэмжээний бас хэвлэл мэдээллийн хэрэгслүүд хүлээх нөгөө ард түмнээ мэдээллээр хангах төрийн функцийг хуваалцаж байгаа гэдэг утгаар нь бас тодорхой хэмжээний үүрэг чиглэл өгсөн. Хамтарч ажиллах бололцоог нь нээсэн ийм хуулийн заалтуудыг хийсэн байгаа.

Эрүүл мэндийн боловсрол маш чухал аа. Их Хурал дээр гэхэд л бид нар таргалалт, илүүдэл жинтэй манай гишүүд бас их сайн тэмцэж байгаа шүү дээ. Үлгэр жишээгээр ярих юм манай Батлут гишүүн байж байна. Тийм ээ. Тэрэнтэй адилхан иргэд, аж ахуйн нэгж, гэр бүл, хамт олон бие биедээ нийгмийн эрүүл мэндийн чиглэлээр нөлөөлөх, хамтарч ажиллах, мэдлэг мэдээллээ хуваалцах тэр боломжийг бид нар бас мөн энэ хуульд оруулж өгсөн байгаа. Нийгмийн эрүүл мэндийн чиглэлийн тусгай пэйж хуудас ажиллуулах, цахимаар иргэдээс энэ чиглэлээр ямар асуудлыг бид иргэдтэйгээ хамтарч хийж хэрэгжүүлэх шаардлагатай вэ гэдгийг амьд харилцаатайгаар байнга мэдээлэл авах энэ боломжийг хүртэл энэ хуулиар ингээд нээж өгсөн байгаа юм аа.

Тэгээд 4 сарын 1-ний тухайд манай Чинзориг сайд хэлнэ биз. Бид нарт энийг хийгээд явах бололцоонууд их өргөн байгаа. Би Сандаг-Очир гишүүнтэйгээ нэг зүйл дээр 100 хувь санал нэг байгаа нь өвдөхөөс нь өмнө урьдчилан сэргийлнэ гэхчээд урьдчилан сэргийлэх үзлэгт орж байгаа. Эрт илрүүлэлтэд очиж байгаа иргэд маань өвдсөн хүмүүстэй зэрэгцээд очерлож

суугаад ингээд яваад өгдөг эсвэл халдвар авах тэр нөхцөлийг нь бүрдүүлээд байдаг.

Тийм учраас би Эрүүл мэндийн сайд байхдаа тухайлбал 1 дүгээр эмнэлгийн дарга Мөнхсайхан, 2 дугаар эмнэлгийн дарга Энхболд дараа нь сайд болсон 2 залуу. Энэ 2 эмнэлгээ түшиглээд Эрүүл мэндийг дэмжих төв гэдгийг тусад нь байгуулж өгсөн. Бүх тоног төхөөрөмжөөр нь хангаад ингээд урьдчилан сэргийлэх үзлэг эрт илрүүлэгт орох иргэд маань нэг хаалгаар ороод нэг хаалгаар гараад явах өвчтэй хүмүүстэй хамт очерлож суудаггүй байх ийм боломжийг бүрдүүлсэн. Дараа нь манай 3 дугаар эмнэлгийнхэн байгуулсан байна лээ. Энэ мэтчилнээр энэ эрүүл мэндийг дэмжих төвүүдийг байгуулах юм бол харин нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээг жинхэнэ амьд утгаар нь бий болгох ийм боломж бүрдэнэ. Тэгээд энэ дээр анхаарч ажиллаарай гэж хэлж байгаа Сандагаа гишүүнийхээ саналтай санал нэг байна.

Ж.Чинбүрэн: Чинзориг сайдын микрофоныг нээе.

С.Чинзориг: Нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний тухай хуультай болох зайлиггүй шаардлага бол байгаа юм аа. Энэ одоо нөхцөл нь үүссэн үү, цаг үе нь мөн үү гээд би мөн л гэж үзээд байгаа юм. Би нэг зүйлийг хэлээд байгаа шүү дээ. Үндсэн хуульд ч гэсэн иргэн эрүүл мэндээ хамгаалах нь иргэний журамт үүрэг мөн гээд маш том Үндсэн хуулийн заалттай. Тэрийг төр ч ярьдаггүй хэн ч ярьдаггүй. Тийм учраас бол энэ бас нэг нөхцөл шалтгаан нь байгаа юм.

Хоёр дахь асуудлууд нь энэ хавдрын өвчлөл маш их хүндрэл гээд байна. Хавдрын чинь өвчнөөр оношлогдож байгаа иргэдийн чинь 74

хувь нь дандаа хожуу үед оношлогдоод байна шүү дээ. Тийм учраас бол энэ зайлиггүй энэ эрт илрүүлгийг бас хийдэг зайлиггүй шаардлагатай байна. Ийм нөхцөл боломжууд байгаа учраас бол бид нар энэ Нийгмийн эрүүл мэндийн тухай хуульд зайлиггүй шаардлагатай байгаа юм.

Гурав дахь асуудал нь тэр олон улсын хөгжлийн жишигээс ч гэсэн бид нар урвуу л яваад байгаа юм л даа. Ер нь нийгмийн эрүүл мэнд анхан шатдаа тэр олон улсын байгууллагууд чинь үйлчилгээнийхээ дийлэнхийг нь үзүүлдэг. Санхүүжилтийнх нь дийлэнхийг нь үзүүлдэг. Бид чинь ерөөсөө л санхүүжилтийн дөнгөж нэг хорьхон хувийг нь л энэ шатдаа өгч байна шүү дээ. Тэгэхээр энэ олон улсын хөгжлийн жишигийн эсрэг бид нар яваад байгаа. Ийм нөхцөл шаардлагууд байгаа учраас энэ хууль байгаад байгаа юм ЭМД-ын сан чинь бол Сандаг-Очир гишүүн ээ одоо бид бол хуваарилалтын зарчимтай л явж байна шүү дээ. Хуваарилалтын зарчимтай. Цаашидаа бол энийг бас өргөжүүлж бие даалгах ер нь тэр хуримтлалын, хагас хуримтлалын тогтолцоо руу эд нар оруулах асуудлыг шийдэх ёстой. Тэгж байж тэр урамиуулалтай холбоотой, хөнгөлөлттэй холбоотой асуудал нэлээн бас нээлттэй болох ёстой. Нийгмийн эрүүл мэндийн төвтэй холбоотой асуудал дээр бас ялангуяа нийслэл дээр бол асуудал их байгаа юм байна лээ.

Одоогийн мөрдөгдөж байгаа хүчин төгөлдөр байгаа Эрүүл мэндийн тухай хуулиараа нийгмийн эрүүл мэндийн төв гэсэн бүтэц байхгүй хуульдаа. Гэтэл дүүргүүд дээр дандаа нийгмийн эрүүл мэндийн төв гээд бүтэцтэй. Танай Багануур бол нийгмийн эрүүл мэндийн төв гэсэн нэртэй атлаа нэгдсэн эмнэлэгтэйгээ хамт явж байна. Хан-Уул дүүрэг, Сонгинохайрхан дүүргүүд дээр нийгмийн ЭМГ гээд

тусдаа нэг төв, нэгдсэн эмнэлэгтэй. Гэсэн атлаа нөгөө дүүргийн нийгмийн эрүүл мэндийн төв нь нэгдсэн эмнэлэгтэйгээ адилхан. Яг тусламж үйлчилгээ үзүүлдэг ортой. Ийм тийм хуульчлагдаагүй. Нийгмийн эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлэх биш нэгдсэн эмнэлэгтэйгээ адилхан ортой эмнэлгийн үйл ажиллагаа явуулж байгаа асуудлууд асар их байна.

Энийг бид нар энэ хуулийн дараа дагуулаад дараагаар Эрүүл мэндийн тухай хуулиа оруулж ирж энэ бүгдийг цэгцэлнэ ээ. Нийгмийн эрүүл мэнд нь яг нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлдэг тэр эрт илрүүлэг урьдчилан сэргийлэхтэй холбоотой асуудал. Тэгээд иргэний эрүүл мэндийн боловсролтой холбоотой асуудлаа шийддэг. Ийм юм руу оруулахгүй бол бас болохгүй байгаа юм. Энэ хууль дээр аймаг нийслэл дээр нийгмийн эрүүл мэндийн төвийн даргыг нь аймаг, нийслэл, эрүүл мэндийн газрын дарга томилдог болгож байгаа. Ер нь бол Аймгийн нэгдсэн эмнэлгийн даргыг Нийгмийн эрүүл мэндийн төвийг бол Аймгийн эрүүл мэндийн газрын дарга томилдог болохоор Эрүүл мэндийн тухай хуульд өөрчлөлт оруулъя. Харин эрүүл мэндийн газрын даргыг нь яам томилдог ийм тогтолцоо өнөөдөр оръё гэсэн ийм асуудлууд яригдаж байгаа. Би нэг чуулган дээр хэлж байсан юм.

Томилгоотой холбоотой асуудлыг ч гэсэн цэгцлэхгүй бол сумын Эрүүл мэндийн төвийн дарга энэ эмнэлгийн даргыг чинь аймгийн дарга томилж болохоор нэг заалттай, сумын Засаг дарга томилж болох нэг заалттай аймгийн эрүүл мэндийн газрын дарга томилж болох заалттай. Ийм л хуулиа бол бид нар ингээд нэмэлт, өөрчлөлт хийсээр байж байгаад энэ Эрүүл мэндийн тухай хуулиа ийм сонин болгочихсон юм байна лээ. Тийм учраас бид нар яаралтай нэг эрүүл мэндийн

тухай хуулиа бол өөрчлөлт оруулж байна. Анхан шатын эрүүл мэндийн байгууллагууд бол хуучнаараа үйл ажиллагаагаа явуулна.

Гэхдээ дээр нь нийгмийн эрүүл мэндийн энэ урьдчилан сэргийлэхтэй холбоотой асуудлууд дээр нь иргэний эрүүл мэндийн боловсролын гээд ийм бас чиг үүргүүд бас бас энэ анхан шатын эрүүл мэндийн байгууллагууд дээр нэмэгдээд явна л гэж ойлгож байгаа юм.

Ж.Чинбүрэн: Тэгэхлээр би бас ажлын хэсгийн гишүүний хувьд бас 2 гуравхан зүйл нэмээд хэлчихье гэж бодож байна. Ер нь чухал сэдэв хөндөж байна. Сандаг-Очир гишүүний ярьж байгаа гол зүйл бол ер нь бид Нийгмийн эрүүл мэндийг дэмжих төв Эрүүл мэндийг дэмжих төв нь буцаад эмнэлэгтээ дарамттай болж байгаа асуудлыг шийдэх үү гэдэг асуудал. Тэгэхээр бол бид энэ хууль орсноороо урьдчилан сэргийлэх эрт илрүүлэх үзлэг тусдаа. Энэ чинь эрүүл мэндийн хуульдаа хүртэл төсвөөс даах заалт байгаа. Тэгэхээр энэ чиглэлээрээ ингээд явчихна. Харин ЭМД-ын сан бол энэ өвчилсөн хүмүүсийг солидарити гэдэг зарчмаараа эрүүл улсууд нь өвчтэй хүндээ, залуучууд нь ахмадууддаа энэ өвчилсөн үед нь өвчнийг нь даадаг байх ядууралд оруулдаггүй байх энэ тогтолцоог хийх үндсэн утга нь энэ хуульд бий болсноороо бий болно гэж харж байгаа.

Тэгэхлээр би Чинзориг сайдын хэлж байгаа саналтай нэг байна. Ер нь бол эрүүл мэндийн даатгалын сангаасаа хамаг юмаа авсаар байгаад сүүлдээ энэ маань өөрөө ачааллаа ч даахаа болиод болохоо больчихсон.

Жишээлбэл Ковид цар тахлын үед ч гэсэндээ бас ялгаагүй энэ асуудал орж байсан. Тэгэхээр энэ олон нийтийг хамарсан халдварт өвчнийг хүртэл

санхүүжилтийг нь шийдэх том механизм энэ эрүүл мэндийн салбарт орж ирж байгаа. Тэгээд энэ бол үндсэндээ 2 жигүүртэй эрүүл мэндийн салбар маань 2 жигүүртэй сайхан хүчтэй өвчний өвчилсний араас биш өмнө нь явж чадах ийм тогтолцоог хийх түүхэн чухал хуулийг батлахаар бид хэлэлцэн сууж байгаа гэж бодож байгаа.

Сандаг-Очир гишүүн тодруулах зүйл байхгүй бол Бейсен гишүүний микрофоныг нээе. Бейсен гишүүн.

Б.Бейсен: Энэ яах аргагүй олон жил яригдсан хууль орж ирж байгаа л даа. Урьд нь ер нь 80, 90-ээд онд чинь Монгол Улсад Эрүүл ахуйн халдвар судлалын институт аймаг болгонд эрүүл ахуйн халдвар судлал станц гээд байсан юм. Тэгээд сүүлд нь энийг чинь зарим нь Мэргэжлийн хяналт зарим нь нэгдсэн эмнэлэг зарим нь эрүүл мэндийн газарт өгөөд одоо ингээд тараасан юм. Одоо дахиж Нийгмийн эрүүл мэндийн газар гээд ингээд шинээр байгуулагдаж байна л даа. Тэгээд энэ хууль дээр чинь өчигдөр энэ ариутгал халдваргүйжүүлэлтийн албаны 60 жилийн ой дээр энэ ахуйн шавж мэргэчдийн халдваргүйжүүлэлтийн салбарын цаашдын зорилт салбар дундын хэлэлцүүлэг болсон юм. Сайжаа багш тэргүүтэй улсууд. Энэ ажлын хэсгийнхэн Сайжаа багш эд нараас ч бас зөвлөгөө аваад ярьсан юм болов уу? Тэд нар 6 төрлийн санал ярьсан. Туваан гишүүн ярьсан уу? Ярьсан байвал давхардуулахгүй орхичихъё. Яриагүй байвал энэ дээр 1 дүгээрт ариутгал халдваргүйжүүлэлтийн ахуйн шавж мэргэчдийн үед ажиллагааг мэргэжил арга зүйн хувьд чиглүүлэгч зөвлөх мэргэжилтэн ажиллуулах гээд ийм юунд оруул гэсэн.

Нөгөө талаар энэ дамжуулагч шавжны тархалт тэдгээрийн дамжих

халдварын судалгаа, тандалт сэргэлтийн бодлого хөтөлбөр, төлөвлөгөөтэй ажиллах гээд бас ийм санал оруулаа ч гэсэн юм. Нөгөө талаар энэ ахуйн шавж устгалын пестицид дезомфектантууд байна даа. Эд нарын найрлагыг тогтоох тийм баталгаат лабораторитой больё гээд тэгсэн юм. Энэ мэт 8 төрлийн юу ярьж байна л даа. Энэ нийтийн ариун цэврийн байгууламжийн стандарт, тавигдах шаардлага, зарим орны эрх зүйн зохицуулалттай харьцуулаад юм бас оруулаарай энэ хууль дээр гээд тэгсэн юм. Одоо энэ хөдөөд болохоор чинь нөгөө нүхэн жорлонгоос салъя гэсэн. Хөдөөд бараг ер нь төвлөрсөн усан хангамж байхгүй бүгд нүхэн жорлонтой байгаа шүү дээ. Ер нь бараг сумуудаар очоод үзээрэй. Ер нь үнэхээр хүнд байгаа.

Тийм учраас бас энэ хууль дээр бас зарим асуудлуудыг тэр зөвлөх багш нараасаа зөвлөгөө авсан юм болов уу гээд энэ яамныхнаас асууя бас. Тэгэхгүй бол бас учир дутагдалтай хууль баталчихвал сүүлдээ дахиж асуудал гарах вий гээд ийм санал хэлье.

Ж.Чинбүрэн: Бейсен гишүүний асуултад 4 номерын микрофоныг нээе. Ер нь тэгээд энэ эрүүл ахуйн чиглэлээр бас тусдаа бие даасан хууль байдаг учраас Баярболд дарга энийг тайлбарла даа.

Д.Баярболд: Бейсен гишүүний асуултад хариулъя.

Таны асуусан энэ асуултын хувьд бол энэ Эрүүл ахуйн тухай хуулиар бол зохицуулалт байгаа. Дээр нь эрүүл мэндийн тухай хуульд энэ ахуйн шавж мэргэч устгалын асуудлын бүртгэл бодисын хяналтын асуудал тусгай зөвшөөрөл олгох асуудал бол дээрх 2 хуулиар бол зохицуулагдаад явж байгаа. Манай энэ Нийгмийн эрүүл мэндийн

тусламж үйлчилгээний хуульд халдварт болон халдварт бус өвчний хяналт сэргийлэлтийн асуудал дотроо энэ ариутгал халдваргүйтгэл, шавж, мэргэчгүйтлийн асуудлаа бол тусгаад явах бол бүрэн боломжтой байгаа.

Ж.Чинбүрэн: Тэгээд сая Бейсен гишүүний хэлсэнчлэн ер нь мэргэжлийн улсуудтай байнга холбоотой зөвлөгөө авч, тэдгээрийн асуудлуудыг сонсож, тэр болгонд нь хариултууд энэ хуульдаа энэ асуудлууд нь шийдэгдэж байгаа эсэх талаас нь байнга хянаж байгаа байх гэж бодож байна. Ингээд гишүүд асуулт асууж дууслаа.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд заасны дагуу Улсын Их Хурлын даргаас гүйцээн боловсруулах чиглэл өгсөн зарчмын зөрөөтэй 2 саналаар санал хураалт явуулна аа.

1.Төслийн 4 дүгээр зүйлийн гарчгийн “Үйл ажиллагаанд баримтлах” гэснийг “Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний” гэж, 4 дүгээр зүйлийн 4.1.3 дахь заалтын “нотолгоонд” гэснийг “судалгааны үр дүн, нотолгоонд” гэж тус тус өөрчилж, 4.1.1 дэх заалтын “, тэгш хүртээмжтэй, чанартай” гэснийг хасаж, мөн зүйлд доор дурдсан агуулгатай дараах заалт нэмэх:

“4.1.8.чанар, үр ашигтай байх;

4.1.9.тэгш хүртээмжтэй байх;

4.1.10.жендэрийн эрх тэгш байдлыг хангах.

Санал хураалт.

72.7 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Дараагийн санал хураалт.

2.Төслийн 5 дугаар зүйлийн 5.2 дахь хэсэг, 5.2.1 дэх заалтыг нэгтгэн доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“5.2.Энэ хуулийн 5.1.1-д заасан нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх хүрээнд дараах үйл ажиллагаа явуулна:

5.2.1.халдварт болон халдварт бус өвчний эрсдэлт хүчин зүйлийн тархалтыг тандан судлах, тодорхойлох, урьдчилан сэргийлэх, хянах арга хэмжээг орчин үеийн болон уламжлалт анагаах ухааны судалгааны үр дүн, нотолгоонд суурилан зохион байгуулах;

5.2.2.нийгмийн эрүүл мэндийн мэдээллийн сан бүрдүүлэх, мэдээ, мэдээлэлд дүн шинжилгээ хийх.”

Санал хураалт явуулъя.

72.7 хувийн саналаар дэмжигдлээ.

3 дахь нь. Анхны хэлэлцүүлгээр дэмжигдсэн боловч Байнгын хорооны хуралдааны эцсийн хэлэлцүүлгээр дахин санал хураалт хураалгах шаардлагатай гэж гишүүдийн 3-ны 2 нь үзсэн бол тухайн асуудлаар дахин санал хураалгах дэгийн заалтын хүрээнд зарчмын зөрөөтэй нэг санал байна аа.

Санал хураалт.

Нөгөө байгууллагын гэдгийг.

72.7 хувиар санал дэмжигдлээ.

Зарчмын зөрүүтэй саналаар санал хураана.

Төслийн 19 дүгээр зүйлийн 19.4 дэх хэсгийн “байгууллагын” гэснийг

хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Санал хураалт.

72. 7 хувиар батлагдлаа. Ингээд хэлэлцэх эхний асуудал дууслаа. Баярлалаа.

Хоёр дахь асуудал руугаа орно.

11.16 цагт

Танилцуулгаа уншичихъя.

Засгийн газраас 2023 оны 10 сарын 13-ны өдөр өргөн мэдүүлсэн Хүүхэд хамгааллын тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн бусад хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг хийе ээ.

Хүүхэд хамгаалалттай холбоотой ажлын дэд хэсгийг оруулъя.

Нийгмийн эрүүл мэндийн тусламжийн тухай хуулийн эцсийн хэлэлцүүлэг хийсэн талаарх танилцуулгыг Сарангэрэл гишүүн танилцуулна аа.

Ажлын дэд хэсгийн нэрсийг өгөөрэй. Ажлын хэсгийн танилцуулгыг ажлын хэсгийн ахлагч Улсын Их Хурлын гишүүн Цагаанхүүгийн Идэрбат таньг анхны хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх танилцуулгыг хийж өгөхийг урьж байна.

Ц.Идэрбат: Монгол Улсын Засгийн газраас 2023 оны 10 сарын 13-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Хүүхэд хамгааллын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн бусад хуулийн төслүүдийг Улсын Их Хурлын гишүүн С.Одонтуяа нарын эмэгтэй гишүүдээс 2021 оны 3 сарын 5-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн.

Хүүхэд хамгааллын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй нэгтгэн Байнгын хороо болон чуулганы хуралдаанаар хэлэлцүүлэх бэлтгэл хангах ажлын хэсгийг Нийгмийн бодлогын байнгын хорооны 2023 оны 11 сарын 7-ны өдрийн 14 дүгээр тогтоолоор байгуулан ажлын хэсгийг Улсын Их Хурлын гишүүн Ц.Идэрбат ахалж, гишүүдээр Улсын Их Хурлын гишүүн П.Анужин, Б.Баярсайхан, Б.Бейсен, Б.Жаргалмаа нарын гишүүд ажиллалаа.

Ажлын хэсэг хүүхэд хамгааллын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллагууд, иргэд олон нийтийн төлөөлөл, Засаг дарга, хамтарсан багийн гишүүд, нийгмийн ажилтнууд, хууль, шүүх, цагдаа, хүүхдийн эрхийн хууль зүйн хорооны гишүүд, Хүний эрхийн Үндэсний Комисс, Боловсролын салбар, Эрүүл мэндийн салбарын эмч, өрхийн эмнэлгийн төлөөлөл, цахим хөгжил, харилцаа холбооны яам, харьяа агентлагууд, олон суваг дамжуулах байгууллагын төлөөлөл, хүүхдийн асрамжийн газар, хүүхэд хамгааллын төв, нийслэлийн холбогдох газрууд, соёл, спортын салбар, гамшиг, онцгой байдлын алба хамтарсан багийн гишүүдтэй уулзалт зохион байгуулж хуулийн төслийг хэлэлцүүлж санал авсан болно.

Ажлын хэсэг нийт 10 удаагийн салбар, хэлэлцүүлэг, хуулийн төслийг ди парламент, цахим хуудаст байршуулан иргэдээс ирүүлсэн саналыг үндэслэн Засгийн газраас өргөн мэдүүлсэн Хүүхэд хамгааллын тухай хуулийн шинэчилсэн найруулгын энэ төслийг суурь болгон Улсын Их Хурлын гишүүн С.Одонтуяа нарын эмэгтэй гишүүдээс Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Хүүхэд хамгааллын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг нэгтгэн нийт зарчмын зөрөөтэй 30 санал найруулгын

шинжтэй нэг санал дагасан хуулийн төслийн хүрээнд 20 зарчмын зөрөөтэй саналыг боловсрууллаа.

Үүнд: Эцэг эхийн үүрэг, хариуцлагыг нэмэгдүүлж хүүхдийн дэргэд согтууруулах ундаа хэрэглэх, хэрэглэсэн үедээ бусдын орон байранд нэвтэрч хүүхдийг эрсдэлт нөхцөлд оруулахыг хориглох, эцэг, эх, асран хамгаалагч, соёл, спортын арга хэмжээнд хүүхдээ оролцуулахдаа гэнэтийн ослын даатгалд хамруулах, үе тэнгийн дээрэлхэлт үйлдсэн хүүхдийн хамтаар сэтгэл зүйн зөвлөгөө, үйлчилгээ, төлөвшилд нөлөөлөх сургалт, үйл ажиллагаанд хамрагдах. Боловсролын салбар дахь хүүхэд хамгааллын хүрээг өргөжүүлж багш, боловсролын багш, боловсролын сургалтын байгууллагад хүүхэд хичээлдээ тодорхойгүй шалтгаанаар ирээгүй тохиолдолд нэн даруй эцэг эхэд мэдэгдэх, эрсдэлт нөхцөлд хүүхэд өртсөн тохиолдолд холбогдох ажилтанд мэдэгдэх, хүүхдийн эрх хамгааллын нөхцөл байдлын үнэлгээг хийх, эцэг эхийн зөвлөл нь хүүхдийн эрх хамгааллын бодлоготой байх, Цахим орчин дахь хүүхэд хамгааллын хүрээг өргөжүүлж, хэвлэл мэдээлэл өргөн нэвтрүүлэг цахим орчинд хүүхдийг хортой, хориотой мэдээлэл, контентоос хамгаалах чиглэлээр холбогдох байгууллагуудад дотооддоо авч хэрэгжүүлэх арга хэмжээг зааж, цахим орчинд хүүхдийг урхидах, дээрэлхэх, дарамтлахыг хориглосон.

Соёл спортын салбарт хүүхдийн оршин суугаа газраас өөр газарт 24 цагаас дээш хугацаагаар арга хэмжээнд оролцуулсан тохиолдолд 15 хүүхэд тутам заавал нэг хүн харгалзан явах. Аливаа төрлийн хурдан морины уралдааныг зохион байгуулагч заавал харьяа орон нутгийн захиргаанд мэдэгдэх. Уралдаанч хүүхдийн эрх аюулгүй байдлыг хангах хүрээнд морь

уралдуулж байгаа морины өмчлөгчид үүрэг хариуцлагыг хүлээлгэхээр, гамшиг онцгой байдлын нөхцөлд хүүхдийн амь нас, эрүүл мэндийг эрсдэлт нөхцөлд оруулан байгаа газраас нь авч явах болон тээвэрлэхийг хориглох, хүүхэд хамгаалал, удирдлага, зохион байгуулалтын хүрээнд хүүхдийн эсрэг болон хүний бэлгийн эрх чөлөө халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг үйлдэж эрүүгийн хариуцлага хүлээсэн хүнийг хүүхдийн байгууллагад ажиллуулахыг хориглох, сум хорооны 3 мянга хүртэлх хүн амд нэг хүүхэд, гэр бүлийн нэг хүүхэд, гэр бүлийн нийгмийн ажилтан байхаар тооцож ажиллуулах, тэдгээрийн нийгмийн баталгааг боловсролын нийгмийн ажилтны нэгэн адил тогтоох, хүүхдийн эрхийн хууль зүйн хорооны даргыг Засаг дарга эсвэл хуулийн асуудал хариуцсан нэгжийн дарга байхаар, Хүүхдийн эрхийн хууль зүйн хороо болон хамтарсан багийн санхүүжилт үйл ажиллагааны зардлыг харьяа газар орон нутагт нь төсвийн төсөлдөө заавал тусгаж эрх бүхий этгээдээр батлуулан хэрэгжилтэд хяналт тавихаар, Хүүхэд хамгааллын хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах хяналтыг сайжруулах хүрээнд орон нутаг нь хэрэгжүүлсэн ажлынхаа тайланг жил бүрийн 2 дугаар сард Хүүхэд гэр бүл хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлж, Хүүхдийн төлөө үндэсний зөвлөл нэгтгэсэн тайланг хэлэлцэн дүгнэж шаардлагатай тохиолдолд холбогдох этгээдэд чиглэл өгч ажиллахаар, энэ хуулийн 2024 оны 9 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөхөөр зарчмын зөрүүтэй саналыг боловсрууллаа.

Мөн хуулийн төслийг дагасан нийт 14 хуулийн төслөөс Гэр бүлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах Иргэний бүртгэлийн тухай хуульд нэмэлт оруулах, онц байдлын тухай хуульд нэмэлт оруулах хуулийн

төслүүдийг хууль санаачлагдан буцаах болон Хүүхдийн эрхийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд сум дүүргийн Засаг дарга нь баг хороо бүрдээ хүүхдийн эрхийн олон нийтийн байцаагч ажиллуулж болохоор, Нийгмийн халамжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд хүүхдийн мөнгөн тэтгэмжийг зээл өр төлбөрт суутгахыг хориглох болон эцэг эх нь тэжээн тэтгэх үүргээ биелүүлээгүй, хүүхдийн эрхийг зөрчсөн нь тогтоогдсон хүүхдийн мөнгөн тэтгэмж олгох асуудлыг түдгэлзүүлэх асуудлыг тус тус тусган хуулийн төслийг боловсруулаа.

Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Ажлын хэсгээс бэлтгэсэн зарчмын зөрүүтэй саналыг хэлэлцэн ишийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье.

Ж.Чинбүрэн: Идэрбат гишүүнд баярлалаа.

Ажлын хэсгийг танилцуулъя. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Гэр бүлийн бодлогын хэрэгжилтийн зохицуулах газрын дарга Баярмаа, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Хуулийн хэлтсийн дарга Ренчиндорж, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Хүүхдийн эрхийн хэрэгжилтийн бодлого зохицуулалт хариуцсан мэргэжилтэн Азжаргал, Хуулийн зөвлөх өмгөөлөгч Баттулга,

Гэр бүл хүүхэд хөгжлийн газрын даргын албан үүргийн түр орлон гүйцэтгэгч Өлзийхутаг, Цахим хөгжил харилцаа холбооны яамны Хуулийн хэлтсийн дарга Нямдорж, Боловсролын ерөнхий газрын дарга Ням-Очир, БШУЯ-ны ерөнхий боловсролын газрын СӨБ-ын хэлтсийн дарга Мягмар, БШУЯ-ны шинжээч Дуламсүрэн,

Харилцаа холбооны зохицуулах хорооны Зохицуулалтын бодлогын хэрэгжүүлэх газрын ахлах шинжээч Уранчимэг, Цахим харилцаа холбооны яамны мэргэжилтэн Оюун-Эрдэнэ Биеийн тамир спортын газрын ахлах мэргэжилтэн Мөнх-Эрдэнэ, Эрүүл мэндийн яамны Эмнэлгийн тусламж үйлчилгээний газрын мэргэжилтэн Пүрэвжав, Эрүүл мэндийн яамны Нийгмийн эрүүл мэндийн газрын мэргэжилтэн Оролзодмаа байгаа юм уу? Эрүүл мэндийн яамны Нийгмийн эрүүл мэндийн газрын мэргэжилтэн Ундрал. Болормаа гэж байна хурандаа Цагдаагийн ерөнхий газар алга байна.

Ажлын хэсгийн ахлагчийн танилцуулгатай холбоотой холбогдуулан асуулт асуух гишүүдийн нэрс өгнө үү? Баярсайхан гишүүнийг оруулаарай. Энэ дарагдахгүй байгаад байх юм. Баярсайхан гишүүнээр тасаллаа. Баярсайхан гишүүний микрофоныг нээе.

Б.Баярсайхан: Өнөөдөр Хүүхэд хамгааллын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг хэлэлцэж байгаа. Энэ бол одоо маш чухал хуулийн төсөл.

Монгол Улсын үндсэн хуулийн 16.11-д гэр бүл, эх нялхас, хүүхдийн ашиг сонирхлыг төр хамгаална гэж заасан. Энэ хуулиар бид энэ амлалтаа энэ хуулийг биелүүлэх түүхэн боломж гэж өнөөдөр харж байгаа. Өнөөдөр манай улсад 3 хүн тутмын нэг нь хүүхэд байгаа. Дэлхийн банкны 2020 оны ядуурлын дүр төрх судалгаагаар 5 ядуу хүн тутмын 2 нь өнөөдөр хүүхэд байна гэсэн ийм судалгаатай. Энэ статистик нь мэдээ нь манай улсад хүүхэд хамгийн эмзэг нөхцөлд байдаг. Монголд хүүхдийн ядуурал ямар их байгааг ингэж харуулж байгаа. Өнөөдөр бид энэ хуулиараа тогтолцоог биш хүнийг хүүхдийг хамгаалах гэж энэ хуулийг батлах гэж байгаа гэдгээ бид нар маш сайн

ухамсарлах ёстой шүү. Тогтолцоо нь хүүхдээ хамгаална. Бид нар хүүхдээ 1 дүгээрт тавина гээд.

Тэгэхээр хэд хэдэн санаа байгаа. Юуны өмнө хэлэхэд энэ одоо Гэр бүл хүүхэд залуучуудын газар гээд одоо яг энэ хүүхдийн эрхийг хамгаалах гол газар байж байна. Бүтэц юмнуудад нь өөрчлөлт хийгдэж байгаа гэсэн. Энэ агентлаг маань одоо жил тойрон байна уу, энэ үүрэг гүйцэтгэгчтэй ингэж яваад байна аа. Яагаад хүүхдийн асуудал ийм эмзэг байхад энэ агентлагийн даргыг одоо болтол ингэж томилохгүй ингээд байгаад байгаа юм бэ? Энэний ар талд ямар асуудал байдаг юм бэ? Энэ дээр нэлээн бухимдаж байна.

Өлзийхутаг дарга чадлаараа сайн ажиллаж байгаа. Гэхдээ ингээд үүрэг гүйцэтгэгч явж байна гэдэг чинь тухайн ажлыг ингээд хийсэн ч нэг сэтгэлд нь сэвтэй байна. Тухайн байгууллагыг удирдахад ч гэсэн энэ бол төдийлөн хүмүүсийн хандлага, энэ ажил хийхэд бас ингээд төвөг бэрхшээл ингээд учруулж байдаг шүү. Тэгээд энийг бас энэ хууль хэлэлцэж байгаа үеэр хэлмээр байна аа.

Тэгээд энэ салбарын сайд бас энэ орж ирж энэ юугаа сонсвол их сайн байна гэж хэлмээр байна.

Нэгдүгээрт нь энэ хөдөлмөр эрхэлж байгаа хүүхдийн хүүхэд хамгааллын асуудал ер нь бол хангалтгүй байгаа. Энэ хөдөлмөрийн тухай хуульд хөдөлмөр эрхэлж болох насны доод хязгаарыг 13 гэж заасан. Тэгвэл хүүхэд ажиллаж, хөдөлмөрлөж байгаа орчиндоо хэрхэн хамгаалагдаж байгаа юм. Ямар нөхцөл баталгаагаар хангагдах асуудлыг бид нар нарийн үзэж анхаарах ёстой. Тиймээс энэ хуульд хүүхэд ажиллаж байгаа орчин гэсэн

зүйлийг нэмэх ийм саналтай байгаа гэдгээ бас хэлье ээ.

Хуулийн хэлэлцүүлэг, ажлын хэсгийг ахалж байгаа Идэрбат гишүүний маш сайн идэвхтэй энэ салбар болгон дээр ингээд хэлэлцүүлэг хийгээд мэргэжлийн болон ТББ, ОУБ-ынхныг оруулаад санаа оноог нь сонсоод явж байгаа дээр би баяртай байгаа. Гэсэн ч гэсэн дэд ажлын хэсэг ялангуяа энэ хуулийн зүйл заалт дээр л яг одоо бид нарыг бид нарт гарсан боломж шүү гэж нэлээн сэтгэлтэй бас ажиллах ёстой гэдгийг хэлмээр байна аа. 1.7 дээр байгаа энэ үе тэнгийн дээрэлхэлт гэж нэг буюу хэд хэдэн хүүхэд өөр нэг буюу хэд хэдэн хүүхдийг бие махбод сэтгэл санааны хувьд гэмтээх, зовоох, ялгаварлан гадуурхах, айлган сүрдүүлэх, заналхийлэх зорилготой зорилготой түрэмгий зан үйлээ санаатайгаар удаа дараа биеэр амаар болон цахим орчинд үйлдэхийг гэж оруулсан. Удаа дараа биш бол бас үе тэнгийн дээрэлхэлт гэж үзэхгүй байж бас болохгүй ээ.

Тийм учраас энэ ямар нэгэн байдлаар энэ дээрэлхэлт гадуурхалтыг бид нар хаах зорилготойгоор энэ хуульдаа бас оруулах шаардлагатай гэж ингэж үзэж байна. Энэ хэвлэл мэдээллийн орчинд хүүхдийг хамгаалах гээд энэ маш чухал заалт байгаа.

Өнөөдөр Монгол Улсад бараг 200 гаруй телевиз үйл ажиллагаа явуулж байгаа. Энэ дээр бол энэ хүүхдийг хэвлэл мэдээллийн орчинд.

Ж.Чинбүрэн: Баярсайхан гишүүн хариулт авах уу?

Сарангэрэл гишүүн нэг зарчмын зөрүүтэй санал хэлье гэж байна.

Д.Сарангэрэл: Энэ Чинбүрэн дарга аа? Энэ Хүүхэд хамгааллын тухай хууль бол бас их олон жил дунишиж

байгаа, олон нийтийн зүгээс хүлээлттэй байгаа ийм хуулийн төсөл юм байгаа юм. Тэгээд өнөөдөр хүүхдийн эрхийн асуудал ямар байгаа юм. Хүүхдээ бид нар хэрхэн яаж хамгаалж байгаа гэдгийг нийгмээрээ шүүмжилж байгаа. Бид үүнийг ч хүлээн зөвшөөрөх ёстой. Яг Засгийн газрын бүтцийн хувьд нэлээн хэд хэдэн бүтэц бий тэр дундаа Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яаманд бол нэг бүтэц нь байж байгаа юм аа.

Тэгээд хүүхэд хамгаалал, ахмад эмэгтэйчүүд, хөгжлийн бэрхшээлтэй гээд нийгмийн хамгааллын бүх чиглэлүүд энэ Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яаманд төвлөрч байгаа. Тэгээд ийм чухал хууль хэлэлцэж байхад салбарын сайд байхгүй. Сая би Баярсайханыг зөв хэллээ гэж бодож байна. Тэгээд гишүүдийн бас оролцоо хангалтгүй байгаа учраас ийм чухал хуулийг ийм байдалтайгаар хэлэлцэж би болохгүй гэж бодож байна. Тийм дөрөвхөн гишүүн байна. Тэгээд би энэ хуулийн төслийг бол сайдыг нь байлцуулаад ингээд зарчмын дагуу хэлэлцүүлэх ёстой энэ хуулийн төслийг би хойшлуулах ёстой гэсэн ийм саналыг гаргаж байна.

Ж.Чинбүрэн: Булгантуяа сайд орж ирж байна уу? Ер нь Сарангэрэл гишүүн чухал сэдвийг хөндлөө шүү. Энэ чухал хуулийг бид бас бүрэлдэхүүн нэлээн чамбай байж хэлэлцэх энэ асуудлаа зүйл бүрдээ. Бид 50 гаруй санал хураалт явагдана. Нийгмийн эрүүл мэндийн тусламжийн тухай хууль дээр бол Эрүүл мэндийн яам мэргэжилтнүүд бүгд бүрэн бүрэлдэхүүнтэй сууж гишүүд маш идэвхтэй санал асуулаа.

Салбарын сайд байхгүй байгаа учраас асуудлыг хойшлууллаа.

Ажлын хэсгийнхэн нь гарч байна уу.

3 дахь асуудал руугаа орёе. Та хэд байж байгаарай. Түр хойшлуулсан учраас түр байж байгаарай.

Хэлэлцэх 3 дахь асуудал.

Монгол Улсын Их Хурлын 23 оны 6 дугаар сарын 30-ны өдрийн 60 дугаар тогтоолоор байгуулсан Эмийн үнийн өсөлтийн шалтгаан нөхцөлийг хянан шалгах түр хорооны ажиллах хугацааг сунгах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэж эхэлье ээ.

Хянан шалгах түр хорооны ажиллах хугацааг сунгах тухай саналаа уншиж танилцуулъя.

Тэгвэл 2 дахь асуудлаа үргэлжлүүлэн хэлэлцье.

Ажлын хэсгээ оруулчих ажлын хэсгээ оруулъя. Юу ч гэсэн орж байг орж байг.

Би хүүхэд хамгааллын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн талаарх хуулийн хэлэлцүүлгээ үргэлжлүүлъя. Түрүүн Баярсайхан гишүүн асуулт асуусан.

Үүнд ажлын хэсгийн ахлагч Идэрбат гишүүн хариултаа өгье.

Ц.Идэрбат: Баярсайхан гишүүний асуултад хариулъя.

Ер нь сая танилцуулга дээр энэ хүүхэд хамгааллын энэ хууль Засгийн газраас өргөн баригдсан. Хэдийгээр Засгийн газраар өргөн баригдсан ч гэсэн ажлын хэсгийн хувьд дэд ажлын хэсгийн хувьд бол бас энэ Хүүхэд хамгааллын хуулийг яг анхан шатад хэрэгжүүлж байгаа дунд болон удирдлагын түвшинд ч ажиллаж байгаа энэ л төрийн байгууллагуудтай төрийн бус байгууллагуудтай нэлээдгүй уулзалтыг хийсэн. Энэ уулзалт дээрээс зарчмын

олон саналууд бас гарсан. Энэ хуулийн төсөлд бас өргөн баригдаагүй олон зүйлүүд байна гэдэг ийм зүйлүүдийг ярьсан. Гишүүдийн асуултад хариулахад хөдөлмөр эрхлэлттэй холбоотой асуудалд бол хүүхдийн бүх төрлийн мөлжлөг, хөдөлмөрийн мөлжлөг, бэлгийн мөлжлөг эндээс энэ хүүхэд хамгааллын энэ тогтолцоо бол хамгаална гэсэн ийм зүйл заалтууд орсон.

Хөдөлмөрийн хууль дээрээ бол бас 13-аас 15 насны хүүхэд өөрийн өсөлт бусад зүйлээр хохироохгүйгээр хөдөлмөрийн хөнгөн нөхцөлд ажиллах боломжтой гэсэн ийм л зүйл заалт хэрэгжиж байгаа. Тэрний хүрээнд харин хөдөлмөрийн мөлжлөгөөс сэргийлэх ийм асуудлууд тусгагдсан. Үе тэнгийн дээрлэлт гэдэг бол бас үнэхээр тийм нухацтай хандахаар ийм асуудал болсон юм билээ. Тийм учраас ер нь энэ хүүхэд хамгааллын хуулийн нэг томоохон хэсэг нь бол энэ цахим орчин дахь хэвлэл мэдээллийн хэрэгсэл дэх энэ хүүхэд хамгааллын асуудлууд байгаа. Тэрэн дотроо энэ хүүхдийн үе тэнгийн дээрлэлт гэдэг энэ зүйлүүд ер нь хөдөө хотгүй бий болсон. Ийм л зүйл байгаа юм байна лээ.

Тэгэхээр энэ дээр ямар нэгэн зохицуулалт зайлшгүй хэрэгтэй. Тийм учраас энэ хүүхдийн үе тэнгийн дээрлэлтийн асуудлыг нэлээн нухацтайгаар бас оруулж ирж байгаа. Тэгэхээр дээрлэхэж байгаа нь ч тэр дээрлэхүүлж байгаа нь ч тэр хоёулаа л хүүхэд. Эхний ээлжид энэ үе тэнгийн дээрлэлтийг хийж байгаа энэ хүүхдүүдэд сургууль боловсролын байгууллагын зүгээс бас анхааруулах үе тэнгийн тэр хүүхдүүдийг хооронд нь бас нэг уулзаад уучлалт гуйх тийм орон зайг 1 дүгээрт бий болгож байгаа. Ер нь энэ байдал удаа дараа давтагдах юм бол цаашидаа эцэг эхтэй нь энэ асуудлыг

ярихаас өөр аргагүй байдалд орох юм билээ.

Тийм учраас энэ эцэг эхийн үүрэг оролцоог энэ нь үе тэнгийн дээрлэлтийн асуудалд бас оруулж ирж байгаа. Би түрүүнд хэлсэн ер нь бидний энэ нэг 10-аад удаагийн уулзалтуудаар ингээд анзаарч байхад нөгөө бүх зам Ром хүрнэ гэдэг шиг ер нь явж явж бүх л энэ нөхцөл яг тэр хүүхдийн эцэг эх рүү л яг чиглэх юм байна лээ. Тэгэхээр ер нь энэ хуулийн бас нэг том зүйл бол өөрчлөлтийн зүйл энэ эцэг эх рүү нэлээн хариуцлага юмнуудыг нь нэлээн чиглүүлсэн ийм л хуулийн төсөл бэлтгэгдсэн гэж ингэж хэлье. Баярлалаа.

Ж.Чинбүрэн: Байнгын хороон гишүүд асуулт асууж хариулт авч дууслаа.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39.10-д заасны дагуу Байнгын хороо хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэнэ.

Гишүүд хуулийн төслийн тухай зүйлтэй холбогдуулан хууль санаачлагчаас асуулт асууж болно оо. Зарчмын зөрүүтэй саналын хүрээнд ажлын хэсгийн ахлагчаас асуулт асууж болно оо.

Ингээд төслийн 1.1 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу? Алга байна. Санал гараагүй байна.

Төслийн 1.2 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу? Жаргалмаа гишүүн байхгүй юм байна. Асуулт байгаа санал гараагүй.

Төслийн 1.3 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу? ажлын хэсгээс бэлтгэсэн зарчмын

зөрүүтэй нэг санал байгаа. Унишж танилцуулъя. Төслийн 1.3 дугаар зүйлийн 4 дэх хэсгийг хасах санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Идэрбат, Анужин, Баярсайхан, Бейсен, Жаргалмаа цаашид ажлын хэсэг гэнэ.

Санал хураалт.

Гишүүд санал хураалт хийж байна шүү.

55.6 хувиар дэмжигдлээ.

Төслийн 1.4 дээр саналтай гишүүд байна уу? Байхгүй байна.

Ажлын хэсгээс бэлтгэсэн зарчмын зөрүүтэй нэг саналтай.

2.Төслийн 1.4 дүгээр зүйлийн 1.3 дахь заалтын “учруулахуйц үл хайхрах” гэснийг “учруулах” гэж өөрчилж, мөн заалтын “сэтгэл санаа,” гэсний дараа “эдийн засаг” гэж, мөн зүйлийн 1.12 дахь заалтын “кейс менежмент” гэсний өмнө “тохиолдлын зохицуулалт” гэж тус тус нэмж, 1.11 дэх заалтын “хүүхдийн эцэг, эх болон хүүхдийн эцэг, эхтэй гэрлэсэн хүн ороогүй, түүнчлэн” гэснийг, мөн зүйлийн 2 дахь хэсгийг тус тус хасаж, мөн зүйлийн 1 дэх хэсэгт доор дурдсан агуулгатай 1.6, 1.15, 1.16 дахь заалтыг тус тус нэмэх:

“1.6. “хүүхдийг үл хайхрах” гэж хүүхдийн аюулгүй байдал, боловсрол, эрүүл мэнд, бие махбод, сэтгэл санаа, хөгжил, оролцооны хэрэгцээг гачигдуулсны улмаас хүүхдэд гэм хор учруулсан болон учруулахаар завдсан, эсхүл энэ нөхцөл байдлыг мэдсээр байж хүүхдийг хамгаалах, урьдчилан сэргийлэх арга хэмжээ аваагүй эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч, хуулиар үүрэг хүлээсэн бусад этгээдийн үйлдэл, эс үйлдэхүйг;

1.15. “хориотой агуулга” гэж хуулиар хориглосон контент, бүтээл, мэдээ, мэдээлэл, зар сурталчилгааг;

1.16. “хүүхдэд хортой агуулга” гэж хуулиар хориглоогүй боловч хүүхдийн эрүүл мэнд, нас, бие махбод, оюун санаа, ёс суртахууны хөгжил, төлөвшил, хүмүүжилд сөргөөр нөлөөлөх контент, бүтээл, мэдээ, мэдээлэл, зар сурталчилгааг.

Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

Байж байгаарай. Мөнх-Оргил гишүүн асуулт байна.

Мөнх-Оргил гишүүний микрофоныг нээгээрэй.

Ц.Мөнх-Оргил: Баярлалаа. Ажлын хэсгээс асууя.

Энэ 1.6-г хүүхдийг үл хайхрах гэдгийг нөгөө юу гэж ойлгоод байна шүү дээ. Нөгөө *neglens* гэдгийг л та хэд үл хайхрах гэж л орчуулаад байна. Хүүхдээ асрахгүй, хамгаалахгүй, хариуцлагагүй хандах гэж. Тэгээд хүүхдийг үл хайхрах гэдэг үг чинь Монгол хэлэн дээр буухгүй байна шүү дээ. Энийг нэг өөр үгээр л солимоор байх юм. Нөгөө *neglens* гэдэг үгний тэрийг дагалдаж гарч байгаа агуулга нь болохлоор энэ дотор байгаад байгаа юм.

Хоёрдугаарт учруулахаар завдсан биш завдана гэдэг чинь санаатай үйлдэл байгаа байхгүй юу. Завдалт энэ үл хайхрах *neglens* чинь буюу нөгөө илүү болгоомжгүй талдаа байхгүй юу. Ерөөсөө нөгөө хэнэггүй болгоомжгүй тэрнээсээ болоод хүүхдийн амь нас эрүүл мэнд сайн сайхныг аюулд учруулчхаж байгааг л хэлээд байгаа шүү дээ. Тэгэхээр энэ чинь өөрөө энэ нөгөө *charald neglens* гэдэг

үгээрээ тэр эрх зүйн агуулгаараа явж байх юм бол энэ чинь нэлээн гүнзгий агуулгатай хууль, эрх зүйн санхүүтэй шийтгэлтэй зүйл байхгүй юу? Их тийм агуулгатай үүрэг араасаа чирч явж байдаг.

Эсхүл энэ нөхцөл байдлыг мэдсээр байж хүүхдийг хамгаалах урьдчилан сэргийлэх арга хэмжээ аваагүй гэж. Жишээ нь мэдсээр байж байж аваагүй байх бол хүүхдийг үл хайхрахаас илүү ноцтой юм болж байгаа байхгүй юу. Мэдэх ёстой байх ёстой байхгүй юу, мэдэх ёстой. Ямар ч эцэг эх ямар ч хүн ингээд хүүхдээ юу гэдэг юм халуун зун машинд нь түгжиж хаячхаад хэдэн цагаар гараад явчих юм бол тэр бол 1 дүгээрт мэдэж байсан.

Хоёрдугаарт би мэдээгүй гэж хэлэх юм бол мэдэж байх ёстой байсан гэдэг агуулга орж ирэх байхгүй юу. Тэгэхлээр энэ дээр үгийг нь солимоор байна. Тэгээд би бол ийм саналтай байна дарга аа. Юуг нь саналыг зарчмын хувьд дэмжчихье тэгэхдэ үг үсгийг нь сольё, эргэж харъя. Илүү Монгол хэлэн дээр буусан энэ агуулгыг бүрэн зөв гаргасан үг хайж олъё тэгэх үү? Жишээ нь ийм байхгүй юу? Charles neglens гэдэг эрүүгийн хариуцлагатай байх ёстой байхгүй юу. Эрүүгийн хариуцлагатай байх ёстой. Тэгэхдээ энэ үйлдлээсээ болоод хөнгөн юм уу хүндэвтэр гэмт хэрэг байх ёстой тийм. Тэгэхлээр энийгээ дагаад энэ чинь Эрүүгийн хуульд заалт байхад. Миний өөрийн хүүхэд учраас би энийгээ яаж ч болно гэдэг сэтгэхүй байж болохгүй шүү дээ.

Ихэнх тохиолдолд зөрчлийн шинж агуулах ёстой. Тэгэхлээр энийгээ хэдүүлээ энэ шүүгч прокуроруудтай яриад, энэ дээр ямар энэ хүүхдийг үл хайхрах буюу neglens гэдэг чинь ингээд энэ Хүүхэд хамгаалах хуулиас гадна Зөрчлийн болон Эрүүгийн хуульдаа суух юм уу, суухгүй юм уу гэдэг юмнуудаа бас

хэдүүлээ нэг ярьчихмаар байна. Тэгээд агуулгаар нь санал хураагаад томъёоллыг нь хэдүүлээ эргэж ярьж тэгэх үү? Би энэ дээр прокуроруудтай зөвлөлдөж шүүгч нартай зөвлөлдөж би бас.

Ж.Чинбүрэн: Мөнх-Оргил гишүүн бас яг хууль зүй талаасаа хуулийн үр дагаврын талаар бас чухал санаанууд хэллээ. Тэгэхлээр энэ үгийн орчуулга үгийн хэрэглээ дээрээс нь бас энэ агуулгын хувьд учруулан болон учруулахаар завдсан гэдэг нь яг л санаатай үйлдэл болох гээд байна тийм ээ. Тэгээд мэдсээр байж гэдэг бас юмыг хэллээ. Тэгэхээр хэдүүлээ энэ дээр зүгээр шууд гүйцээн боловсруулах гээд орхичихвол яадаг юм болохгүй юу? Саналаа хураачхаад. Энэ дээр саналаа хураачхаад дараа нь нэр томъёог нь илүү хууль эрх зүйн талаас нь илүү зохимжтой болгох тал дээр тодруулна гэж тохироод санал хураачихъя. Агуулгаар нь дэмжье гэдэг утгаар санал хураалт явуулья.

66.7 хувиар санал дэмжигдлээ.

Тэгэхээр энэ дээр бас та бүхэн үг найруулгаа бас анхаарахаар тохирлоо шүү.

Төслийн 1.5 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу? Байхгүй байна. Ажлын хэсгээс бэлтгэсэн зарчмын зөрүүтэй нэг саналтай.

Төслийн 1.5 дугаар зүйлийн 1.5 дахь заалтыг хасаж, мөн зүйлийн 2 дахь хэсгийн “хүүхдэд зааж сургахдаа” гэснийг “хүүхэдтэй харилцахдаа” гэж өөрчлөх сурталчилгааг

Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

66.7 хувиар санал дэмжигдлээ.

Төслийн 2.1 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу? Алга байна санал гараагүй.

Мөнх-Оргил гишүүн микрофоныг нээе.

Ц.Мөнх-Оргил: Энэ 1.5 чухал заалт байгаа юм л даа. Нөгөө хүүхэд хамгааллын зарчим гээд. Тэгээд өөрөөр хэлбэл дараа нь энэ хуулийг хэрэглэж байхад хэрэгжүүлж байхад шууд хууль дээр тусгагдаагүй асуудал гарч ирлээ гэхэд шүүх бол хууль хамгаалалтын байгууллага шүүх энэ зарчмуудыг л харах байхгүй юу. Хамгийн түрүүнд юугаа тавьсан юм. Ямар гол зорилго тавьж хийж байгаа юм гээд. Тэгээд энэ дээр надаа энэ 1.5.2 дээр эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч хүүхэдтэй шууд харьцаж ажилладаг болон бусад хүнд гэж хүүхдийг хүмүүжүүлэх хүүхэдтэй харилцахдаа гээд энэ дээр багш сурган хүмүүжүүлэгч гэж нэммээр байна. Бүүр тодотгож өгмөөр байна. Багшийг. Яагаад гэвэл бие махбодын шийтгэл гутаан доромжлох гэдэг юм чинь бол яг яах вэ тэр хүүхэдтэй шууд харьцаж ажилладаг гэдэг дотор багш нар орчхоод байна л даа. Гэхдээ яг нэрээр нь зааж өгөх багш сурган хүмүүжүүлэгч гэж нэрээр нь зааж өгөх аягүй чухал байгаа байхгүй юу. Зүгээр нэг их олон газар гарахгүй шүү дээ. Гудамжинд явж байгаа зүгээр хүүхдийг л хүн барьж аваад л цохиод зодоод байхгүй шүү дээ.

Тэгэхээр энийг редакцаар юм уу одоо эсвэл би зарчмын зөрүүтэй санал оруулаад нэмчихье. Тэгэх үү дарга аа?

2 дугаарт энэ 1.5, 1.2 дээр энэ хүүхдийн үзэл бодол саналаа илэрхийлэх эрх оролцоог хангах гэж байна шүү дээ. Энийг би арай л жоохон дээгүүр тавьчихсан юм уу даа. Энэ яах вэ дээ

яришиг яришиг багш сурган хүмүүжүүлэгч гэсэн санааг нэмээд оруулаач гэсэн хүсэлт.

Ж.Чинбүрэн: Мөнх-Оргил гишүүний багш, сурган хүмүүжүүлэгч нэмэх гэдгийг редакцын саналаар нэмээд оруулчихъя гэдэг байдлаар авчихъя аа. Тэгээд ажлын хэсэг дээрээ та хэд ярилчих. Тэгээд дараачийн хэлэлцүүлэгтээ оруулъя. Редакцын тийм.

4.Төслийн “ХОЁРДУГААР БҮЛЭГ” гэснийг “ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ” гэж өөрчилж, мөн зүйлийн 3 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулж, мөн зүйлд доор дурдсан агуулгатай 5 дахь хэсэг нэмэх:

“3.Засгийн газрын гишүүн бүр эрхлэх асуудлын хүрээнд хүүхэд хамгааллын бодлого баталж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллана.

5.Хүүхдийн эсрэг болон хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг үйлдэж эрүүгийн хариуцлага хүлээсэн хүнийг хүүхдийн эрх, хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлдэг байгууллагад ажиллуулах, хүүхэдтэй холбоотой ажил, үүрэг гүйцэтгүүлэхийг хориглоно.”

Санал гаргасан ажлын хэсэг гэсэн байна. Бас санал хураалт. Түр азнаарай цуцалъя. Мөнх-Оргил гишүүнээс асуулт байна цуцлаарай санал асуулгыг цуцалъя. Мөнх-Оргил гишүүний микрофоныг нээе.

Ц.Мөнх-Оргил: Энэ шинээр томъёолж оруулж байгаа 3 дугаар заалт буюу Засгийн газрын гишүүн бүр эрхлэх асуудлын хүрээнд Хүүхэд хамгааллын бодлого баталж хэрэгжилтэд хяналт тавьж ажиллана гэдгээ тайлбарлаад өгөөч. Энэ ямар агуулгатай юм бэ? Жишээ нь Түли

эрчим хүчний сайд яах юм? Боловсролын сайдыг ойлголоо гэж бодъё. Эрүүл мэндийн сайдыг ойлголоо гэж бодъё. Байгаль орчны сайд яг яах юм? Өөрийнх нь асуудлын хүрээнд байгаль орчныг хамгаалахад хүүхдийг ингэж оруулна шүү гэж хэлэх юм уу? Энэ жоохон тийм байгаад байх юм, ойлгомжгүй байгаад байх юм. Өргөн барьсан нь бол төрийн байгууллага хуулиар хүлээсэн чиг үүргийнхээ хүрээнд хүүхэд хамгаалахыг дэмжих хэрэгжүүлэх үүрэгтэй гэж үг өгүүлбэр байгаа байхгүй юу. Энийг Засгийн газрын гишүүн бүр эрхлэх асуудлын хүрээнд гээд яачхаж байгаа юм.

Засгийн газрын гишүүний эрхлэх асуудлын хүрээ гэдэг чинь нөгөө Засгийн газрын бүтэц бүрэлдэхүүний тухай хуулиа Засгийн газрын хуулиараа нэг их олон юм заагаад өгчихсөн байж байгаа шүү дээ. Хил хамгаалалтын асуудал, гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх гээд. Жишээ нь ХЗДХ-ийн сайд.

Тэгээд тэр асуудал бүрийнхээ хүрээнд хүүхэд хамгааллын бодлого батална гэж байхгүй шүү дээ. Угаасаа бид нар чинь энэ хүүхэд хамгааллын бодлого гэдгийг чинь энэ хуулиараа батлаад өгчхөж байгаа байхгүй юу. Тэгэхээр Засгийн газрын гишүүн бол Их Хурлын баталж өгсөн бодлого буюу хуулийг л хэрэгжүүлэх ажлыг хийнэ үү гэхээс дахиад л бодлого батлаад байхгүй шүү дээ тэр чинь. Тийм энэ дээр нэг тайлбар өгөөдхөөч.

Ж.Чинбүрэн: Хэн хариулах вэ? 4 дүгээр микрофон Баярмаа дарга.

Н.Баярмаа: Мөнх-Оргил гишүүний асуултад хариулъя аа.

Хүүхэд хамгааллын бодлого гээд Хөдөлмөрийн хуулийн 43.3-д заасан хүүхдийн эрх ашгийг бүх ажил олгогч

ажилтан албан хаагчдынхаа ажил амьдралын тэнцвэрийг хангаж хүүхэд хамгааллын бодлогыг хэрэгжүүлнэ гэсэн заалт байгаа. Тэгээд бид нар энэ нь заалтыг бол хүүхэд хамгааллын бодлогыг салбар болгон хэрэгжүүлдэг байя гэсэн ийм зохицуулалтыг хүүхэд хамгааллын энэ Үндсэн хуульдаа оруулаад ажил олгогч төрийн байгууллагууд бодлогоо батална гээд. Тэгээд дагаж орж байгаа хуульдаа бид нар бас Хүүхдийн эрхийн тухай хуульд Хүүхдийн төлөө үндэсний зөвлөл хүүхэд хамгааллын жишиг бодлогыг баталъя. Тэгээд эрхлэх асуудлын хүрээнд сайдууд орчны хамгааллаараа сайдууд болгон хүүхэд хамгааллын бодлогоо хэрэгжүүлнэ гэсэн заалтыг нэгдсэн удирдлага зохион байгуулалтдаа оруулаад явж байгаа юм. Байгаль орчин, аялал жуулчлал гээд ерөөсөө бүх салбарууд л хүүхдийн асуудал хамааралтай байгаа учраас хүүхэд хамгааллын бодлогоо баталдаг. Салбарт байгаа явуулж байгаа үйлдвэр үйлчилгээ болгон хүүхдэд ээлтэй байх салбар болгон ажилтан албан хаагчдынхаа ажил амьдралын тэнцвэрийг хангасан хүүхдийг дэмжсэн ийм бодлоготой байгааг гэдэг энэ агуулгаар л энд оруулсан.

Тэгээд хүүхэд хамгааллын бодлогоо бас тайлбар оруулсан байгаа.

Ж.Чинбүрэн: Мөнх-Оргил гишүүн.

Ц.Мөнх-Оргил: Баярмаа дарга тэгж ойлгож байгаа бол та хэд Хөдөлмөрийн хуулийн заалтыг бүүр шал эсрэгээр нь хөндлөнгөөр нь буруу ойлгочихсон явж байна аа. Тэр Хөдөлмөрийн хуулийн тэр заалт чинь Баярсайхан гишүүн санаачлаад ажлын хэсэг дэмжээд Их Хурал баталсан чинь болохлоор ажил олгогч болгон тэр дундаа төрийн байгууллага бүгд орж байгаа байхгүй юу. Ажил олгогч болгон

тухайн байгууллагад ажиллаж байгаа ажилчдынхаа хүүхдүүдээ харахад нь дэмжлэг тусалцаа үзүүлсэн ээлтэй бодлого явуулаач. Одоо жишээ нь юу гэдэг юм хөхүүл хүүхэдтэй эхчүүдэд илүү зайнаас ажиллах бололцоо олгооч. Илүү амралтыг нь өгөөч эсвэл ганц бие эцэг байх юм бол гадаад, дотоод томилолт юман дээр нь анхаараач гэсэн тийм бодлого ярьж байгаа байхгүй юу. Илүү цагаар өөрөөр хэлбэл хуулиар тэр хүүхэд хамгаалах бодлогыг хөдөлмөрийн хуульд нэлээн заагаад өгчихсөн дээр.

Та нар байгууллага болгон дээрээ энийг привичет болгооч ээ. Одоо жишээ нь өглөө хүүхдээ сургуульдаа хүргэж өгдөг бол заавал 9 цагаас ажлыг нь бүртгэх гээд байхгүй, 10 цагаас ажилдаа ирвэл хүлээж аваад, орой 7 цагаас дээр нь олгодог ч юм уу. Ингээд нэг Зохицуулалт хийж өгөөч гэдэг шаардлага тавьж байгаа байхгүй юу. Таны энэ бичээд байгаа чинь Засгийн газрын гишүүн бүр эрхлэх асуудлынхаа хүрээнд гэдэг чинь та ерөөсөө хамаагүй асуудал яриад байна. Энийг ингэж баталж болохгүй. Эсвэл энийг энэ өргөн барьсан төрийн байгууллага хуулиар хүлээсэн чиг үүргийнхээ хүрээнд хүүхэд хамгаалаг дэмжих хэрэгжүүлэх үүрэгтэй гэдэг заалтаар нь үлдээе. Эсвэл энэ гурваа ерөөсөө бүхэлд нь хасъя. Яагаад гэвэл өргөн барьсан 3 нь ч гэсэн агуулгагүй заалт байгаа байхгүй юу. Хүүхэд хамгааллыг дэмжих хэрэгжүүлэх үүрэгтэй. Угаасаа л хуулиараа байж байгаа шүү дээ.

Тэгээд энэ чинь байгууллага болгон чи яг ийм үүрэгтэй шүү л гэж зааж өгөхгүй бол ерөнхийгөөр Засаг дарга бүх шатны Засаг дарга, хэсгийн төлөөлөгч, өрхийн эмч, Их Хурлын гишүүн, Төрийн нарийн бичиг бүгдээрээ.

Ж.Чинбүрэн: Идэрбат гишүүн ажлын хэсгийн ахлагч энэ дээр тайлбар хэлээч?

Ц.Идэрбат: Мөнх-Оргил гишүүний хэлж байгааг бас ойлгож байна. Тэр Хөдөлмөрийн хуульд Баярмаа даргын тайлбарласан тэр салбарт салбарын дотоод тэр ажилтнуудын хүүхэд хамгаалах эрхийг хүүхдэдээ хандах тэр цаг зав янз янзын юмыг нь зохицуулсан ийм л хандлага байгаа. Тэрийг бол ойлгож байгаа. Бидний оруулж ирсэн энэ ажлын хэсгээс оруулж ирсэн энэ заалт бол ер нь энэ хүүхэд хамгааллын бодлого хэдийгээр сая Мөнх-Оргил гишүүний хэлж байгаа бүгдийнх нь чиг үүрэгт байгаа ч гэлээ гэсэн бас дулимаг байна. Хэрэгжилт хангалтгүй байна аа.

Тийм учраас ер нь энэ Засгийн газрын гишүүд бүр одоо жишээ нь ингээд хүүхэд яг өөрийнх нь салбар дээр байгаа хүүхэд хамгааллын нэг цэгийн үйлчилгээн дээр гэхэд л төсөв тавихгүй байгаад байгаа байхгүй юу. Төсөв тавихгүй тэгээд тэрийг хэнд санхүүжүүлэх нь мэдэхгүй, тэр үйл ажиллагааг яаж явуулах нь мэдэгдэхгүй нэг иймэрхүү зүйлүүд бас энэ салбар болгон дээр л бас байгаад байгаа юм билээ.

Тийм учраас энэ өргөн барьсан төсөл дээрээ тийм утгаар орж ирсэн. Ажлын хэсэг дээр энэ талаар бас энэ дэд ажлын хэсгийнхэн бас олон талаас нь ярьж байгаад яг ийм шүүмжлэл бол бас гарна шүү. Гэхдээ энийг заавал бид ингэж оруулах нь зүйтэй байна. Амьдрал дээр энэ чинь бас болохгүй байна шүү гэсэн ийм л агуулгаар оруулж ирсэн юм байгаа юм гэж би нэмэлт тайлбар хэлье гэж бодож байна.

Ж.Чинбүрэн: Тэгэхээр энэ надад бол бас Мөнх-Оргил гишүүний хэлснээр ер нь 3 дугаар зүйл төрийн байгууллага хуулиар хүлээсэн чиг үүргийнхээ хүрээнд хүүхэд хамгаалах дэмжих хэрэгжүүлэх үүрэгтэй гэдгээ байлгаад үлдээгээд.

Тэгэхээр одоо би шинээр уншаад энэ 3 дугаар зүйлийг оруулахгүйгээр тэгээд бусад зүйлээ уншаад оруулчихвал тэгээд болчих юм шиг санагдах юм. Босоод ирнэ шүү дээ. Тэрүүгээр явах нь зөв үү. Тэгэхээр би ингэж санал хураалгая гэж бодож байна.

Төслийн “ХОЁРДУГААР БҮЛЭГ” гэснийг “ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ” гэж өөрчилж, мөн зүйлийн мөн зүйлд доор дурдсан агуулгатай 5 дахь хэсэг нэмэх:

5. Хүүхдийн эсрэг болон хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг үйлдэж эрүүгийн хариуцлага хүлээсэн хүнийг хүүхдийн эрх, хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлдэг байгууллагад ажиллуулах, хүүхэдтэй холбоотой ажил, үүрэг гүйцэтгүүлэхийг хориглоно.” гэдэг заалтаа ингээд л уншаад л оруулчихъя. Яг энүүгээр санал хураалгачихъя.

Санал хураалт.

Сая 3 дугаар зүйлийг уншсангүй шүү дээ. Зөвхөн 5 дугаар зүйлийг нэмээд. Тэгж байгаа тэр тэгэхдээ байсан нь дээр байх, байсан нь дээр.

66.7 хувиар дэмжигдлээ.

Дараагийн санал руугаа явна аа.

Төслийн 2.1 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу?

Байхгүй байна. Санал гараагүй.

Төслийн 2.2 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу? Санал гараагүй.

Төслийн 2.3 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу? Алга байна. Санал гарга гараагүй байна. Төслийн 2.4 дүгээр зүйлтэй

холбогдуулан асуулт асуух гишүүн байна уу? Алга байна. Ажлын хэсгээс бэлтгэсэн зарчмын зөрүүтэй нэг саналтай.

Төслийн 2.4 дүгээр зүйлийн 1.3 дахь заалтыг хасаж, мөн зүйлийн 1.4 дэх заалтын “этгээдийг” гэснийг “этгээдэд тавигдах шаардлага,” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Дундын мэдээллийн сан больсон эсэх талаар Баярмаа дарга хариулт байна уу? 4 номерын микрофоныг нээгээд өгөөч. Дундын мэдээллийн сан. 4 номер.

Н.Баярмаа: Хүүхэд хамгааллын мэдээллийн нэгдсэн сантай байх зохицуулалт байгаа. Тэгээд энэ мэдээллийн нэгдсэн сангаар сангийн зохицуулалттай явъя гээд энэ боловсролын орчин эрүүл мэндийн орчин дахь мэдээллийн сангуудыг нэгтгэсэн заалт байгаа. Тэр нь хаана байгаа юм? Хүүхэд гэр бүлийн агентлаг дээр удирдлага зохион байгуулалтыг нь хангаад сангийн ажиллах. Хуулийн 2.19 дээр байгаа.

Хуулийн 2.19 дээр.

Хүүхэд хамгааллын тогтолцоо дотроо 4.19 дээр байгаа.

Ж.Чинбүрэн: 4.19 дүгээр зүйл дээр нэгд хүүхэд хамгааллын нэгдсэн мэдээллийн сантай байна. Хүүхэд хамгааллын мэдээллийн нэгдсэн сангийн дэд бүрэлдэхүүн нь хүүхдийн цахим хувийн хэрэг байна

3. Хүүхэд хамгааллын мэдээллийн нэгдсэн санг хэрэг бүрдүүлэх зарчим хэлбэр нэгдмэл байна. Хүүхэд хамгааллын мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх хадгалах аюулгүй байдлаа хангах ашиглах журмыг Засгийн газар батална гэж орсон юм байна.

Санал хураалт 66.7 хувиар дэмжигдлээ.

Төслийн 2.5 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу? Алга байна санал гараагүй байна.

Төслийн 2.6 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу? Мөнх-Оргил гишүүний микрофоныг 2.6.

Ц.Мөнх-Оргил: Энэ өргөн барьсан хуулийн уучлаарай нэг заалт ухараад ярьчихъя. 4.4-ийн 1.6 дээр энэ ийм өгүүлбэр орчхоод байх юм. Энэ Булгантуяа сайд танай яам л хийх юм шиг байна л даа. Төрийн захиргааны төв байгууллага гээд байгаа юм. Хүүхдийн эрх хүүхэд хамгааллын чиглэлээр эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчид зориулсан сургалтын хөтөлбөр журмыг батлах гээд байгаа байхгүй юу. Танай яам ингээд ийм эцэг эхчүүдэд зориулсан сургалтын хөтөлбөр журам батлах юм уу?

Ж.Чинбүрэн: Төрийн захиргааны төв байгууллага ажлын хэсгийн ахлагч Идэрбат гишүүний микрофоныг нээе.

Ц.Идэрбат: Ер нь энэ хүүхэд хамгааллын чиглэлээр энэ чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа төрийн болон төрийн бус байгууллагуудтай уулзахад тэгээд л энэ хүүхэд хамгааллын энэ асуудал чинь ер нь явж явж тэгээд л бүх юм эцэг эхтэй л ердөө салиггүй холбоотой юм билээ. Гэтэл бид нар эцэг эх рүүгээ хандсан одоо энэ хүүхэд хамгааллын чиглэлийн сургалт хөтөлбөр янз янзын юм байдаггүй. Ийм л зүйл байгаа юм билээ. Тэгэхээр одоо ингээд үе тэнгийн дээрэлхэлтэд өртсөн хүүхдэд эхлээд өөрсдөд нь сануулж уулзаж ярьж байгаад дараа нь үнэхээр давтагдаад байвал эцэг эх рүү хандаж байгаа байхгүй юу. Яг үүнтэй адилхан тэр үл хайхрах асуудлууд ч гэсэн явж

явж эцсийн цэг нь эцэг эх л болоод байгаа юм.

Тэгэхээр ер нь энэ насанд хүрэгчид буюу эцэг эх рүүгээ хандсан энэ сургалтын бас нэг ийм хөл агуулга юмнууд нь бас нэг энэ хуулийн хэрэгжилтэд үнэтэй хувь нэмэр оруулахуйц энэ хүүхэд хамгааллын тогтолцоонд өшөө бэхжүүлэхуйц ийм сургалтын хөтөлбөр бол зайлишгүй ер нь хэрэгтэй юм байна аа. Зүгээр л бид нар хууль яриад байж болохгүй юм байна лээ. Тэгэхээр энэ дээр сургалт, сургууль, боловсролын байгууллагууд ч тэр энэ л хөтөлбөрийн хүрээнд насанд хүрэгчтэй харьцах нь байна. Эцэг эхийн хүрээнд тэр гэр бүл, хүүхдийн нийгмийн хамгаалал асуудал эрхэлсэн тэр байцаагч ч тэр, олон нийтийн ажилтан ч тэр энэ хүрээнд бас нэг явдаг ийм юутай болохгүй бол бас болохгүй байна л гэж ингэж үзсэн ийм зүйл байгаа юм. Жишиг хөтөлбөр л гэж ингэж.

Ж.Чинбүрэн: Мөнх-Оргил гишүүний микрофон.

Ц.Мөнх-Оргил: Та хэд сайн бодоорой зүгээр. Мэргэжлийн хүмүүстэйгээ сайн зөвлөлдөөрэй. Тэгэхдээ миний бодлоор бол яам, сургалтын хөтөлбөр журам, жишиг хөтөлбөр ч байсан гэсэн батлахгүй дээ Булгантуяа сайд аа. Та чинь төрийн захиргааны төв байгууллага байгаа байхгүй юу. Захирамжилдаг байгууллага байхгүй юу захиргааддаг байгууллага байхгүй юу. Тэгэхээр энэ сургалтын хөтөлбөрийг жишээ нь Боловсролын яам ч батлахгүй шүү дээ. Шал өөр газар боловсруулна. Тэгээд агентлагаараа. Ядаж бүүр болохгүй бол агентлаг нь баталдаг байна. Харин тийм ядаж агентлаг нь баталдаг байвал нэг учиртай байхгүй юу. Тэгээд бүхэлдээ байна шүү дээ. Энэ яамд яамны чиг үүрэг гээд байна шүү дээ. Идэрбат

гишүүн ээ 4.4 Булгантуяа сайд аа. Энэ яамны чиг үүрэг дотор.

Ж.Чинбүрэн: Хүүхдийн эрх хүүхэд хамгааллын чиглэлээр эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчид зориулсан сургалтын хөтөлбөр журмыг батлах гэдгээ 4.5 дугаар зүйл хүүхэд гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын чиг үүрэг гэдэгт оруулах юм уу?

1.6, 1.5-ыг доошоо шилжүүлэхдээ л.

Тэгвэл ерөөсөө ингэвэл яасан юм 1.5, 1.6-г Булгантуяа сайд энийг ерөөсөө юу руу оруулчихъя. Агентлагийн чиг үүрэг рүүгээ оруулчихъя. Тэгвэл санал хураачихъя. 1.5, 1.6-г 4.5 руу оруулъя гэж. Тэгэхээр агентлаг руу оруулаад агентлагийн чиг үүрэг дотроо оруулаад явчихъя гэдгээр санал хураах уу? Тэгвэл Мөнх-Оргил гишүүний санал саналаар саяын 1-ийн агентлаг нь уг нь хийвэл. Тэгэхдээ Идэрбат гишүүн би бас ингэж ойлгож байна. Жишээлбэл Эрүүл мэндийн яам эмийн зохистой хэрэглээг зохицуулахын тулд тэр заавар гаргахгүй байхгүй юу? Эмийн агентлаг эмийг яаж зөв зохистой хэрэглэх вэ гэдгийг л гаргачихна гэж. Би надад тэгж төсөөлөгдөж байна. Хувируулаад бодох юм бол.

Мөнх-Оргил гишүүний дэвшүүлсэн саналаар санал хураалт.

66.7 хувиар дэмжигдлээ.

2.6 дээр зарчмын зөрөөтэй санал байгаа зарчмын зөрөөтэй саналыг уншиж танилцуулъя.

Төслийн 2.6 дугаар зүйлийн 1.6 дахь заалтын “судалгаа хөтөлж,” гэсний дараа “хүүхэд хамгааллын нэгдсэн” гэж нэмж, мөн зүйлд доор дурдсан агуулгатай 5 дахь хэсэг нэмэх:

“5.Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан орон нутгийн байгууллагын дарга Төрийн албаны тухай хуульд заасан нийтлэг шаардлагаас гадна хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан төрийн байгууллагад 4-өөс доошгүй жил, үүнээс хүүхэд, гэр бүлийн нийгмийн ажилтнаар хоёроос доошгүй жил ажилласан байна.” Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

Дэмжигдсэнгүй ээ. Санал дэмжигдээгүй.

Мөнх-Оргил гишүүн горимын санал гаргая.

Ц.Мөнх-Оргил: Тэр нөгөө ярьж байгаад уучлаарай. Сая санал хураалтад оролцож чадсангүй. Нөгөө санал хураах гэж байгаа заалтаа тойрч ярьж байгаад горимын санал гаргаж амжсангүй. Горимын санал гаргаж байна. Саяын санал хураалтыг хүчингүйд тооцоод дахиж санал хурааж өгөөч ээ. Агуулгыг нь дэмжиж байна. Тэгэхдээ яг өөрөөр хэлбэл Гэр бүл хөгжлийн асуудал хариуцсан орон нутгийн байгууллагын даргад тусгайлан шаардлага тавихыг дэмжиж байна.

Гэхдээ яг 4-өөс доошгүй жил ажилласан байх ёстойгоос гадна хүүхэд гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан төрийн байгууллагууд 4-өөс доошгүй жил, үүнээс хүүхэд, гэр бүлийн нийгмийн ажилтнаар 2-оос доошгүй жил ажилласан байна гэдэг бол миний бодлоор орон нутагт их өндөр их өндөр шаардлага байна аа. Улаанбаатар, Эрдэнэт, Дарханд бол хүн амын төвлөрөл ихтэй газар магадгүй байхгүй юу. Гэтэл юу гэдэг юм цагдаад ажиллаж байсан ч юм уу. Тийм ээ шүүх, прокурорт ажиллаж байсан юм уу эсвэл боловсролын байгууллагад ажиллаж

байсан хүн энэ Хүүхэд гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан орон нутгийн байгууллагын удирдлагыг хийгээд явчихад хангалттай хүн байх байхгүй юу.

Гэтэл яг нөгөө тэр чиглэлээрээ 4-өөс доошгүй жил. Энэнээсээ тухайлбал 2-оос доошгүй жил гээд тавьчихлаар би зүгээр орон нутагт хүн олдохгүй л зовлон болно доо л гэж бодож байна. Одоо жишээ нь бид нар шүүхийн хуульд тийм заалт оруулчихсан байхгүй юу. Шүүхийн туслах, нарийн бичиг, заавал магистр цолттой байх ёстой гээд. Уул нь санаа нь аягүй гоё байгаа байхгүй юу. Шүүгчийнхээ туслахыг аягүй тийм мундаг л шаардлага тавиад байдаг. Тэгсэн чинь магистртай хүн нь олдохоо байчихсан. Тэгээд бид нар 2 удаа хуулиа хойшлуулж байгаа шүү дээ. Тэрэнтэй л адилхан юм болох байх гэж бодож байна. Тэгэхлээр агуулга нь дэмжиж байна. Зүгээр энэ заалтуудаа харин яах юм. Жишээ нь миний бодлоор төрийн албанд төдөөс доошгүй жил ажилласан гээд тийм ээ шаардлага байх нь хангалттай байгаа байхгүй юу.

Ж.Чинбүрэн: 4 номерын микрофон Баярмаа дарга энэ дээр ямар хариулт өгчих. Арай их чанга хатуудав. Хүний нөөц хүрэлцэх үү гэж асууж байна шүү.

Н.Баярмаа: Мөнх-Оргил гишүүний асуултад хариулъя аа. Иргэний нийгмийн байгууллага, төрийн бус байгууллагуудтай уулзалт хийхэд нөгөө хүүхдийн байгууллагыг мэргэжисэн байгаа ч мерит байлгах энэ зарчмыг оруулаач гэдэг санал тавьсан. Тэгээд одоо бид хэдийн оруулж ирж байгаа энэ Хүүхэд хамгааллын хуулийн шинэчилсэн найруулгын бас гол асуудал хүүхэд хамгаалал бол мэргэжлийн нийгмийн ажил үйлчилгээ юм аа. Орон нутгийн асуудал хариуцсан байгууллагын дарга бол нөгөө кэйс хамтарсан баг хууль зүйн

хороон дээрээ ажиллаж байгаа кэйс дээрээ удирдан чиглүүлдэг зөвлөн тусалдаг кэйс супервайзерууд бараг байхаар байгаа. Тэгээд нөгөө хүүхэд хамгааллын үйлчилгээг мэргэжлийн болгох үүднээс энэ удирдлагын юун дээр ийм заалтыг оруулж ирсэн.

Одоогийн байдлаар бол хүүхэд гэр бүлийн хөгжлийн чиглэлээр ажиллаж байгаа аймаг дүүргийн хэлтэс болон харьяа байгууллагад ажиллаж байгаа 1054 хүн ажиллаж байгаа. Тэгээд Хүүхдийн эрхийн тухай хуулиараа хүүхэд гэр бүлийн нийгмийн ажилтан гэж ямар мэргэжилтэй хүн байх вэ гэдгийг 2016 он онд батлагдсан хуулиараа бас заагаад өгчихсөн байгаа. Тэгэхээр бол 7, 8 жилийн хувьд бол бас энэ хүүхэд гэр бүлийн нийгмийн ажилтнаар бас ажилласан. Газар хэлтэст ажиллаж байгаа хүмүүс бол ажиллах удирдлагаар ажиллах боломжтой л гэсэн. Яг мэргэжлийн талаас нь зааж өгсөн шалгуур байгаа.

Ж.Чинбүрэн: Тэгэхлээр сая Мөнх-Оргил гишүүн өөрөө тодруулчихъя.

Ц.Мөнх-Оргил: Баярмаа дарга мерит зарчим байна тэгэхдээ ингэж бас хаягаа манахгүй. Энэ салбарт яг энэ ажлыг хийх бололцоотой бусад хүмүүс орж ирж энэ ажлыг хийх бололцоо байх ёстой шүү дээ. Та бодоод үз л дээ. 4-өөс доошгүй жил ажиллачихсан тэрнээс доош 2-оос доошгүй жил ажиллачихсан гээд энэ хуулийн шаардлагыг биелүүлчихсэн мөртөө энэ байгууллагыг удирдаад явах бололцоогүй хүн байвал энэ хуулиар чинь тэр хүн чинь удирдаад явахаас өөр аргагүй болчихоод байна шүү дээ.

Тэгэхээр дарга энийг нь саналыг нь агуулгаар нь дэмжээд тэгэхдээ томъёоллыг нь эргэж харья тэгэх үү? Эхлээд жишээ нь юу гэдэг юм?

Ж.Чинбүрэн: Хураасан саналаа хүчингүйд тооцох санал хураалт хийе. Саяын санал хураалтыг хүчингүй болгох санал хураалт явуулчихсан байсан юм. Уначихсан байхгүй юу. 77.8 хувиар санал хүчингүйд тооцлоо. Тэгэхээр одоо ажлын хэсгийн ахлагчаас энэ 4-өөс доошгүй жил 2-оос доошгүй жил 2-ыг босгыг нь буулгах буулгаснаа шууд санал хураах уу эс үгүй бол дараа нь та бүхэн нэр томъёолол дээр нь ажиллах уу?

Тэгвэл агуулгыг нь дэмжиж байна гээд санал хураачих уу? Идэрбат гишүүний микрофоныг нээгээрэй.

Ц.Идэрбат: Энэ асуудал Засгийн газраас өргөн барьсан хуулийн төсөл дээр байгаагүй. Ажлын хэсэг дээр мөн ажлын хэсгийн дэд хэсгийн хуралдаан дээр мөн энэ салбарын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн болон төрийн бус байгууллагууд нартай уулзахад энэ энэ хүүхэд хамгааллын ер нь хүүхдийн байгууллага гэдэг бол зүгээр нэг хэн нэгэн хүнийг чи багш юм байна гээд авчраад тавьчихдаг юм бол одоо биш.

Энэ ингээд 7 жил болж байгаа энэ тогтолцоог бид нар өшөө л цаашаа чамбайруулаад энэ чинь бүүр шинжлэх ухаан болж хөгжөөд нийгэм хөгжихийн хэрээр энэ салбар өшөө ийм тогтвортой менежменттэй ажилладаг ийм л юм болохгүй бол болохгүй байна гэсэн ийм зүйлүүд яригдаад тэгээд ямар ч байсан одоо байгаа энэ хүүхэд хамгааллын чиглэлээр мэргэшээд ажиллаж байгаа энэ хүмүүсээ мерит зарчмаар цаашаа хөгжөөд явах ийм бололцоог нь нээж өгье өө.

Тэр битгий хэл сургуулийн захирлуудтай уулзахад бүх багш нарт энэ багш бэлтгэж байгаа сургуулиудад хүүхэд хамгааллын чиглэлээр бүүр

хичээл оруулмаар байна аа. Дөнгөж төгсөөд ирсэн багш хүүхдэд энэ хүүхэд хамгааллын чиглэлээр бид нар дахиж тэрийг сургах ийм хүндрэлүүд үүсэж байна тэгэхээр энэ гэдгийг сургуулийн захирлууд хүртэл хэлээд байна лээ. Тэгэхээр энэ хүүхэд хамгааллын энэ тогтолцоо юмнуудыг үйлчилгээг бид өшөө боловсронгуй болгоход тийм нийтлэг гэхээсээ илүүтэйгээр энэ салбар руу бас нэлээн тийм ажиллачихсан тийм хүмүүс байвал өшөө л бас чанартай болно оо гэсэн ийм л агуулгаар орж ирсэн ийм зүйл заалт байгаа юм аа.

Тэгэхдээ ажлын хэсгийн ахлагчийн хувьд Мөнх-Оргил гишүүний хэлж байгаа Булгантуяа сайдын хэлж байгаа энэ зүйлүүд дээр бас эргэж бас ярилцаад ингээд явъя л гэсэн ийм л бодолтой байна.

Ж.Чинбүрэн: Тэгэхээр би зүгээр агуулгаар нь дэмжиж байна гэж санал хураалгаж болохгүй л байгаад байна л даа. Шууд юу явал яасан юм Төрийн албаны тухай хуульд заасан нийтлэг шаардлагаас гадна хүүхэд гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан төрийн байгууллагад мөн гэр бүлийн нийгмийн ажилтнаар ажилласан нь давуу байдал үүснэ ч гэдэг юм уу тиймэрхүү байдлаар орж болохгүй юу? Зөрчилдөх үү? 4 номерын микрофон тодруулж Баярмаа дарга тодруулж хэлнэ үү?

Н.Баярмаа: Төслийн дараагийн заалт нь болохоор яг энэ нийгмийн ажилтнаар ажиллах хүмүүсийн мэргэжлийн зэрэг дээр бас яг энэ нийгмийн ажилтан нь тэгээд дээрээс нь боловсрол болон нийгмийн ухааны чиглэлээр мэргэшсэн гэхээр боловсролын салбарт ажилтанд ажиллаж байгаа хүмүүс яг энэ хүүхэд гэр бүлийн ажилтнаар ажиллах ийм боломж л мөн байгаа. Тэгээд бид нарын энэ нөгөө мерит зарчмыг бас Боловсролын

ерөнхий хуулийн боловсролын орон нутгийн удирдлагыг бас харсан. Боловсролын ерөнхий хууль дээр орон нутгийн удирдлага бол боловсролын салбартаа 10 жил ажилласан. Үүнээс удирдах албан тушаалд бүр 5 жил ажилласан гээд энэ мерит зарчмыг нь заагаад өгчихсөн байна лээ. Тэгээд бид нар харин энийг яг хүүхэд гэр бүлийн бас хүний нөөцтэйгөө уялдуулаад 4 жил, 2 жил гэсэн байдлаар л ингэж томъёолж оруулсан байгаа.

Ж.Чинбүрэн: Булгантуяа сайдад микрофоныг өгье. Булгантуяа сайдын микрофон.

Х.Булгантуяа: Манай салбарынхан дотор бас нэг яах вэ юу байгаад байдаг нь одоо жишээлбэл шал өөр салбараас татвараас байдаг юм уу? Ирээд энэ агентлагийн хэлтсийн дарга болчихдог байдаг юм уу? Аймаг орон нутагт ингээд салбар ойлгохгүй хүмүүсийн салбарыг удирдах гээд байдаг гэдэг нэг ийм шүүмжлэл бас байдаг юм. Ер нь сая энэ хуулийг боловсруулахад бид нар тойрч ярьсан бас нэг том асуудал нь энэ. Ер нь төрийн захиргааны байгууллага байх ёстой юм уу, төрийн үйлчилгээний байгууллага байх ёстой юм уу гэдгийг ч тойрч ярьсан. Зүгээр санаа зовсон зүйл нь төрийн захиргааны албан хаагчийг халах солих.

Энэ нь Төрийн албаны хуулийн нэлээн хатуу зохицуулалттай учраас энэ салбар бол бас энэ шинэ хуультай болоод энэ байгууллага ч гэсэн аймаг орон нутагт хөлтэй болоод удаагүй байгаа учраас сонгуулийн дараа ч гэдэг юм уу улс төрчид очиж томилгоог замбараагүй хийгээд байх вий дээ гэж нэг хэсэгтээ төрийн захиргааны байгууллагаар явах нь зүйтэй юм гэж манай салбарынхан бас үзсэн юм. Угтаа бол манайх энэ бараг нэг бодлын

үйлчилгээ шүү дээ. Хамгаалах хүүхэд хамгаалах үйлчилгээ.

Тэгэхээр төрийн үйлчилгээний байгууллага байгаад олон улсын байгууллагуудад ажиллаж байгаа хүмүүсээс, төрийн бус байгууллага дээр ажиллаж байсан хүмүүсээс гээд ингээд бас ажиллах үүд хаалга нь нээх ёстой юм болов уу гэж ярьж ярьж хийсэн юм аа. Тэгэхдээ энэ одоо зүгээр манай хүүхэд хамгааллын хуультай болоод 2016 оноос л хуультай болсон. Энэ бүтэц орон тоо энэ бүгд 2016 оноос хойш л хууль хэрэгжээд бий болсон. Тэгэхээр ийм өндөр шаардлага тавихаар бас албан хаагчид аймаг орон нутагт олдоц бас хэцүү юм биш үү гэдэг асуудлыг яриад байна.

Магадгүй эхэн үедээ бид нар нэг жоохон нээлттэй байж байгаад 5 жил юм уу явуулаад харвал яасан юм бэ? Харж бас болох юм гэдэг бас ийм саналтай байна.

Ж.Чинбүрэн: Одоо санал хураалтаа түрүүн уншсан. Тэгэхээр энэ 2.6 дугаар зүйлийн зарчмын зөрүүтэй саналаар санал хураалт. Байж байгаарай байж байгаарай. Түрүүн хэлчихсэн дээ, эд нарыг тэгээд саналаа л хураачих. Тэгээд гишүүд яаж дэмжиж яах нь вэ? Хэрвээ унавал тэгээд юун дээрээ асуудлаа шийдье.

Санал хураалт. Тийм дэмжихгүй унана л гэсэн үг.

44.4 хувиар дэмжигдсэнгүй энэ санал уналаа.

Цаашаа явъя. Төслийн 2.7 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу? Алга байна. Ажлын хэсгээс бэлтгэсэн зарчмын зөрүүтэй 2 саналтай 2.7.

7.Төслийн 2.7 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн “мэргэжлээр дээд боловсролтой,” гэснийг “, эсхүл боловсрол, нийгмийн ухааны чиглэлээр дээд боловсрол эзэмшиж” гэж өөрчилж, мөн зүйлийн 2.3 дахь заалтын “үнэлгээ хийх,” гэсний дараа “дүгнэлт гаргах,” гэж, мөн зүйлийн “кейс” гэсний өмнө “тохиолдол” гэж тус тус нэмж, мөн зүйлд доор дурдсан агуулгатай 2.9 дэх заалт нэмэх:

“2.9.Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд заасны дагуу хүүхдийн хууль ёсны төлөөлөгчөөр оролцох. Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

66.7 хувиар дэмжигдлээ.

Төслийн 2.7 дугаар зүйлийн 6, 7 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулж, 6 дахь хэсэг болгон өөрчилж, мөн зүйлд доор дурдсан агуулгатай 8 дахь хэсэг нэмэх:

“6.Сум, хорооны 3000 хүртэлх хүн амд нэг хүүхэд, гэр бүлийн нийгмийн ажилтан байхаар тооцож сум, хороо бүрд ажиллуулна.”

8.Хүүхэд, гэр бүлийн нийгмийн ажилтнаар ажилласан эхний тав дахь жил болон дараагийн гурав дахь жил тутамд нэг удаа зургаан сарын үндсэн цалинтай нь тэнцэх хэмжээний мөнгөн тэтгэмжийг улсын төсвөөс олгоно.” Санал гаргасан ажлын хэсэг.

Мөнх-Оргил гишүүний микрофоныг нээе. Санал хэлнэ.

Ц.Мөнх-Оргил: Засгийн газраас өргөн бариагүй тэгээд ихээхэн хэмжээний төсвийн үр дагавартай 2 заалт орж ирж байна л даа. Ажлын хэсгээс тэгээд энэ дээр Засгийн газар

ямар байр суурьтай байгаа юм бэ? Хэдэн төгрөгийн зардал нэмэгдэж гарах гээд байгаа юм бэ? Одоо байгаа нийгмийн ажилтны тоо хэдээр нэмэгдэх юм.

Жилийн төсөв нь хэд болох юм. Энэ 5 дахь жил болон дараагийн 3 дахь жил тутам нэг удаа 6 сарын үндсэн цалинтай тэнцэх хэмжээний мөнгөн тэтгэмжийг улсын төсвөөс олгоно гэдэг заалт чинь бусад ижилд дүйцэж тооцож болох төрийн албан хаагчдын нийгмийн хангамжийн нэг мөнгөн тэтгэмжийг олгож байгаа хэлбэр хэмжээтэй дүйцэж байгаа юм уу? Одоо бид нар чинь нэг хууль батлах болгон дээр л тухайн салбарынхандаа мөнгөн тэтгэмж олгосоор байгаад л сүүлдээ энэнийхээ учрыг олохгүй цэгцэлж чадахгүй л баларчхаад яваад байгаа хүмүүс шүү дээ. Одоо ингээд энэ нэмэгдэх юм байна л даа.

Хүүхэд гэр бүлийн нийгмийн ажилтан гээд. Тэгэхлээр хүүхэд гэр бүлийн биш өөр нийгмийн ажилтнууд явж л байгаа шүү дээ цаана чинь. Ийм чиглэлийн нийгмийн ажил хийгээд явж байгаа юм. Тэр төрийн албан хаагч чинь яах юм, авах юм уу, авахгүй юм уу гэх мэтийн олон асуудлууд байна аа. Тэгээд энэ дээр ажлын хэсэг Булгантуяа сайд тэгээд саналаа хэлнэ биз хариулт өгнө биз.

Миний энэ асуултаас гадна горимын санал бол энэ 2 заалттай холбогдуулж Төсвийн байнгын хорооноос дүгнэлт гаргуулах хэрэгтэй гэж бодож байна.

Ж.Чинбүрэн: Тэгэхлээр Засгийн газраас өргөн барьсан төсөл дотор бол байхгүй байна. Тэгэхлээр ажлын хэсэг дээр яасан учраас Идэрбат гишүүн тодруулна уу?

Ц.Идэрбат: Засгийн газраас өргөн барьсан дээр 3 мянга тутамд нэг гэж байхгүй боловчиг сум хороонд гэр бүл, хүүхдийн асуудал эрхэлсэн нийгмийн ажилтантай байна гэсэн ийм зүйл байгаа байгаа. Ажлын хэсгийн зүгээс ер нь юм тодорхой байх нь зүйтэй. Энэ дээр бас судалгаа юмнууд хийе гээд. Ер нь 3 мянга тутам гэдэг тоог бас энэ нөгөө Монгол Улсын сумдын дундаж хүн ам, мөн одоо хүн амын төвлөрөл ихтэй аймгийн төвийн сум энэ нийслэлийн энэ хороодууд эд нараас гарч байгаа бас үндэслэлээр бид нар энэ тоог бас тавьсан юм байгаа юм ажлын хэсгийн зүгээс. Ер нь зүгээр энэ хүүхэд хамгааллын энэ тогтолцоог бид нар ярьдаг шигээ олигтойхон бодитой байлгая л гэвэл хүнийхээ тоог бид зайлшгүй нэмэхээс өөр аргагүй ээ.

НҮБ-ын хүүхдийн байгууллагаас гаргасан дүгнэлтэд одоо мөрдөгдөж байгаа 2016 оны хууль маань хэрэгжиж эхэлснээс хойш нэг жилийн дараа л энэ Монгол Улсын энэ хүүхэд хамгааллын тухай хууль дээр чинь ийм ийм ноцтой алдаанууд байна аа.

Тэрэн дээр энэ боловсон хүчний дутмаг байдал, энэ хамтарсан багийн энэ санхүүгийн тогтолцоо хаана ч тусгагдаагүй. Ингээд нэг хууль дээр, ингээд нэг тийм зүгээр ийм нэг тунхаг маягаар орчихсон. Тэр чинь ажиллахгүй байна гэдгийг аль уже арваа 5, 6 жилийн өмнө хэлчихсэн юм билээ. Тэр яг амьдрал дээрээ бас байдаг эд ээ.

Тийм учраас энэ Засгийн газраас өргөн барьсан хууль дээр сум хороонд гэснийг бид бас тодорхой заагаад өгье өө гэсэн ийм үндэслэлээр оруулж ирсэн юм байгаа юм. Бидний судалгаагаар ажлын хэсгээс хийсэн судалгаагаар энэ Монгол Улсын 330 сум, энэ хороод, нийслэлийн хороодоор ингээд үзэхээр 1153 хүний асуудал энд яригдах гээд байгаа юм. Яригдах гээд байгаа юм. Эд

нарын яг цалин хөлстэй холбоотой энэ зардлыг нь тооцоод үзэхээр 2025 оны 1 сарын 1-ээс эхлээд 30 тэрбум төгрөгийн асуудал яригдаж байгаа юм. 30 тэрбум төгрөгийн асуудал. Тэр урамшуулалтай холбоотой асуудал 2030 оноос ингээд ярихаар 10 тэрбум төгрөг яригдаж байгаа юм. Магадгүй бид хэрвээ энэ 3 мянга тутамд ийм хүн байна гэдэг энэ заалт хэрвээ унавал та бид нарын өнөөдрийн энэ ярьж байгаа хууль угаасаа л 2016 оны хууль.

Тэр нь НҮБ-аас гаргасан тэр нэг тийм тунхаг төдий хууль болоод л үлдэнэ. Би энийг бол бас нэг анхан шатад энэ хамтарсан баг хүүхэд хамгааллын багийг ажиллуулж байсан хүний хувьд хэлэхэд.

Дээрээс нь бидний энэ орон нутгуудтай бид нар цахимаар хүртэл уулзалтууд хийсэн. Ховд аймгийн Зэрэг сумтай ингээд уулзалтууд хийж байгаа.

Нийслэлийн СБД-ийн хороодоос өрхийн эмч ирээд ажиллаж байгаа.

Хороон дээр өнөөдөр нөхцөл байдал ямар байна вэ гэхээр 15 мянган хүнд дөрөв, тавхан хүн л үйлчилж байгаа юм байна лээ шүү дээ. Тэнд хүүхдийн асуудал ярьдаг хүн бараг байхгүй. Сумдуудад ганцхан нийгмийн бодлогын түшмэл байгаа тэр бол бас нэг л суманд үйл ажиллагаа явуулж байгаа. Аймгийн төвийн багууд дээр аваад үзэх юм бол 5, 6 мянган хүнд энэ яг нийгмийн ажилтан гээд нэг л хүн байгаа. Яг энэ гэр бүл хүүхдийн энэ асуудал руу хариуцсан хүн байхгүй ээ. Тийм учраас яах вэ Засгийн газар дээр яг 3 мянга тутам гэж орж ирээгүй боловчиг бид энэ зүйлийг энэ 2 үгийг яг амьдрал дээр буулгахын тулд л энэ 3 мянга гэдэг энэ тоог оруулж ирсэн гэдгийг. Санхүүгийн хувьд бол ийм тооцоо урьдчилсан байдлаар гарсан гэдгийг бас хэлье ээ.

Ж.Чинбүрэн: Тэгэхлээр бас Мөнх-Оргил гишүүний нэг асуусан асуултад бусад төрийн үйлчилгээ үзүүлж байгаа алслагдсан сум хүн ам цөөтэй газруудад хэр байгаа вэ? Ижил төстэй юу гэсэн бас нэг асуулт асуусан. Тэгэхээр ингэе. Би ийм санал тавимаар байх юм. Хэдүүлээ 2 тусдаа хураачихъя. Сум хорооны 3 мянга хүртэлх хүн амд нэг хүүхэд гэр бүлийн нийгмийн ажилтан байхаар сум хороо бүрд ажиллуулна гээд, нэг.

Хоёр дахь нь энэ саяын энэ санхүүжилттэй холбоотой энэ саналыг тэгээд чиглэл нь болохлоор ажлын хэсгийн ахлагч Төсвийн байнгын хороотой бас нэг уулзаж зөвшилцөж энэ талаар бас ярилцсан нь дээр байх аа. Энэ дээр Төсвийн байнгын хороо заавал албан ёсны дүгнэлтээ өгөх ёстой. Энэ төсвийн юмнууд гарчихсан байж байгаа шүү дээ. Тэгэхээр энэ төсвийн бололцоо байхгүй гэж хэлдэг үү эсвэл энэ төсвийн бололцоо байна гэж хэлдэг үү нэгдүгээрт?

Тэгэхлээр ажлын хэсгийн ахлагчтай бас ярилцаад санал хураах томъёоллоо ийм болгоё гэж байна.

Төслийн 2.7 дугаар зүйлийн 6 7 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулж зургаа дахь хэсэг болгон өөрчлөх, тэгээд зургаа сум, хорооны 3 мянга хүртэлх хүн амд нэг хүүхэд гэр бүлийн нийгмийн ажилтан нь байхаар тооцож сум хороо бүрд ажиллуулна гээд.

Тэгээд 8 дугаар зүйлээ хасчхаж байгаа юм байна шүү. Татаад авчхаж байгаа юм байна.

Тэгэхлээр ерөөсөө ганцхан сум хорооны гэдгээр Идэрээ гишүүн микрофоныг нээе. Идэрбат гишүүний микрофоныг.

Ц.Идэрбат: Ер нь яах вэ зүгээр сум хороон дээр 3 мянга хүртэлх гэдэг энэ зүйл заалт би байгаасай билээ гэж чин сэтгэлээсээ хүсэж байгаа юм. Энэ чинь кэйс гарсны ард дээр юм уу, тохиолдол гарсны ард дээр явах хүмүүс биш. Тэрнээс урьдчилан сэргийлэх л ийм л хүмүүс байгаа. Энэ чинь сумд нэг л байгаа. Суманд байхгүй байсан хүн нэг болж байгаа юм. Аймгийн төвийн багууд дээр бас нэг болж байгаа юм. Хороон дээр бол тэр 15 мянган хүн байлаа гэхэд бол дунджаар 5 хүн нэмэгдэх гээд байна л даа. Нэмэгдэх гээд байна. Гэтэл 15 мянган хүн доод тал нь 3 мянган өрх айл гээд ингээд бодохоор энэ бол бас тийм ч боломжгүй зүйл биш юм аа. Ер нь бол зүгээр яах вэ тооцооллын хувьд гаргасан тооцоогоо ер нь танилцуулсан.

Харин энэ төсөв хөрөнгөтэй холбоотой асуудлууд яригдаж байгаа учраас энэ ажлын хэсгийн зүгээс оруулсан энэ 8-ыг татаж авъя гэж ингэж би хэлэх гээд байгаа юм. Татаж авъя аа. Энэ дээр бас нэлээдгүй тооцоо гарна. Гэхдээ яах вэ, энд гэр бүл, нийгмийн ажилтан маань өөрөө төрийн албаны хуулиар бусад нэмэгдэл юмнуудаа аваад ирж байгаа учраас энэ ажлын хэсгээс гаргасан энэ 8 дахь саналыг нь татаад авчихъя.

Харин тэр 3 мянга гэдэг дээрээ санал хураалт хураалгая л гэж. Ингэж 3 мянга тутамд нэг гэдэг дээрээ баярлалаа.

Баярсайхан гишүүн. Баярсайхан гишүүний микрофоныг нээе. Бейсен гишүүний микрофоныг нээгээрэй.

Б.Баярсайхан: Баярлалаа энэ дээр Баярмаа дарга бас хариулж өгөөрэй. Бид нар чинь нөгөө удаа дараа суман дээр жишээлбэл мал хариуцсан 5 хүн байхад, хүн хариуцсан нэг л хүн

байна гэж яриад байгаа. Хамтарсан баг гэдэг тэр гадаад орны туршилагыг авчраад өнөөдөр хэрэгжүүлсэн боловч Мөнх-Оргил гишүүний хэлдгээр бүгд өөр өөрийн үндсэн ажилтай, хамгийн завгүй ажилладаг, нөгөө сумын Засаг дарга байнга солигддог тогтвортой ажиллаж чаддаггүй, улс төрийн шалтгаанаар. Өрхийн эмч, цагдаа, багийн дарга гээд ийм хүмүүс л байгаад ерөөсөө энэ энэ хамтарсан баг чинь өнөөдөр Монгол Улсад тийм дорвитой үр дүнтэй ажиллаж чадахгүй байгаа юм. Сэтгэл нь байвч болохгүй байгаад байгаа юм.

Тэгэхээр энэ ялангуяа энэ хотын хороонд үнэхээр төсөв мөнгө болдог бол энэ 5 байх бол ерөөсөө ихдэх асуудал биш гэж би харах гээд байхгүй юу. Тэгээд манай яамныхан чинь бас аягүй их туршилага эд нар судалж гадагшаа явдаг шүү дээ. Ер нь нийгмийн эрүүл мэнд, айл гэрийн эрүүл мэнд хүүхдийн аюулгүй байдлыг хангахад л тэр хороо дүүргийн чинь ажилд чиглэж байдаг гол ажил нь байхгүй юу. Тэгэхлээр энэ дээр яг ям ямар юугаар ингэж гаргаж ирсэн гэдгээ нэг дэд ажлын хэсгээс нэг тайлбарлаад өгвөл бас арай тод шуурхай болох байх гэж бодож байна.

Ж.Чинбүрэн: 4 номерын микрофон хэдүүлээ шуурхайлна. Тодорхой хариулт өгөөрэй.

Н.Баярмаа: 3 мянган хүн тутам гэдгийг бид нар бас Засгийн газрын тогтоолын дагуу гаргаж ирсэн. Халамжийн нийгмийн ажилтны ажиллах шалгуур чиглэл гээд 2010 онд баталсан тогтоол байгаа.

Суманд 3 мянган хүн тутамд нэг нийгмийн ажилтан, хороонд 5 мянган хүн тутамд нэг нийгмийн ажилтан гээд. Тэгээд энэ жишгийн дагуу бид нар Засгийн газрын хүрээнд Сангийн яам руу санал явуулаад 1044 нийгмийн ажилтан

байх юм байна гээд. Тэгээд одоо энэ дээр бол Их Хурал дээрээ л шийдэгдэнэ биз гээд. Тэгээд бид нар бас яг энэ 3 мянга тутам хүнд нэг гэсэн агуулгаар бас оруулж ирсэн байгаад байгаа юм.

Хүүхдээс гадна бас Гэр бүлийн хуулийн шинэчилсэн найруулга батлагдана. Гэр бүлийн хуулийн шинэчилсэн найруулга батлагдана. Яг энэ дагуу бол энэ нийгмийн ажилтан 16 төрлийн чиг үүрэг, асран хамгаалагч, харгалзан дэмжигч, шинжээчийн дүгнэлт гаргах, үрчлэл дээр хяналт тавих гээд 16 чиг үүргийг энэ хуулиас гадна хэрэгжүүлэхээр нийгмийн ажилтан байгаа.

Ж.Чинбүрэн: Булгантуяа сайд хариулт нэмж өгье.

Х.Булгантуяа: Энэ хуулийг анх батлуулж байхад бид нар НҮБ-ын хүүхдийн сангаас Засгийн газар захиалгаа өгөөд Монгол Улсын хүүхэд хамгааллын үйлчилгээний өртөг ба төсвийн дүн шинжилгээ гэж хийлгэсэн. Тэгэхэд 2016 онд энэ хуулийг хэрэгжүүлэхэд 11.5 тэрбум төгрөг хэрэгтэй. Ийм нарийн мэргэжлийн хүмүүс аймаг орон нутагт бүгдээрэнд нь гартай, хөлтэй байж байж хэрэгтэй гэсэн. Тэгээд үнэнийг хэлэхэд бид нар нэг анх 300 гаруйхан сая төгрөгөөр тавьж эхлээд л одоо 8 тэрбум төгрөг гэхээр сүүлийн 3, 4 жил 8 тэрбум төгрөг тавьсан. Бараг ямар их мөнгө юм бэ гэсэн байдалтай ер нь төдийгөөс өдий болтол байгаа. Нийт хүүхдэдээ та бүхэн хуваагаад аваад үзэх юм бол нэг хүүхдийн хүүхэд хамгааллын зардал, нэг хүүхдэд бүтэн жилийнх нь зардал гэх юм бол 6 мянга 600 орчим төгрөг байгаа шүү. Энэ хүүхдүүдээс нийт хүүхдүүдийн 37, 38 орчим хувь нь халамж хамгаалал шаардлагатай айл өрхөд өсөж байгаа хүүхдүүд байгаа. Бид нар ингээд энэ суманд шаардлагатай гээд байгаа гол шалтгаан нь тэнд кэйс үүсэхэд одоо энэ

өвлийн хүйтэнд чинь ямар ч бай ингээд аймгийн төвөөс хэдэн 100 км давхиж очиж тэр хүүхэд мэдүүлэг өгөхөд тэр хүүхдийн эрхийг хамгаалахад гээд ингээд очиж ажиллах болчихоод байгаа юм.

Энэ хүмүүст бас үүнээс гадна ганицхан хүүхэд гэр бүл гэхээр энүүн дотор түрүүн 10 гаруй чиг үүрэг хариуцна гэж байна. Энэ хүмүүсийн тоо, орон тоо нэмэгдэж чиг үүрэг сайжирч байж цагдаа дээр ирэх ачаалал ч гэсэн буурах юм. Бид нар урьдчилан сэргийлэх, мэдээ мэдээллээр хангах, тэгээд ер нь бас иргэд олон нийтийг татан оролцуулах мэргэжлийн төрийн бус байгууллагуудтай хамтран ажиллах гэдэг энэ чиг үүргүүдийг нэмэгдүүлэх ёстой гэдэг НҮБ-аас бид нар анх энэ хуулийг л боловсруулж байхад л өгч байсан чиг үүргийг л бид нар 2016 оноос хойш л одоо л хэрэгжүүлэх гээд л явж байгаа л даа. Тийм юугаар л орж байгаа.

Ж.Чинбүрэн: Мөнх-Оргил гишүүний микрофоныг.

Ц.Мөнх-Оргил: НҮБ чинь Булгантуяа сайд аа, тэгээд 3 мянган хүүхдэд хүн амд нэг байцаагч тавьчхаарай гэж зөвлөөгүй байлгүй дээ. Гишүүд та хэд манай ажлын хэсгийнхэн ч гэсэн зөв ойлгоорой. Би энийг ингээд эсэргүүцээд юм уу, ингээд хүүхдүүдээс харамлаад байгаа юм ерөөсөө байхгүй. Бид нар тэгэхдээ бодит амьдрал дээрээ буух ёстой байхгүй юу. Мөнгө байвал энийг чинь хэдийг ч тавьж болно шүү дээ. Байхгүй байхгүй юу. Энэ төсөв чинь байхгүй, нэгдүгээрт.

Хоёрдугаарт өргөн барьсан төсөл чинь зөв байгаа байхгүй юу. Одоогийн тогтолцоо чинь зөв байгаа байхгүй юу. Аргачлалыг нь Засгийн газар батална. Аль суманд аль хороонд хэдэн хүн ажиллах вэ гэдгийг чинь Засгийн газар нь батлаад тоог нь гаргаад өгөөд

тэрэндээ тааруулаад ажиллах аргачлал чинь зөв байхгүй юу. Тэрнээс биш хууль дээрээ төдөн хүн төдөн байцаагч байя гэдэг шаардлага тавьж болохгүй шүү дээ. Тэгэх юм бол цагдаагийнхан Хууль зүй, дотоод хэргийн яам 3 мянган хүнд нэг цагдаатай болно оо гээд л хуулийн төсөл оруулаад ирнэ.

Хоёр мянган хүнд нэг өрхийн эмчтэй байя гээд л хуулийн төсөл оруулаад ирнэ. Өнөөдөр энэ хэлэлцэж байгаа асуудал чинь бидний хувьд чухал болохоос биш бид нар энэ хуулийг хэрэгжүүлэхэд цаана нь улс орны нийгмийн ерөнхий том зураг, хөрөнгө мөнгө, төсөв энэ төрийн албаны хууль энэ бүх юмаа харж байж том зургаараа хийнэ үү гэхээс ганицхан энэ хуулиар Монголын бүх асуудал шийдэгдэхгүй гэдгийг л бид нар ойлгох ёстой байхгүй юу даа. Тэгээд Ерөнхий зургаа барих ёстой. Ерөнхий зураг чинь өргөн барихдаа та нар Одон Булгантуяа сайдаа зөв өргөн барьчихсан байна.

Тухайн нэгжгийн нутаг дэвсгэрийн хэмжээ, хүн амын нягтаршил, гэр бүл, хүүхдийн тоо, хүүхдийн эсрэг гэмт хэрэг зөрчлийн гаралт зэргийг үндэслэн сум, хороонд ажиллах хүүхэд гэр бүлийн нийгмийн ажилтны орон тоог тогтоох шалгуур үзүүлэлт, аргачлалыг Засгийн газар батална гээд. Энэ чинь л зөв байгаа байхгүй юу.

Засгийн газар чинь хэлнэ шүү дээ. Ийм алслагдсан байгаад 2 мянган хүнтэй байх юм бол төд байна шүү. Гэр хороололд ингээд ингээд ийм төдөн гэртэй байх юм бол ийм байна шүү. Орон сууцын хороолол төд байна шүү гээд ингээд л аргачлалаа батлаад хийчих нь хамаагүй зөв байхгүй юу даа.

Ж.Чинбүрэн: Санаа ойлголоо. Ингээд санал хураалтаа хийнэ.

Сая унисан 8 дугаар хэсгийг ажлын хэсгийн ахлагч татаад авчихсан. Одоо зургаа дээр сум хорооны 3 мянга хүртэлх хүн амд нэг хүүхэд гэр бүлийн нийгмийн ажилтан байхаар тооцож сум, хороо бүгд ажиллуулна гээд.

Ингээд санал дэмжигдвэл яг энүүгээр.

Бейсен гишүүний микрофоныг нээе ээ.

Б.Бейсен: Өчигдөр энэ ажил юуны хурал дээр бас хэлсэн. Би төсөв нь байгаа юм уу энэ тэр гээд л. Тэгэхээр 16 тэрбум гэлүү тийм юм батлагдсан гээд ярьсан. Хөдөлмөрийн яам хөдөлмөр хамгааллын чиглэлээр. Тэгэхдээ энэ асуудал сая энэ гишүүний саналыг бас харж үзэхгүй болохгүй нь. Төсвийн асуудал дээр сумууд дээр чинь захиргаа нь нэг нийгмийн ажилтан, сургуульд нэг нийгмийн ажилтан, эмнэлэгт нэг нийгмийн ажилтан байгаа. Одоо ер нь ажиллаж байгаа. Би яг эмнэлгүүдээр яваад бүгд нь мэдэж байгаа бүгд орон тоо нь байгаа. Орон тоотой ажиллаж байгаа. Эд нар зарим нь орон тоо батлуулаагүй ажиллаж байгаа. Тэгэхээр чинь тэр Төсвийн байнгын хорооноос энийг бас яаж байгаад шийдэхгүй бол бас болохгүй асуудал гарчих болов уу? Дүгнэлтийг нь авах уу? Ер нь тэр талаар бас зөвлөе хэдүүлээ.

Ж.Чинбүрэн: Тэгээд ингэе саналаа хураачихъя. Хэрвээ унах юм бол нөгөө төслийн анхны өргөн барьсан хэлбэрээрээ. Хэрвээ дэмжигдэх юм бол 3 мянга хүртэлх хүн ам тутамд гэр бүл хүүхдийн асуудал хариуцсан ажилтан ажиллах нь гэж ойлгох нь ээ.

Санал хураалт.

55.6 хувиар санал дэмжигдлээ.

Чуулган дээр Мөнх-Оргил гишүүн цөөнх болж уг хэлнэ гээд тэмдэглэхье протокол дээр тэмдэглээд оруулчихъя. Чуулган дээр уншина.

Цаашаа явна аа. Төслийн 2.8 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу? Алга байна.

Ажлын хэсгээс бэлтгэсэн зарчмын зөрөөтэй нэг саналтай.

9.Төслийн 2.8 дугаар зүйлийн 1, 2 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“1.Монгол Улсын хэмжээнд Хүүхдийн төлөө үндэсний зөвлөл, орон нутагт хүүхдийн төлөө зөвлөл нь хүүхэд хамгааллын бодлогын хэрэгжилтэд хяналт тавина.

2.Хүүхдийн төлөө үндэсний болон орон нутгийн зөвлөл улирал тутам хуралдаж, хүүхэд хамгааллын талаар хийсэн ажлын тайланг хэлэлцэж, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний талаар төрийн захиргааны төв болон нутгийн захиргааны байгууллага, нутгийн өөрөө удирдах байгууллага, холбогдох бусад хуулийн этгээдэд зөвлөмж өгч, хүүхэд хамгааллын бодлого тодорхойлох, шийдвэр гаргахад талуудын оролцоог хангаж, санал, дүгнэлт гаргана.” Санал гаргасан ажлын хэсэг.

Хүүхэд хамгааллын бодлогоо бас нийцүүлээрэй.

Санал хураалт 66.7 хувиар дэмжигдлээ.

Төслийн 2.9 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу? Алга байна. Санал гараагүй.

Төслийн 2.10 зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байна

уу? Алга байна. Ажлын хэсгээс бэлтгэсэн нэг зарчмын зөрөөтэй саналтай юм байна аа.

10.Төслийн 2.10 дугаар зүйлийн 1.2 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулж, мөн зүйлд доор дурдсан агуулгатай 2.2 дахь заалт нэмэх:

“1.2.Төсвийн тухай хуулийн 8.5.1-д заасны дагуу тухайн шатны жилийн төсвийн төслийг иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн мэдүүлэхдээ хүүхэд хамгааллын үйлчилгээ, хамтарсан баг болон хууль зүйн хорооны үйл ажиллагааны зардлыг тусгах;

2.2.Төсвийн тухай хуулийн 8.5.3-т заасны дагуу тухайн шатны жилийн төсвийн төслийг иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн мэдүүлэхдээ хүүхэд хамгааллын үйлчилгээ, хамтарсан баг болон хууль зүйн хорооны үйл ажиллагааны зардлыг тусгах;” санал гаргасан ажлын хэсэг гэсэн байна.

Саналтай гишүүд байна уу?

Санал хураалт.

66.7 хувиар дэмжигдлээ.

Төслийн 2.11 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу? Алга байна. Ажлын хэсгээс нэг зарчмын зөрөөтэй саналтай.

11.Төслийн 2.11 дүгээр зүйлийн 4 дэх хэсгийн “байгуулж болно” гэснийг “байгуулна” гэж, мөн зүйлийн 6 дахь хэсгийн “Засаг даргын орлогч” гэснийг “тухайн аймаг, дүүргийн Засаг даргын ажлын албаны хуулийн асуудал хариуцсан нэгжгийн дарга” гэж тус тус өөрчилж, 9 дэх хэсгийн “байгууллага,” гэснийг дараа “сум дахь хууль зүйн

хорооны нарийн бичгийн даргын үүргийг тухайн сумын хүүхэд, гэр бүлийн нийгмийн ажилтан” гэж нэмж, мөн зүйлийн 3 дахь хэсгийн “олон улсын байгууллагын төлөөлөл,” гэснийг, мөн зүйлийн 5 дахь хэсгийн “аймаг, дүүрэг,” гэснийг, 10 дахь хэсгийг тус тус хасаж, мөн зүйлийн 2 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“2.Хууль зүйн хорооны бүрэлдэхүүн дараах байгууллагын удирдах албан тушаалтнаас бүрдэнэ:

2.1.нутгийн өөрөө удирдах байгууллагын ажлын алба;

2.2.аймаг, дүүргийн хүүхэд, гэр бүлийн хөгжлийн газар, хэлтэс;

2.3.аймаг, дүүргийн боловсролын газар, хэлтэс;

2.4.аймгийн эрүүл мэндийн газар, дүүргийн нэгдсэн эмнэлэг, эрүүл мэндийн төв;

2.5.аймаг, дүүргийн хөдөлмөр, нийгмийн халамжийн үйлчилгээний газар, хэлтэс;

2.6.гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн ажлын алба;

2.7.Засаг даргын ажлын албаны хуулийн асуудал хариуцсан нэгж;

2.8.аймаг, дүүрэг дэх цагдаагийн газар, хэлтэс;

2.9.аймаг, нийслэл, дүүрэг дэх шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, хэлтэс;

2.10.аймаг, дүүргийн прокурорын газар;

2.11.шүүхийн тамгын газар, эсхүл шүүгч зөвшөөрсөн тохиолдолд.” Санал гаргасан ажлын хэсэг.

Мөнх-Оргил гишүүний микрофон санал хэлье.

Ц.Мөнх-Оргил: Зарчмыг нь дэмжиж байгаа юм. Тэгэхдээ энэ дээр байна шүү дээ эсвэл шүүгч тохиорсон зөвшөөрсөн тохиолдолд гэж. Энэ бол байж болохгүй байх хасах хэрэгтэй байх. Шүүгч чинь өөрөө хуулиар олгосон юутай үүрэгтэй шүү дээ.

Дараа нь энэ нөгөө Хууль зүйн хороогоор хэлэлцэж байгаа асуудлууд чинь шүүгч дээр ороод ирвэл яах юм. Эсвэл өмнө шүүгч тухайн шүүгч энэ асуудлуудыг нь шийдэж байсан бол яах вэ орон нутагт байнга л тийм юм гарна шүү дээ тийм ээ.

Тэгэхээр шүүгч чинь бол бие дааж хараат бусаар үйл ажиллагаа явуулж байх ёстой. Ямар нэгэн байдлаар өөр дээр нь очиж болох хэргүүдэд урьдчилан оролцохгүй байх ёстой гэх мэтийн хамгаалалтууд байдаг учраас тэр Тамгын газраас нь орвол ордог юм байгаа биз. Шүүгч бол хэрэггүй байх аа. Тэгээд энэ Цогзолоо юу яамаар байх юм аа. Техникийн чанартай гэх юм уу энэ хуулийн төсөл өргөн баригдахдаа энэ зүйлүүдээ юу яачихжээ? Дугаарлахдаа буруу дугаарлачихсан байна аа. Жишээ нь 1 дүгээр бүлэг нийтлэг үндэслэл 1.1 биш байхгүй юу 1 дүгээр зүйл хуулийн зорилго. Нөгөөдөх нь 1.2 биш хууль, Хүүхэд хамгааллын тухай хууль тогтоомж биш 2 дугаар зүйл гээд уншаад явчих юм бол дараа нь хэрэглэхэд амар байгаа байхгүй юу. Тэгэхгүй бол энийг чинь 4.6.5, 4.6.8 гээд л ингээд л яг нөгөө Эрүүгийн хуулийнх ишг аягүй хүнд дугаарлачхаж.

Тэгэхээр бид нар чинь бол ихэнх хуулиудаа бол бүлгүүдээ хуваагаад тэгээд зүйлүүд нь бол дэс дарааллаар явчхаж байгаа шүү дээ. Хэрэглэхэд амар байгаа байхгүй юу. Нэг их олон задаргаа

байхгүй. Тэгээд өргөн барихдаа тэгээд дараа нь яачихмаар хамгийн сүүлд нь нэг санал хураадаг шүү дээ тэ? Техникийн юм оруулах гэдэг. Ингээж ингээж засах гээд дараалал дугаарлалыг нь тэгээд засчихмаар юм байна шүү.

Ж.Чинбүрэн: Ажлын хэсгийн ахлагч сая шүүхийн тамгын газар эс үгүй бол шүүгч зөвшөөрсөн тохиолдол гэдэг дээр Идэрбат гишүүний микрофоныг нээе.

Ц.Идэрбат: Тийм энэ дээр яах вэ бас бидний хийсэн хэлэлцүүлэг, уулзалтууд дээр шүүх, прокурор, цагдаагийн байгууллага гээд олон энэ яг байгууллагуудын төлөөллүүд оролцсон. Тэрэн дээр бас нэг оролцсон манай нэг шүүгчийн санал юм байгаа юм.

Шүүхийн тамгын газрын дарга гэдэг чинь бол одоо тэгээд тэр тухайн шүүхийн хэвийн үйл ажиллагааг явуулахад чиглэсэн л үйл ажиллагаа явуулдаг болохоос биш энэ хүүхэд хамгааллын энэнд оролцох ямар ч боломжгүй ээ. Хэрвээ тэрний оронд харин ерөнхий шүүгч нь байдаг юм уу ийм хүмүүс байх шаардлага гардаг юм билээ гэж БЗД-ээс бас хэлж байсан юм байгаа юм. Тэрний дагуу орсон. Ийм л зүйл байгаа юм аа.

Харин бас энэ дээр нэг санал хэлэхэд яах вэ бидний хэлэлцүүлгүүд ингээд зарчмын зөрүүтэй 30 санал гарч байна гэдэг бол бас нэг бодлын олон боловчиг нөгөө талаасаа энэ хууль хэрэгжүүлж байгаа энэ төрийн болон анхан шатын байгууллагууд дээр зайлиггүй хэрэгтэй гэж хэлж ярьсан тэр зүйлийг хуулийн техник бусад холбогдох хуультай хэрхэн нийцэж байгаа вэ гэдгийг бас үзэж харж л оруулж ирж байгаа энэ саналууд юм байгаа юм. Энэ дээр харин тэр Хууль зүйн хорооны даргаар Засаг дарга орлогч гээд бидний санал бол орлогчийг

нь болиод Хуулийн хэлтсийн дарга гэсэн ийм санал оруулж байгаа.

Гэхдээ энэ нь ч нөгөө амьдрал баян л юм болохоор зарим газар орлогч нь олигтой ажиллахгүй хууль зүйн хороо чиг л байна. Зарим газар хуулийн хэлтсийн дарга нь сайн ажиллаж байгаа эсвэл муу ажиллаж байгаа ч юм байгаа юм. Тэгэхээр яах вэ энийг нь Засаг даргын орлогчийг нь бас нээлттэй орхичихъё гэдэг ийм саналыг бас гаргах гээд байгаа юм.

Яагаад гэвэл Засаг даргын орлогч гэдэг чинь улс төрийн албан тушаалтан. Тэр хүмүүс хуулийн хэрвээ хуульч хүн байх юм бол энэ дээр маш сайн ажиллаад байна гэж. Хуульчаас бусад өөр юу гэдэг юм малын эмч байдаг юм юм уу, өөр тийм хүмүүс байвал бас ажил нь явж өгөхгүй байна гээд. Тэгэхээр Засаг даргын орлогчийн өөрийнх нь ажлын туршилага гэдэг юм уу, мэргэжил гэдэг юм уу тэр зүйлийг нь харгалзаад Засаг даргын орлогчоороо томилж болох эсвэл Хуулийн хэлтсийн даргаараа, Хууль зүйн хэлтсийн даргаараа томилох ийм бололцоог нь бас давхар нээж өгье өө гэсэн ийм бодолтой байгаа.

Ж.Чинбүрэн: Тэгэхлээр Мөнх-Оргил гишүүн эс үгүй бол шүүгч зөвшөөрөх гэдэг маань нөгөө шүүгч биеэ даасан хуультай таны хэлдгээр болохгүй учраас өөрсдөө би сайн дурын үндсэн дээр бараг хийлгэнэ гэсэн санаа байна шүү дээ. Зөвшөөрнө гэдэг маань. Тэгээд ингэж орж болж байна уу гэдэг асуудал.

Шүүхийн тамгын газар гэдгээрээ үлдээгээд тэрийг нь аваад хаячихъя тэгэх үү? Тийм Мөнх-Оргил гишүүний хэлснээр.

Тэгээд ажлын хэсгийн ахлагчийн бас хэлж байгаагаар бол Засаг даргын орлогч гэсний ар дээр дараа гэж

хэлэхгүй бол болохгүй нь байна шүү дээ тэгвэл тийм гэсний дараа нэмэх гэж нэмэх гэхгүй бол та Засаг даргын орлогч байж болно гэж байгаа юм байна шүү дээ. Орлогч гэсний дараа яг тэгж л орох гээд байх юм.

Дараа гээд тэгээд нэмэх гэж. Тэгээд ийм томъёоллоор санал хураая.

Санал хураалт.

55.6 хувиар дэмжигдлээ.

Төслийн 2.12 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу? Алга байна. Санал гараагүй.

Төслийн 2.13 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух санал гараагүй гэж байна шүү дээ айн? Энэ дээр санал байгаа юм байна шүү.

12.Төслийн 2.12 дугаар зүйлийн 1.2 дахь заалтын “хүчирхийлэл үйлдсэн этгээдийг тогтоох зорилгоор хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа эхлэхээс өмнө” гэснийг хасаж, мөн зүйлийн 1.3 дахь заалтын “зөвлөгөө,” гэсний дараа “эрх зүйн туслалцаа, мэдээлэл өгөх, гэж, мөн заалтын “саналаа хэлэх,” гэсний дараа “хүсэлт гаргах” гэж тус тус нэмж, мөн зүйлийн 1.7 дахь заалтын “газарт нь” гэснийг “газар, тусгай өрөөнд” гэж өөрчлөх санал гаргасан ажлын хэсэг.

Саналтай гишүүд.

Санал хураая. Санал хураалтыг цуцалъя, санал хураалтыг цуцаллаа.

Санал хураалтаа явуулъя 55.6 хувиар дэмжигдлээ.

Төслийн 2.13 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу? Алга байна. Санал гараагүй.

Төслийн 2.14 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу? Алга байна санал гараагүй.

Төслийн 2.15 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу? Алга байна санал гараагүй.

Төслийн 2.16 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу? Алга байна. Санал гараагүй.

Төслийн 2.17 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу? Алга байна, санал байхгүй.

Төслийн 2.18 дугаар зүйлтэй холбогдуулан асуух асуулт гишүүд байна уу? Алга байна, санал гараагүй.

Төслийн 2.19 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу? Алга байна. Санал гараагүй.

Төслийн 3.1 дүгээр зүйлтэй холбогдуулан асуух асуулт гишүүд байна уу? Алга байна.

Ажлын хэсгээс бэлтгэсэн зарчмын зөрүүтэй санал уншиж танилцуулъя.

13.Төслийн 3.1 дүгээр зүйлийн 4 дэх хэсгийн “ашиглах,” гэсний дараа “хүүхдийг үл хайхрах,” гэж нэмж, мөн зүйлийн 8 дахь хэсгийг хасаж, мөн зүйлд доор дурдсан агуулгатай 8, 9 дэх хэсэг нэмэх:

“8.Хүүхдийн дэргэд согтууруулах ундаа хэрэглэсэн, эсхүл хэрэглэсэн үедээ орон байранд нэвтэрч хүүхдийг эрсдэлт нөхцөлд оруулсны улмаас гарсан хүүхэд хамгааллын үйлчилгээний зардлыг буруутай этгээдээр төлүүлэх арга хэмжээг хүүхдийн эрхийн улсын байцаагч авна.

9.Эцэг, эх хүүхдээ эрсдэлт нөхцөлд орж болзошгүй соёл, спортын үйл ажиллагаа, урлагийн тоглолтод оролцуулах тохиолдолд гэнэтийн ослын даатгалд даатгуулна.”

Санал гаргасан ажлын хэсэг гэсэн байна. Энэ дээр Мөнх-Оргил гишүүн санал хэлье. Мөнх-Оргил гишүүний микрофон. Санал хэлж байх хооронд.

Ц.Мөнх-Оргил: Энэ 8, 9 дүгээр заалт уг нь зөв л заалтууд л даа. Одоо энийг эсэргүүцээд байх хэн ч байхгүй. Тэгэхдээ 1 дүгээрт 8 дугаар заалт чинь миний ойлгосноор Зөрчлийн хууль дээр угаасаа байж байгаа заалт шүү дээ. Тэгээд энэ чинь зүгээр л хар ухаанаар бодоход нэг хуульд байгаа тэр тусмаа Зөрчлийн хуульд байгаа заалтыг өөр хуульд хуулж бичээд байх шаардлага байхгүй шүү дээ. Энэ чинь хууль тогтоох арга техник гэж байна. Наад захын элементарный шаардлага хангахгүй байгаа байхгүй юу.

Одоо яах юм энэ чинь бид нар Эрүүгийн хуульд байгаа юм уу, Зөрчлийн хуульд байгаа бүх заалтуудаа холбогдох заалт заалт дээр нь ингээд л хуулаад л бичээд байх юм уу?

Тэгэхлээр энэ 8 дугаар заалт бол тэр юун дээрээ л байж байг. Зөрчил дээрээ л байж байг.

Дараа нь 9 дүгээр заалт. Эцэг эх хүүхдээ эрсдэлт нөхцөлд орж болзошгүй соёл, спортын үйл ажиллагаа, урлагийн тоглолтод оролцуулах тохиолдолд гэнэтийн ослын даатгалд даатгуулна гэж байгаа. Энэ байна шүү дээ. Жишээ нь хүүхэд нь өөрөө соёл спортын арга хэмжээнд оролцох гэж байгаа. Өөрөөр хэлбэл спортын төрлөөр уралдаж байгаа ч юм уу нөгөө бага насны хүүхэд хурдан морь унаад явж байгаа ч юм уу тэнд бол

ойлгож байгаа юм. Эсвэл уран нугараач гээд тоглолтод оролцож байгаа тэр хүүхдүүд чинь даатгалтай байна уу. Ямар нэгэн байдлаар хөдөлмөр хамгаалалт хөдөлмөр нь хамгаалалттай явж байгаа шүү дээ. Зүгээр үзэх гээд явж байгаа хүүхдүүдийг энд яриад байна шүү дээ та нар. Соёл нөгөө урлагийн арга хэмжээ үзэх гээд явж байхад оролцуулах тохиолдолд гэж байгаа байхгүй юу.

Тоглолтод оролцуулах гэдгийг чинь тэгж л ойлгоно шүү дээ. Би тэгж л унших юм байна.

Тэгээд энэ бол гэнэтийн ослын даатгалд даатгуулна гэдэг нь яг тэрэндээ тулах юм бол энэ эцэг эх нь ч биш. Ажил олгогч нь жишээ нь циркт хүүхдийг уран нугаралт хийлгэж байна шүү дээ тийм ээ. Тэгэх юм бол энэ чинь Хөдөлмөрийн хуулиараа ийм байгаа шүү дээ. Эцэг эх, хөдөлмөрийн байцаагч, ажил олгогч 3 хамтарч гэрээ байгуулж байгаа байхгүй юу. Хүүхдийн хөдөлмөрийн гэрээн дээр чинь. Тэр гэрээнд чинь ихэнхдээ тусгагдаж байгаа. Ийм ийм эрсдэлийн эсрэг даатгуулна шүү гэж. Тэгэхээр тэр даатгал чинь бол ажил олгогч нь хийнэ. Эцэг эх бол энд гэнэтийн ослын даатгалд даатгуулах ямар ч бололцоо байхгүй шүү дээ.

Угаасаа гэнэтийн ослын даатгалын чинь ажил олгогч ажилчдаа хамгаалж хийх ёстой заалт байхгүй юу. Хэрвээ энд нөгөө ажил хийж байгаа хүүхэд биш зүгээр соёл урлагийн арга хэмжээнд оролцох гэж байгаа тэмцээн үзэх гэж байгаа хүүхдүүдийг та нар янз янзын зодоон цохионд орчих вий, байшин сав нь нурчих вий эсвэл олуулаа бужигнаж байгаад нэгийгээ гэмтээчих вий тийм юманд даатгал даатгуулна гэж байгаа бол энэ биш шүү дээ. Тийм юм байхгүй шүү дээ.

Тэгэхээр энэ дээр тайлбар өгөөд би энэ 8, 9 хоёрыг хасах саналтай байна.

Ж.Чинбүрэн: Ажлын хэсгийн ахлагч саналаа тайлбар өгнө үү? Идэрбат гишүүний микрофон.

Ц.Идэрбат: Яах вэ 8 дугаар зүйл заалттай холбоотой асуудал бол яах вэ зөрчлийн хууль дээр хүүхэд согтууруулах ундаа хэрэглэж болохгүй л гэсэн тийм зүйл заалт байгаад байгаа. Зүгээр бидний ажлын хэсгийн хувьд нэг ярьсан зүйл бол бидэнд байгаа стандарт юугаар мэдээллээр, статистик тоогоор бол ялангуяа энэ бага насны хүүхдийн хүчирхийлэлд өртөж байгаагийн шалтгаан энэ архитай холбоотой. Тэр дундаа жилдээ одоо энэ чинь 350 хэдэн хүүхэд бэлгийн хүчирхийлэлд өртсөн гэсэн ийм дүн мэдээ байгаа юм. Тэр дотроо 70 хувь нь ойрын төрлийн хамааралтай хүмүүс байна гэсэн ийм харамсалтай мэдээ байгаа.

Тэгэхээр бид энэ Зөрчлийн хууль дээр заагдсан энэ хүүхдийн дэргэд архи ууж болохгүйгээс гадна энийг дагуулаад ер нь бага насны хүүхэдтэй айлд ер нь согтуу хөлчүү орж болохгүй л гэсэн тийм л юмыг нийгэмд бас нэг юм өгөх гээд байгаа юм. Яагаад гэвэл яг иймэрхүү харьцаа ямар нэгэн зохицуулалтгүйгээс болоод энэ гэр бүлийн хүчирхийллийн асуудлууд чинь бас ялангуяа бага насны хүүхдийг бэлгийн хүчирхийлэлд оруулсан ийм зүйл заалт байгаа юм билээ. Нөхцөлүүд тогтоогдоод байдаг юм билээ. Итгэлтэй хүн нь гэсэн үг шүү дээ. Энд ярихад ам эвлэхээргүй тийм нөхцөлүүд л бас байдаг юм билээ.

Дараагийнх нь бол энэ яах вэ энэ тоглолтод оролцуулах тохиолдолд гэж байгаа. Харин сая Мөнх-Оргил гишүүний тэр ажил олгогч гэдгийг бас бид авах ёстой юм байна.

Оролцуулах гэж байгаа учраас оролцуулах гэдэг үгний ард бол бид ярихдаа бол тэр тэмцээн уралдаан үзэж байгаа юм уу тийм хүүхэд гэж үзэгчийн хувьд очиж байгаа хүүхдийг оруулаагүй. Тэр тэмцээнд тоглож байгаа тэр бүжиг танц хийж байгаа гэдэг юм уу тийм л хүүхдүүдийг оруулъя гэж. Тэгээд энэ дээр яах вэ зүгээр манай Соёл спортынхны уулзалт дээр ер нь бид энэ хүүхэд хамгааллын тогтолцоо ярихын тулд хүүхдүүд ер нь ямар нэгэн байдлаар даатгалд хамруулдаг байх гэнэтийн ослын юм уу, яг ийм нөхцөлүүдэд ер нь даатгалд хамруулах зүйл яригдах нь зүйтэй юм биш үү дээ гэдэг. Тэгээд хүүхдийг ингээд нэг соёл спортын арга хэмжээнд ашиглаж байгаад л өнөөх нь хөл гараа хугаллаа гэхэд тэгээд л ингээд л эцэг эх нь л үлддэг. Тэгээд иймэрхүү юмыг боливол яасан юм бэ гэсэн. Нөгөө талаасаа бас даатгалын бизнесийг дэмжих гээд байна ч гэдэг юм уу сөрөг юм гарч магадгүй. Гэхдээ л хүүхэд бас эрсдэлгүй байх л ёстой л гэсэн. Ийм л санааг агуулсан ийм 2 л зүйл байгаа юм аа.

Ж.Чинбүрэн: Мөнх-Оргил гишүүний микрофон.

Ц.Мөнх-Оргил: Хэрвээ 9 дүгээр заалт чинь соёл урлагийн спортын арга хэмжээ үзэж сонирхож яваа биш. Тэр соёл урлаг спортын арга хэмжээнд урлагийн тоглолтод биечлэн оролцоод, үзвэр хийж байгаа, эсвэл хурдан морь унаж байгаа хүүхдүүдийн асуудал ярьж байгаа бол энийг ингэж найруулах хэрэгтэй юм байна. Хөдөлмөрийн хуулийн нөгөө нэг заалт байгаа байхгүй юу. Тодорхой заалт.

Гуравласан гэрээ байгуулдаг заалт байгаа байхгүй юу. Би яг юуг нь мартчихаж.

Тэгэхээр тэр Хөдөлмөрийн хуулийн төдийн төдийн дагуу ингэж

ингэж ажил олгоод ингэж явж байгаа тохиолдолд гэнэтийн ослын болон ганц ч гэнэтийн ослын даатгал биш дээ энэ чинь. Өөр зөндөө даатгалууд байж болно шүү дээ. Тийм ээ?

Тэгэхээр тэр даатгалд ажил олгогч нь хамруулна гэж энэ хуульдаа зааж өгч байгаа юм. Тодотгох хэрэгтэй байна.

Ж.Чинбүрэн: Чухал санаа хэллээ.

9 дүгээр зүйл дээр.

Наймаа яах вэ байж байх уу? Гол санаа түрүүн Идэрбат гишүүн хэлчихлээ.

Тэгэхээр санал хураалтаа явуулчихъя. Энийг микрофон дээр хэлчихвэл яасан юм? Найрууллын томъёоллын саналаа тийм тэгэхлээр хэдүүлээ найруулгыг нь жоохон тодруулга хийе.

Хүүхдийн дэргэд согтууруулах ундаа хэрэглэсэн эс үгүй бол хэрэглэсэн үедээ гэдгийг. Мөнх-Оргил гишүүний хэлсэн саналаар хүүхдийн дэргэд согтууруулах ундаа хэрэглэсэн үедээ хохироосон нөхцөлд зардлыг буруутай этгээдээр төлүүлэх. Та хэлмээр байна.

Ц.Мөнх-Оргил: Энийг ингэж томъёолмоор юм байна аа. Агуулга нь 1 дүгээрт согтууруулах ундаа хэрэглэсэн үедээ хүүхэд хохироочихвол зардлыг нь төлнө. Согтууруулах ундаа хэрэглээгүй үедээ хүүхэд хохироочихвол зардлыг нь төлөхгүй юм шиг агуулга гараад байна шүү дээ. Тэгэхлээр ерөөсөө бүхэлд нь ямар нэгэн байдлаар хүүхдийн эрхийг хохироогоод тэрнээс ингээд ийм юм гарах юм бол тэр нөхрөөс нь хохирлыг нь ингэж, ингэж гаргуулна гэдэг ерөнхий санаагаа л ийшээ томъёолоод оруулчихъя.

Тэгэхдээ энэ дээр манайхан манай ажлын хэсгийнхэн Хууль зүйн байнгын хорооны ажлын хэсэгтэй, Үнэнбат дарга эд нартай та нар зөвлөлдөөдхөөрэй. Энэ чинь угаасаа санаа нь нөгөө нэг хохирол барагдуулах гэдэг заалт чинь угаасаа Эрүүгийн хуульдаа байж л байгаа заалт шүү дээ. Иргэний журмаараа ч болдог. Эрүүгийн хуульдаа ч байж байгаа заалт байхгүй юу.

Тэгэхээр тэрнээс нь яаж салгах вэ? Магадгүй эрүүгийн гэмт хэргийн хэмжээнд хүрээгүй байж болно шүү дээ тийм ээ. Гэхдээ хүүхдэд хохирол учирчихсан л байгаа байхгүй юу. Сэтгэл санааны ч юм уу бие махбодын ч юм уу тийм ээ. Гэхдээ зөрчил болоод эрүүгийн гэмт хэргийн шинж чанар агуулаагүй. Гэхдээ хохирол учирчихсан. Гэмт хэрэг шинж чанар агуулаад явчих юм бол тэр нөгөө юугаараа явна? Тэгэхлээр тэр ялгаануудыг нь гаргаад найруулчих тэгэх үү? Агуулга нь тийм л байх ёстой. Согтуу ч бай, согтуу биш ч бай хүүхэд хохироочихсон л байх юм бол тэр нөхөр би аюултай юм байна шүү, би зардал төлөх юм байна шүү гэдэг л нэг агуулга л байх ёстой. Тэгээд хэрвээ согтуугаараа орж ирэх юм бол бүүр ингэнэ шүү гэдэг бас юу байж болно.

Харин тийм нэмэлт байж болно. Тийм л агуулга байхгүй юу.

Ж.Чинбүрэн: Ажлын хэсгийн ахлагчийн гол санаа бол ерөөсөө согтууруулах ундаа ууж айлд орж болохгүй л гэдэг мессежийг өгөх гээд байна шүү дээ энэ хуульд. Тэгэхээр найруулгаа яаж унших юм тэгээд? Өсвөр нас чинь бас.

Тэгээд найруулъя, тэгэх үү? Тэгээд найруулна гэдэг байдлаар түрүүн уншсанаараа 2 заалт байна тэгээд санал хураачихъя.

Тэгээд хоёуланг нь найруулъя гэдгээр.

Санал хураалт.

55.6 хувиар санал дэмжигдлээ.

Төслийн 3.2 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу? Алга байна.

Ажлын хэсгээс бэлтгэсэн зарчмын зөрүүтэй 3 саналтай юм байна.

14.Төслийн 3.2 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 2.7 дахь заалт, 9, 10,11 дэх хэсгийг тус тус нэмэх:

“2.7.хичээлийн жилийн турш хүүхэд эрсдэлт нөхцөлд байгаа эсэхийг үнэлэх, зөвлөгөө өгөх, хүүхэд бүрийн нийгэм, сэтгэл зүйн асуудлыг илрүүлэх, тандан судлах арга хэмжээг тогтмол авч хэрэгжүүлэх;

9.Боловсролын орчин дахь хүүхэд хамгааллын үйлчилгээний нийтлэг шаардлагыг хүүхэд, гэр бүлийн хөгжлийн болон боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран батална.

10.Боловсролын сургалтын байгууллага, насан туршийн суралцахуйн төвд суралцаж байгаа хүүхдийн эрх, хамгааллын нөхцөл байдлын тандалт судалгааг гурван жил тутам Боловсролын ерөнхий хуулийн 17.2-т заасан байгууллагаар хийлгүүлнэ.

11.Боловсролын ерөнхий хуулийн 40.2.8-д заасан эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн төлөөллийн байгууллага хүүхдийн эрх, хүүхэд хамгааллын төлөвлөгөөтэй байна.” Санал гаргасан ажлын хэсэг.

Мөнх-Оргил гишүүн.

Ж.Чинбүрэн: Ням-Очир дарга аа. Энэ 3.2 боловсролын салбар дахь хүүхэд хамгаалал гээд их том гарчигтай юм байна шүү дээ. Энийг та хэд үзчихсэн, яам, агентлаг дээрээ ярьчихсан, санал нийлчихсэн, Боловсролын саяхан баталсан хуулийн чинь ерөнхий чиг агуулгатай нийцчихсэн, амьдрал практик дээр нийцэхээр хэрэгжүүлж болохоор заалтууд байна уу?

Ж.Чинбүрэн: Боловсролын ерөнхий газрын дарга Ням-Очир хариулт өгье.

Микрофон 7 дугаар микрофон.

Т.Ням-Очир: Боловсролын ерөнхий газрын дарга Ням-Очир Мөнх-Оргил гишүүний асуултад хариулъя.

БШУЯ-аас яг хуулийн энэ 3.2-той холбоотой заалт нэг бүр дээр найруулга саналаа өгсөн байгаа. Сая Боловсролын ерөнхий хууль холбогдох багц хуулиуд бас батлагдан гарсан. Үүнтэй нийцүүлээд энэ хуультай давхцахгүй болон яг Хүүхэд хамгааллын хууль гарснаар энэ хүүхэд хамгааллын үйлчлэх боловсролын байгууллагын сургалтын орчин дахь хүүхэд хамгааллын үйлчилгээг сайжруулахтай холбоотой бас томъёолол найруулгыг хийж өгсөн байгаа.

Ж.Чинбүрэн: Хариулт хангалттай.

Санал хураалт.

55.6 хувийн саналаар дэмжигдлээ.

Зарчмын зөрүүтэй 2 дахь санал нь Төслийн 3.2 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 2.11 дэх заалт, 4.5.2 дахь дэд заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“1.Боловсролын сургалтын байгууллага, насан туршийн суралцахуйн төв, сүм, хийд, шашны сургууль нь хүүхэд хамгааллын бодлого, түүнийг хэрэгжүүлэх төлөвлөгөөтэй байна.

2.12.хүүхэд тодорхойгүй шалтгаанаар хичээлдээ ирээгүй тохиолдолд гэр бүл, эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчид нэн даруй мэдэгдэх;

2.13.хүүхэд эрсдэлт нөхцөлд өртсөн талаар мэдсэн, таамагласан, илрүүлсэн бол харьяа хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал эрхэлсэн орон нутгийн байгууллага, хүүхэд, гэр бүлийн нийгмийн ажилтанд мэдэгдэх.

4.5.2.сэтгэл зүйн зөвлөгөө, үйлчилгээг үзүүлэх, хүүхдийн төлөвшилд нөлөөлөх сургалт, үйл ажиллагаанд эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн хамт хамруулах.” Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт 55.6 хувиар дэмжигдлээ.

Дараачийнх төслийн 3.4 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу? 3.2 дээр ахиад нэг санал байгаа юм байна.

Төслийн 3.2 дугаар зүйлийн 4.5.1 дэх заалтын “сануулах” гэсний дараа “зөвлөгөө өгөх, хохирогч суралцагчаас уучлалт гуйлгуулах” гэж, мөн зүйлийн 5.5 дахь заалтын “эрсдэлд нөхцөлд” гэсний өмнө “боловсролын сургалтын байгууллага, насан туршийн суралцахуйн төвийн сургалтын хөтөлбөрт” гэж тус тус нэмж, мөн зүйлийн 4 дэх хэсгийн “Боловсролын сургалтын байгууллагын удирдлага, хүүхдийн эрх, хамгааллын үйлчилгээ үзүүлэх нэгж” гэснийг “Боловсролын

сургалтын байгууллага, насан туршийн суралцахуйн төв” гэж, мөн хэсгийн “мэдээллийн мөрөөр нэн даруй хяналт шалгалт явуулж” гэснийг “мэдээллийг хүлээн авч,” гэж, мөн зүйлийн 4.5 дахь заалтын “суралцагчийг сургалт, сэтгэл зүйн зөвлөгөө үйлчилгээнд хамруулах,” гэснийг “хүүхдийг” гэж, мөн зүйлийн 6 дахь хэсгийн “Шашны байгууллага /сургууль/-ын дэргэдэх” гэснийг “Боловсролын сургалтын байгууллага, сүм, хийдийн” гэж, 8 дахь хэсгийн “Шашны байгууллага /сургууль/-д суралцах хүүхэд, түүний гэр бүлд” гэснийг “Боловсролын сургалтын байгууллага, сүм, хийдийн орчны аюулгүй байдалд” гэж тус тус өөрчилж, мөн зүйлийн 4.4 дэх заалтын “, удаа дараа хүчирхийлэл, үе тэнгийн дээрэлхэлтэд өртсөн суралцагч, түүний эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн зөвшөөрснөөр өөр бүлэг, сургууль руу шилжүүлэх” гэснийг, мөн зүйлийн 4.5.3, 4.5.4 дэх дэд заалт, 4.6, 4.7, 5.1, 5.3, 5.6 дахь заалт, 9 дэх хэсгийг тус тус хасах. Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

55.6 хувиар дэмжигдлээ.

Төслийн 3.3 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу? Алга байна. Ажлын хэсгээс бэлтгэсэн зарчмын зөрүүтэй нэг саналтай юм байна.

Төслийн 3.3 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн “байгууллага” гэсний дараа “эрсдэлд нөхцөлд байгаа” гэж нэмж, мөн зүйлийн 5.1, 5.3 дахь заалт, 6 дахь хэсгийг тус тус хасах. Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

55.6 хувиар дэмжигдлээ.

Төслийн 3.4 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу? Мөнх-Оргил гишүүн. Мөнх-Оргил гишүүний микрофон 3.4 дүгээр зүйл.

Энэ хэвлэл цахим орчин дахь хүүхэд хамгаалал гэсэн гарчгийг хэвлэл мэдээлэл өргөн нэвтрүүлэг гэж зассан юм байна л даа. Өргөн нэвтрүүлэг гэдэг чинь жишээ нь кабель орохгүй шүү дээ. Өргөн нэвтрүүлэгт. Хэвлэл мэдээлэл гэдэг дотор яг энэ радио телевиз, FM, зар сурталчилгаа явуулдаг телевиз кабель ч байна уу, өргөн нэвтрүүлэг ч байна уу эд нар орж байна уу? Энэ бол явж явж энэ хүүхэд хамгааллын хуулийн хамгийн чухал заалт болчихоод байгаа байхгүй юу. Янз бүрийн агуулгатай нэвтрүүлэг гаргах юм бол ямар арга хэмжээ авах юм. Юуг нь хориглох ю? Аль нь хориотой юм гэдгийг хэн тогтоох юм, хэзээ тогтоох юм? Хорттой гэдгийг нь хэн тогтоох юм гээд энэ чинь аягүй олон асуудлууд байгаа байхгүй юу.

Тэгэхээр эд нарыг бүгдийг нь зохицуулж чадсан уу? Жишээ нь өргөн нэвтрүүлгийг асуучихлаа. Жишээ нь хориотой контент гэж энэ дээр агуулга гэж орж ирж байгаа юм энэ хуулийн заалт дээр. Тэгэхээр хориотой гэдэг нь яг хаана хаана хэн хэн орчихсон байна аа? Тодорхой тодорхой хэлэх юм байгаа байна уу? Хэн тодорхойлж байгаа юм тэрийг? Энэ хуулиараа бид нар хэлчхэж байгаа юм уу? Тэгэхлээр тэрийг чинь задаргааг нь нэг байгууллага хийж өгөх ёстой шүү дээ.

Ж.Чинбүрэн: Баярлалаа. Ажлын хэсгийн ахлагч ярих уу? Уранчимэг бас байгаа тийм ээ? Тийм байгаа байгаа. Идэрбат гишүүний микрофон.

Ц.Идэрбат: Бид бас энэ хуулийн хэлэлцүүлэгтэй хуулийн төсөл өргөн баригдсантай холбогдуулаад ажлын хэсэг нэлээн бас ажилласан. Одоо нэг

хэсэг нь энэ байгаа. Үнэхээр ч ажиллахаас өөр аргагүй юм билээ. Тэгээд бид бол ингээд ажлын хэсэг дээр ярьж байгаад ер нь бол яг энэ цахим орчин дахь хүүхэд хамгааллын асуудал дээр бүүр тусдаа хууль хэрэгтэй юм байна. Үнэхээр энийг яг энэ Хүүхэд хамгааллын хуулиар бүгдийг нь зохицуулна гэвэл бас боломжгүй байна. Тэгээд энэ дээр Хууль зүйн яам, Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яам, Харилцаа холбоо, цахим хөгжлийн яам энэ 3 яам бол яг энэ цахим орчин дахь хүүхэд хамгааллын асуудлаар бас нэлээн зүгээр судалгаанууд бас хийж байгаа юм билээ.

Дээрээс нь Их Хурлын нэр бүхий гишүүд бас яг энэ цахим орчин дахь хүүхэд хамгаалалд гэсэн бүүр ийм тусдаа хууль ингээд санаачлаад явж байгаа юм билээ. Бидний хувьд бол ингээж ярьж байгаад энэ дээр тодорхой энэ дараагийн яг бүүр нарийн зохицуулалттай хууль гарч иртэл өнөөдөр зохицуулалтгүй байгаа юмнуудыг ямар ч байсан нэг зохицуулна гэсэн ийм л зүйлээр бас ярилцсан.

Энэ Харилцаа холбооны яам бол энэ дээр маш идэвхтэй санаачилгатай бас ажилласан гэдгийг би онцолж хэлэхийг хүсэж байгаа. Ер нь цахим орчин дахь энэ асуудал өргөн нэвтрүүлгийн хүрээнд ч тэр цахим орчиндоо өөрөө нийгмийн энэ сүлжээ энэ платформууд дээр ч гэсэн бид бас хамгаалалтууд байхгүй бол болохгүй юм байна. Энэ дээр орсон нэг зүйл бол энэ өргөн нэвтрүүлэг, хэвлэл мэдээллийн байгууллага нөгөө буух эзэнтэй буцах хаягтай энэ сайтууд эд нар бол дотооддоо хүүхэд хамгааллын бодлого хэрэгжүүлдэг тэр хориотой контентуудыг явуулах, явуулахгүй эсэхийг шийддэг тийм нэг дотоод нэг бүтэцтэй байя гэж, нэгт.

Хэрвээ тэрийг дотоод хяналт нь дутуу ажиллаад гэдэг юм уу ингээд явуулчихсан тохиолдолд ер нь энэ хориотой хортой контентуудыг явуулсан эсэхийг тодорхойлох нэг юу гарч ирэх бүтэц гарч ирэх хэрэгтэй болчихоод байгаа юм. Энэ Засгийн газраас өргөн барьсан хууль дээр бүүр хүүхдийн Үндэсний зөвлөл Ерөнхий сайдын ахалдаг үндэсний зөвлөлийн дэргэд дэд зөвлөл байя гэсэн ийм томъёолол анх орж ирсэн юм байгаа юм. Бид бол тийм шаардлага байхгүй. Энэ цахим орчин дахь энэ зүйл чинь маш хурдтай явах учраас энэ 3 яамнаас энэ журам юмнуудыг нь баталъя. Тэр хэсгийг нь хяналт тавих бүтцийг нь байгуулаад өгье өө. Энэ нь бол зөвхөн хүүхэд хамгаалалттай холбоотой хортой хориотой контент тодорхойлох ийм юмыг нь явуулъя.

Энэ өргөн нэвтрүүлгийн ч юм уу энэ сайт хэвлэл мэдээллийн байгууллагад орохгүй хувиараа эсвэл нууц хаягаар, өөрийнхөө нэрээр явж байгаа ийм зүйлүүд дээр бол хүүхдийн эрхийн байцаагч тухайн нутаг дэвсгэртээ тэгээд хяналтаа тавья.

Хүүхдэд хортой хориотой, хүүхдийн эрхэд хандсан ийм контент эсвэл тийм постууд ингээд яваад байх юм бол энийг хүүхдийн эрхийн улсын байцаагч холбогдох хуулийн байгууллагад нь өгөөд шалгуулдаг ийм л тогтолцоог нэн түрүүнд хийж өгье л гэсэн ийм юм байгаа. Гэхдээ дахиад онцолж хэлэхэд ингэснээрээ бүх юм бас шийдэгдчихэж байгаа юм биш. Ер нь тусдаа бие даасан хууль зайлшгүй хэрэгтэй юм байна л гэж ингэж үзэж байгаа юм.

Ж.Чинбүрэн: Энэ дээр Харилцаа холбооныхон маань харилцаа холбоо нэг номерын микрофон. Тэр өргөн нэвтрүүлгийн кабель энэ тэр орж

байгаа юу FM энэ тэр гээд асуулаа. Нэг номер Батболд арга юм уу?

Л.Нямдорж: Та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэе.

Цахим хөгжил харилцаа холбооны яамны Хуулийн хэлтсийн дарга Нямдорж байна аа. Мөнх-Оргил гишүүний асуусан асуулт дээр тодруулга 2 зүйлийг бас нэмж хариулъя.

Нэгдүгээрт өргөн нэвтрүүлэгт кабелийн телевиз орж байгаа юу гэдэг асуулт байна.

Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн 4.1.1, 4.1.2 дээр өргөн нэвтрүүлэгт бол кабелийн телевиз орж байгаагаар ингээд зохицуулсан байж байгаа.

Дараагийн зүйл нь энэ хориотой агуулга гэдэг зүйлийг бас асуусан. Энэ бол хориотой. Агуулга нь Садар самуунтай тэмцэх тухай хууль, Архидан согтуурахтай тэмцэх тухай хууль мөн Зар сурталчилгааны хуулиуд дээр хориотой контент гэдэг талаасаа бол зохицуулсан байж байдаг. Бид контент гэдэг үгийг яг оруулах гэхээр энэ дээр бас шинэ нэр томъёолол оруулж ирж байгаа юм. Хориотой агуулга, хортой агуулга гэдэг 2 нэр шинэ томъёог оруулж ирж байгаа юм.

Тэгээд яагаад контент гэдэг үг оруулахгүй байгаа вэ гэхээр энэ хэвлэл мэдээлэл дээр контент гэдэг үг нь орчихоор зөвхөн электрон хэлбэрт буугдсан гэдэг энэ ойлголт нь ороод ирж байгаа юм. Тэгэхээр контент гэдэг үгийг оруулахгүйгээр хориотой агуулга, хортой агуулга гэдэг зүйлээр нь оруулж ирж байгаа юм аа.

Хоёр асуулт дээр ингээд нэмж тодруулаа.

Ж.Чинбүрэн: Мөнх-Оргил гишүүн болж байна уу? Хариулт хангалттай юу?

Уншиж танилцуулъя.

Төслийн 3.4 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн “мэдээ, мэдээлэл, зар сурталчилгаа” гэснийг “хүүхдэд хортой агуулга” гэж өөрчилж, мөн зүйлийн 3-11 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“3.Хүн, хуулийн этгээд хүүхдийг цахимаар урхидах, дээрэлхэх, дарамтлахыг хориглоно.

4.Хүн, хуулийн этгээд хүүхдийн нэр төр, алдар хүндийг гутаан доромжилсон, эсхүл хүүхдийн эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн зөвшөөрөлгүйгээр хүүхдийн зураг, дуу, дуу-дүрсний бичлэг агуулсан контент, мэдээ, мэдээлэл, бүтээлийг олон нийтэд түгээхийг хориглоно.

5.Хэвлэл мэдээлэл, өргөн нэвтрүүлэг, цахим орчны үйлчилгээ эрхлэгч өөрийн үйлчилгээнд хориотой агуулгыг түгээхгүй байх, хүүхдэд хортой агуулгыг хянах, хязгаарлах, хаах арга хэмжээ авах үүрэгтэй.

6.Интернэтийн үйлчилгээ эрхлэгч нь эрх бүхий байгууллагын дүгнэлт, шийдвэрийн дагуу цахим орчинд түгээсэн хүүхдэд хортой болон хориотой агуулгыг өөрийн сүлжээнд хязгаарлалт хийх технологийн арга хэмжээг авна.

7.Өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэгч контент, бүтээлийг олон нийтэд түгээхийн өмнө насны ангиллын тэмдэглэгээг байршуулна.

8.Олон суваг дамжуулах үйлчилгээ эрхлэгч хүүхдийг хориотой,

хүүхдэд хорттой агуулгаас хамгаалах зорилгоор насанд хүрэгчдэд зориулсан тохиргоог идэвхжүүлэх нөхцөлийг бүрдүүлсэн байна.

9. Олон суваг дамжуулах үйлчилгээ эрхлэгч Харилцаа холбооны зохицуулах хорооны мэдэгдэлд заасан хориотой, хүүхдэд хорттой агуулгыг өөрийн үйлчилгээнд хязгаарлах, хаах үүрэгтэй.

10. Хүн, хуулийн этгээд хэвлэл мэдээлэл, өргөн нэвтрүүлэг, цахим орчинд хориотой агуулга түгээснээс хүүхдийн эрх зөрчигдсөн, зөрчигдөж болзошгүй гэж үзвэл гомдлоо хүүхдийн эрхийн улсын байцаагч, цагдаагийн байгууллагад гаргаж, шийдвэрлүүлнэ.

11. Цахим орчинд хүүхдийг хориотой болон хүүхдэд хорттой агуулгаас урьдчилан сэргийлэх, хамгаалах журмыг цахим хөгжил, харилцаа холбооны, хүүхэд, гэр бүлийн хөгжлийн болон хууль, зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран батална.

12. Хэвлэл мэдээлэл, олон суваг дамжуулах болон цахим орчны үйлчилгээ эрхлэгчийн цахим орчин, өргөн нэвтрүүлгээр түгээсэн контент, мэдээ, мэдээлэл, бүтээл нь хүүхдэд хорттой агуулгатай эсэх талаар дүгнэлт гаргах чиг үүрэг бүхий орон тооны бус зөвлөл ажиглана.

13. Энэ зүйлийн 12-т заасан орон тооны бус зөвлөлийн бүрэлдэхүүн, ажиглах журмыг Засгийн газар батална.”. Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт. Санал хураалтыг цуцаллаа.

Булгантуяа гишүүний микрофоныг нээе. Булгантуяа гишүүний микрофоныг нээгээрэй.

Х.Булгантуяа: Энэ асуудлыг энэ хуулийг хэлэлцэх эсэхийг хэлэлцэж байхад Цахим хөгжил, харилцаа холбооны сайд энэ хүүхдийн 11 цахим орчинд хүүхдийг хориотой болон хүүхдэд хорттой агуулгаас урьдчилан сэргийлэх журмыг хэн Цахим хөгжил, харилцаа холбооны сайд ер нь дангаараа баталчхаж бараг болно. Тэртээ тэргүй энэ бусад өргөн гэх мэтчилэн цахим гэлтгүй угаасаа ийм үндэсний зөвлөл байдаг. Тэрэн дээр манай яамны дэд сайд бас ордог. Яг ийм ийм жишигээрээ бас энэ хүүхэд хамгааллын бас нэг зөвлөлтэй байна гэж байна шүү дээ. Ийм байдлаар Цахим хөгжил харилцаа холбооны сайд ахлаад манай дэд сайд оролцоод ингээд явчихвал яасан юм бэ гэдэг саналыг гаргаж байсан. Ер нь бас болохгүй зүйл бол байхгүй.

Ж.Чинбүрэн: Санал хэллээ.

Х.Булгантуяа: Шууд зөвлөл гээд тавьчихъя. Дүгнэлт гаргах 11 холбооны хүүхэд гэр бүлийн хөгжлийн 2 журам сайд хамтран батална гэдгийг Цахим хөгжил, харилцаа холбооны сайд батлахаар. Дээрээс нь нэмээд орон тооны бус зөвлөл байна гэж байна шүү дээ тэ? Тэр талаар дүгнэлт гаргах чиг үүрэг бүхий энийг ерөөсөө сайд нь ахлаад л Цахим хөгжил харилцаа холбооны сайд ахлаад л манай дэд сайд бүрэлдэхүүнд нь ороод л явчихдаг. Ямар зөвлөл гэдэг билээ? Цахим хөгжлийн яамныхан. Танай сайд ахалдаг нэг зөвлөл байдаг шүү дээ. Бүүр өргөн өргөн нэвтрүүлгийн энэ тэр гээд? Манай дэд сайд байдаг. Нэлээн олон яамны дэд сайд байна, Соёлын дэд сайд энэ тэр байдаг.

Ж.Чинбүрэн: Энэ дээр 11 дээр бол сая Булгантуяа сайдын хэлдгээр уг нь хамтарсан 2 яам хамтраад хийвэл энэ их сайн л юм шиг харагдаж байна шүү дээ. Ганцхан цахим таны санал бол

Цахим хөгжлийн яам хийчих гээд байна уу? Тийм.

Х.Булгантуяа: Зөвлөлийг нь болохоороо дахиж нэг зөвлөл байгуулж байхаар танай тэр зөвлөлийн бүүр юугаар явчихвал яасан юм бэ? Тэрүүн дээр маш олон яамны Соёлын, яамны дэд сайд, манай яамны дэд сайд ордог нэг зөвлөл байдаг юм.

Дээрээс нь нэмээд ахиад батлахыг нь болохоороо энэ зөвлөлөөсөө гаргасан зөвлөмжийн дагуу танай сайд баталсан ч болно оо гэдэг тийм байр суурьтай байгаад байгаа юм.

Ж.Чинбүрэн: Нэг номерын микрофон Цахим хөгжлийн яам Хуулийн хэлтсийн дарга Нямдорж.

Нэг номерын микрофон нээлээ.

Т.Нямдорж: Зөвлөл гэдэг нь болохоор Үндэсний зөвлөлийг Булгантуяа сайд хэлж байх шиг байна тийм үү? Дэд сайдууд орж байгаа. Бид хэд ажлын хэсэг дээр бас ярилцсан. Үндэсний зөвлөлөөс яг энэ журмыг батлахад бас тохиромжгүй юм байна гэж үзсэн байгаа.

Дээрээс нь сайдуудын хооронд хамтарсан энэ журмыг батлахгүй бол 1 дүгээрт хүүхэд хамгааллын асуудал орж байгаа энд.

Хоёрдугаарт цагдаагийн бас асуудал орж байгаа. Тийм учраас ерөөсөө энэ журмыг хамтрахгүй бол болохгүй юм байна гэдгийг бас яг бид хэд яаман дээрээ зохицуулах дээрээ бид нар ажлын хэсгийн, Дэд ажлын хэсгийн хажууд дахиад ажлын хэсэг гаргаад ингээд ярилцсан. Бас энэ талаар бас бид хэд нэлээн нухацтай ярилцсан. Тийм учраас ерөөсөө хамтарч яг энэ журмыг батлахгүй бол болохгүй юм байна гэж бид хэд үзсэн байж байгаа.

Хоёр дахь хувилбар нь бол бас Засгийн газраас яг энэ журмыг батлавал бас илүү бас зохимжтой юм байна гэж бас 2 янзын хувилбар гарч ирсэн байж байгаа.

Ж.Чинбүрэн: Хариулт тодорхой.

Санал хураалт.

Санал дэмжигдсэнгүй ээ.

Бейсен гишүүний микрофоныг нээе.

Б.Бейсен: Дэмжиж санал өгсөн боловч энэ төхөөрөмж ажиллаагүй. Дахиж санал хураалгаж өгнө үү?

Санал хураалтыг хүчингүй болгох санал хураалт.

66.7 хувиар Бейсен гишүүний санал дэмжигдлээ.

Дахин санал хураалт явуулъя.

Түрүүн санал хураалтыг уншсан.

Санал хураалт.

Төслийн 3.4 дүгээр зүйлд доор дурдсан агуулгатай дараах тайлбар хэсэг нэмэх:

“Тайлбар: Энэ зүйлд заасан “цахим орчны үйлчилгээ эрхлэгч” гэж цахим хуудас, цахим хэрэглүүр /аппликэйшн/, платформ, цахим орчин ашиглаж контент, бүтээлийг олон нийтэд хүргэх үйлчилгээ үзүүлэгч этгээдийг ойлгоно.

Энэ зүйлд заасан “цахимаар урхидах” гэж хүүхдийг гэмт хэрэг, зөрчилд уруу татах зорилгоор цахим сүлжээ ашиглан хүүхэдтэй харилцаа тогтоохыг хэлнэ.

Энэ зүйлд заасан “цахимаар дээрэлхэх” гэж цахим орчинд хүүхдийг дээрэлхэж, гадуурхсан, айлган сүрдүүлсэн, доромжилсон зүй бус агуулга бүхий мэдээ, мэдээллийг өөрт нь болон бусдад түгээхийг хэлнэ.

Энэ зүйлд заасан “цахимаар дарамтлах” гэж хүүхдийг тодорхой үйлдэл хийх, хийхгүй байхыг шаардаж өөрт нь, түүний ойр дотнын хүний эрх, хууль ёсны ашиг сонирхолд нь хохирол учруулж болохуйц баримт, мэдээлэл тараахаар цахим сүлжээнд сүрдүүлэхийг хэлнэ. Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

55.6 хувиар дэмжигдлээ.

Төслийн 3.5 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу? Алга байна ажлын хэсгээс бэлтгэсэн зарчмын зөрөөтэй нэг саналтай.

Төслийн 3.5 дугаар зүйлийн 2, 6 дахь хэсгийг тус тус хасаж, мөн зүйлд доор дурдсан агуулгатай 5 дахь хэсгийг нэмэх:

“5.Сум, дүүргийн Засаг дарга, хүүхдийн эрхийн улсын байцаагч худалдаа, үйлчилгээний газар, боловсролын сургалтын байгууллагаас гадуурх сургалтын ажил эрхэлдэг иргэн, хуулийн этгээдийн үйл ажиллагаанд хүүхдийн эрх зөрчигдөж байгаа эсэхэд хяналт тавьж, хүүхдийг эрсдэлт нөхцөлд оруулсан бол уг үйл ажиллагааг хязгаарлах, зогсоох арга хэмжээ авна.”

Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

55.6 хувиар дэмжигдлээ.

Төслийн 3.6 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу? Мөнх-Оргил гишүүн 3.6

Ц.Мөнх-Оргил: Баярлалаа. Энэ бас их чухал заалт байгаа юм.

Соёл, спортын үйл ажиллагаа дахь хүүхэд хамгаалал гэж. Тэгэхээр энэ ийм санал байна. Энэ нэг дээр байна шүү дээ. Соёл, спортын үйл ажиллагаа, урлагийн тоглолт, спортын тэмцээн, бусад арга хэмжээнд хүүхдийг эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн бичгээр эсвэл цахимаар өгсөн зөвшөөрлийн үндсэн дээр оролцуулна гэж байгаа юм. Тийм үү? Тэгэхээр энэ дахиад нөгөө нэг түрүүний асуудал гарч ирнэ. Үзэх гээд явж байгаа хүүхэд юм уу оролцох гээд тэмцээнд оролцох гээд явж байгаа хүүхэд юм уу? 1 дүгээрт тэрийгээ тодруулмаар байна.

Хоёрдугаарт энэ байна шүү дээ. Ашиг олох зорилгогүйгээр, бизнесийн чиглэлгүйгээр зүгээр сургалт боловсролын нормалнын үйл ажиллагаа явж байна шүү дээ. Тийм юман дотор соёл, спортын үйл ажиллагаа, урлагийн тоглолтод оролцож байвал эцэг эхээс зөвшөөрөл авах шаардлагагүй шүү дээ. Жишээ нь сургууль дээр урлагийн үзлэг болж байна. Сургууль дээр ангиудын хооронд юм уу сургуулиудын хооронд тэмцээн болж байна. Тэрэн дээр бол эцэг эхээс хүүхдийг чинь сагсны тэмцээнд оруулах гэсэн юм. Эсвэл урлагийн үзлэгт оруулах гэсэн юм гээд зөвшөөрөл аваад байх шаардлагагүй байгаа байхгүй юу.

Харин үгүй ээ сургууль дээрээ тэмцээн болж байхад юу гэж эцэг эхээс нь сургуулийн хүүхдүүд тэмцээнд орох гэж байна зөвшөөрөл авъя гэж орохгүй шүү дээ.

Сургуулийн хүүхдүүдийг гадагшаа авч явах гэж байна тэгвэл

авна. Энэ дотор чинь бүх арга хэмжээнд оролцоход эцэг эхээс зөвшөөрөл бичгээр авна гэххээж байгаа байхгүй юу. Бичсэн юмаа унш л даа та нар. Боловсролын яам бишээ чиний бичиж өгсөн юм чинь тэгээд биччихсэн байна.

Тэгээд энэ дээр байна шүү дээ нэгдүгээрт сургуулийн орчноос нь гадуур авч гарч байгаа.

Хоёрдугаарт ямар нэгэн байдлаар бизнес юм уу мөнгө олох орлого олох зорилгоор хийж байгаа бол энэ бичгээр зөвшөөрөл авна. Бусдаар бол зөвшөөрөл авахгүй шүү дээ, нэгдүгээрт тэрийг тодруулмаар байгаа юм.

Хоёрдугаарт энэ зургаа дээр ингэчихсэн байгаа байхгүй юу. Үндэсний баяр наадмын тухай хуульд зааснаас бусад тохиолдолд хурдан морины уралдаан хийх гэж байвал сум дүүргийн Засаг даргад мэдэгдэж бүртгүүлнэ гэж байгаа юм. Тэгэхээр энэ дээр Идэрбат гишүүнээ тэгээд бүртгүүлээд яах юм. Бүртгэхгүй гэвэл яах юм? Бүртгээгүй байсан ч гэсэн уралдаанаа хийчих юм уу? Эсвэл заавал бүртгээж байж бүртгэсэн бүртгээгүй уралдаанаа хийгээд явчаж болох юм уу? Энэ ерөөсөө нэг үр дагавар нь ойлгогдохгүй байгаа юм. Тэгээд энэ хурдан морины уралдаан дээр юу байна. Нөгөө нэг Үндэсний баяр наадмын хууль дээр давхацсан заалтууд байна.

Тэрнийхээ давхардлыг арилгахивал яадаг юм бэ?

Ж.Чинбүрэн: Ажлын хэсгийн ахлагч хариулах уу? Идэрбат гишүүн.

Ц.Идэрбат: Соёл, спортой холбоотой үйл ажиллагаан дээр яг таны хэлж байгаа сургуулийн орчинд хийгдэж байгаа урлагийн үзлэг байдаг юм уу? Сургуулийн аварга шалгаруулах янз янзын уралдаан тэмцээнд бол зөвшөөрөл авахгүй гэдгээр. Бусад

бүсийн байдаг юм уу сургууль хоорондын байдаг юм уу ийм үйл ажиллагаанд гэж ингэж бас ярилцсан ийм зүйл байгаа. Харин тухайн хүүхдийг оршин байгаа газраас нь өөр газарт хоногоор авч явах тохиолдолд гэдэг нэг тийм шинэ зүйлийг оруулсан байгаа.

Мөн дээрээс нь олон хүүхдийг нэг багш авч явах ч байдаг юм уу эсвэл машин унааны оролцоо хүрэлцээ байдаг юм уу орон байрны хүрэлцээ томилт энэнээсээ шалтгаалаад нэг хүнд хэтэрхий олон хүүхдийг хариуцуулж явуулахгүй гэдэг нэг ийм зүйл заалтыг бас оруулсан байгаа.

Таны яг онцолж асуусан энэ бүртгэл ер нь ямар учиртай юм гэж? Яах вэ Үндэсний баяр наадмын хуультай учраас тэр баяр наадам дээр бол энэ хүүхэд хамгааллын асуудал бол маш чухлаар яригддаг.

Гэтэл нийгэмд ингээд морин уралдаантай холбоотой янз янзын сөрөг юмнууд өгөөд хүүхэд бэртсэн байна ч гэдэг юм уу ийм зүйлүүд тухайн орон нутагтаа ямар нэгэн байдлаар мэдэгдэхгүй сунгаа янз янзын юмнууд бас явдаг ийм тохиолдлууд байгаад байгаа юм.

Тэгэхээр энийг бол бид хорино, цагдана гэх биш харин энэ уралдаанлах юмнуудаа эхэлж мэдэгдэх ёстой. Мэдэгдсэний хүрээнд энэ нөгөө нэг бид нарын сум болгонд бий болгох гээд байгаа тэр хүүхэд хамгаалал, гэр бүл, хүүхэд хамгааллын ажилтан, тэр хүүхдийн хувцас хунар нөгөө Үндэсний баяр наадам дээр заасан тэр хүүхэд хамгааллын тогтолцоо тэнд ажиллаж байна уу, үгүй юу гэдгийг давхар хянаад ингээд явдаг л болох л ийм л зүйл байгаа юм. Харин Үндэсний баяр наадам дээр тусгагдчихсан зүйл заалтууд бас давхардсан байна гэж байна. Энэ дээр ажлын дэд хэсгийнхэн маань бас

анхаарч ажиллах нь зүйтэй байх гэж ингэж би хариулья.

Энэ дээр нэг зүйлийг бас нэмж оруулсан нь үндэсний баяр наадам дээр энэ дээр нэг уяач гэдэг зүйлийг ойлгохдоо хурдан морины тэр цаад эзнийг ойлгоно гэсэн нэг ийм бас нэг тайлбар юмнууд бас нэмээд оруулчихсан байгаа гэж ингэж хэлье.

Ж.Чинбүрэн: Баярлалаа. Ренчиндорж, Баттулга энэ хуулийн 2 зөвлөхөөс нь юу авчихъя Ренчиндорж Баттулга 2-ыг хэн найруулах вэ гараа өргөөрэй. 6 номерын микрофон нээе. Баттулга.

П.Баттулга: Нэгдүгээрт нь сум дүүргийн Засаг даргад бүртгүүлдэг заавал зөвшөөрлийн энэ тэр асуудал яригдахгүй. Зөвхөн ийм уралдаан зохион байгуулах гэж байна шүү гэдгээ мэдэгдэнэ. Тэрэнтэй холбоотой сум дүүргийн Засаг дарга хүүхэд гэр бүлийн нийгмийн ажилтанд хяналтаа тавих ийм асуудал нөхцөлийг нь бүрдүүлж байгаа гэдэг утгаар яг зөвшөөрөл авна гэдэг утгаар бол ороогүй гэдгийг тайлбарлая.

Үндэсний их баяр наадмын тухай хуультай яг уялдуулах асуудал бол яригдаж байсан. Энийг нь бас ажлын хэсэг дээрээ эргэж ярья гэж хэлмээр байна.

Ж.Чинбүрэн: Мөнх-Оргил гишүүний микрофоныг нээе.

Ц.Мөнх-Оргил: Асуусан асуулт тэгээд хариултгүй л үлдээд байна л даа. Гол нь энэ дээр бүртгүүлнэ гэдэг чинь ямар үр дагавартай юм бэ л гэж би асуугаад байна шүү дээ. Бүртгүүлчээд хийчихвэл окэй болчихлоо, бүртгүүлээгүй бол яах юм? Бүртгүүлээгүй хийчихсэн бол яах юм? Тэр хүнийг торгох гээд байгаа юм уу

эсвэл тэр уралдааныг нь хүчингүйд тооцох гээд байгаа юм уу? Эсвэл ерөөсөө тэр хүнийг дахиж морь уралдуулах уяач хийхийг нь зөвшөөрөхгүй хориглох гээд байгаа юм уу? Энэ чинь ойлгомжгүй санкцгүй байна шүү дээ 1 дүгээрт.

Хоёрдугаарт хуралдаан даргалагч энэ дээр нэг юм анхаарч өгөөч.

7.1 дээр ийм өгүүлбэр байгаа байхгүй юу. Уралдаанч хүүхдийн сурч боловсрох эрхийг хязгаарлахгүй байх гэж байгаа байхгүй юу. Тэгэхээр энэ хязгаарлахгүй байх тухай асуудал биш л дээ. Энэ чинь нөгөө хүүхэд нь сурах гээд байхад нь өө чи сурч болохгүй шүү. Чи уралдаантай чи хичээлдээ явж болохгүй гэдгээ хэлээд байгаа байхгүй юу. Тэрнээсээ илүү нөгөө хүүхэд нь өөрөө сургуулиа таслаад явчихыг энд хязгаарлаж өгөхгүй байна шүү дээ тэ.

Тэгэхээр тэр хүүхэд уралдаанд орж байна уу, янз бүрийн спортын арга хэмжээнд орж байна уу хамаагүй заавал сургуульдаа хамрагдаад тэр хөтөлбөрөө дуусгаж байх ёстой гэдэг санаа энд явж байх ёстой шүү дээ. Энэ бол зөвхөн уяач юм уу тэр багш нар нь хязгаарлаж болохгүй шүү гээд багш нарт нь үүрэг болгоцхоод байгаа юм.

Тэгэхээр эцэг эхэд нь эцэг эх нь тэр хүүхдээ заавал ч үгүй сургуульд нь хамруулаад дуусгах ёстой байхгүй юу. Тэр санаа энд орхичхоод байгаа юм.

Ж.Чинбүрэн: Баттулга аа. Эцсийн хэлэлцүүлэг дээр тэр Зөрчлийн хуультай холбоотой янз бүрийн санкцууд орох асуудал. Тэрэнтэй холбоотой мэдээлэл өгөөч? 6 номер. 6 номерын микрофон.

П.Баттулга: Тэгээд энэ дээр цахим орчин энэ тэртэй холбогдуулаад

яг Зөрчлийн тухай хуульд тодорхой зөрчил гаргасан хүмүүс хуулийн этгээдэд ямар хариуцлага хүлээх вэ гэдэг боловсруулаад явж байгаа. Тэгээд эцсийн хэлэлцүүлэг дээр дэмжигдэх юм бол тэр Зөрчлийн тухай хуулийн нэмэлт, өөрчлөлт оруулах төслийг боловсруулах боломжтой байгаа.

Ж.Чинбүрэн: Тэгвэл ямар ч байсан эцсийн хэлэлцүүлэг дээр хэрвээ мэдэгдээгүй байж байгаад хийчихсэн байх юм ямар зөрчлөөр санц хийх вэ гэдгээ боловсруулж нэмэлт үйлчилгээ оруулна гэдэг ярьж байгаа юм байна. Энийгээ эцсийн хэлэлцүүлэг дээр.

Хоёрт сая бас санаанууд логикууд орууллаа. Тийм эцэг эх нь хариуцлага хүлээх асуудлыг, зөвхөн уяач хүүхдийг сургуульд явуулах биш эцэг эхийн асуудал гээд. Тэгээд найруулга дээрээ энэ хэсгийг нэмж оруулна гэж ойлгоод санал хураачих уу?

Тийм санал хураалт.

Тайлбар энэ зүйлд заасан уяач гэдгийг хурдан морины уралдаанд уралдаж байгаа морины өмчлөгчийг ойлгоно гэсэн ч түрүүн ажлын хэсгийн дарга хэлсэн.

66.7 хувиар дэмжигдлээ.

Төслийн 3.7 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт энэ дээр ахиад нэг хэсэг хэлье. төслийн 3.6 дугаар зүйлийн 9.10 дахь хэсгийг хасаж мөн зүйлийн 2 дахь хэсгийг оролцуулахдаа гэсний дараа хүүхдийн амь нас, эрүүл мэнд, аюулгүй байдлыг хангах гэж мөн зүйлийн 4 дэх хэсгийн дасгалжуулагч гэсний дараа зохион байгуулагч гэж тус тус нэмж мөн зүйлийн 5.2 дахь заалтыг хамруулж өсөлт хөгжлийн талаар дүгнэлт гаргуулах гэснийг хамруулах гэж өөрчлөн мөн зүйл доор дурдсан

агуулгатай 5, 6 дахь хэсэг тайлбар хэсгийг тус тус нэмэх.

5.Хүүхдийг оршин суугаа газраас өөр газарт айн уншихсан тэ? Болчихсон гэсэн үг үү? Болчихлоо энийг санал хураачихсан.

Мөнх-Оргил гишүүний микрофон. Энийгээ хураачихсан хураачихсан Мөнх-Оргил гишүүн.

Ц.Мөнх-Оргил: Энэ 3.7.5 дээр гамшиг, гамшигийн онцгой нөхцөл байдлын үед үзүүлэх хүүхдийн хамгааллын үйлчилгээний стандартыг Стандартчилал техникийн зохицуулалтын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага батална гэж байна шүү дээ тэ. Энэ заалтыг хасах хэрэгтэй юм байгаа юм аа.

Яагаад гэвэл стандартчиллын байгууллага чинь тухайн үйлчилгээ юм уу бараа бүтээгдэхүүнийг үйлдвэрлэж байгаа аж ахуйн нэгжүүдээс ирүүлсэн стандартын саналыг судалж үзээд энийг бол танай хувьд ийм стандарт болголоо тэгээд сайн дурынх байхгүй юу. Стандартчилал хэмжил зүйн хуулиар чинь стандарт чинь сайн дурынх болчихсон юм. Техникийн зохицуулалт энэ асуудал биш байхгүй юу. Техникийн зохицуулалт чинь нөгөө бараа, үйлчилгээ, процесс тавьж байгаа аюулгүй байдлын шаардлагууд байхгүй юу. Энэ бол юу байх ёстой вэ гэхээр Засгийн газраас юм уу, сайдаас юм уу эсвэл тухайн засаг даргаас гамшигийн нөхцөлийн үед ийм ийм үйл ажиллагаа явуулна шүү гэдэг журам байх ёстой журамлах ёстой юм. Тэр Стандарт техникийн хэмжил зүйн газар энийг хийж чадахгүй. Тэр чинь дандаа мэргэжлийн техникийн шинж чанартай үйл ажиллагаа явуулдаг хүмүүс байгаа юм аа.

Тэгэхээр энийг онцгойгийнхон журам баталдаг юм уу эсвэл аймаг дээрээ Засаг дарга нар нь манай аймаг дээр гамшигийн нөхцөл үүсвэл ингэж ингэж үйл ажиллагаа явуулна шүү гэдэг юун дотроо журамлаж л оруулах хэрэгтэй байгаа юм.

Ж.Чинбүрэн: Нэмэлтээр санал хураалгая гэж санал дэвшүүллээ. Тэгэхээр эхлээд юун дээрээ хураачихъя.

Төслийн 3.7 дугаар зүйл дээрээ зарчмын зөрүүтэй санал дээрээ хураачхаад тэгээд дараа нь 6-г хасах хэсэг дээр Мөнх-Оргил гишүүний саналаар санал хураачихъя.

Төслийн 3.7 дугаар зүйлийн гарчгийн “онцгой нөхцөл байдлын нөхцөлд байгаа” гэснийг “гамшигийн онцгой нөхцөл байдлын” гэж, мөн зүйлийн “онцгой” гэснийг “гамшигийн онцгой нөхцөл” гэж тохиолдол бүрд өөрчилж, мөн зүйлийн 6, 7 дахь хэсгийг тус тус хасаж, мөн зүйлд доор дурдсан агуулгатай 6 дахь хэсэг нэмэх:

“6.Гамшиг, гамшигийн онцгой нөхцөл байдлын үед хүүхдийг насанд хүрсэн хүнд харгалзуулалгүйгээр орхих, хүүхдийн амь нас, эрүүл мэнд, аюулгүй байдлыг хангахаас бусад тохиолдолд хүүхдийг байгаа газраас нь авч явах, тээвэрлэхийг хориглоно.”

Энэ дээрээ санал хураалт хийе. Тэгэх үү? Тэгвэл нэмээд энэ дээр нэмээд 5 дугаар зүйлийг хасах гэдэг дээр 5 дугаар зүйлийг хасах гэдгээр санал байж байгаарай. 4 дүгээр микрофоныг нээгээд энэ дээр бас тайлбар хэлье гэж байна.

4 дүгээр микрофон.

5 дугаар зүйлийг хасахтай холбоотой тайлбар хэлэх байх.

Н.Баярмаа: Хүүхдийн эрхийн тухай хуулийн 12.8 дээрээ гамшигийн онцгой нөхцөлийн үеийн хүүхэд хамгааллын журмыг Засгийн газар батална гээд 2019 онд Засгийн газар хүүхэд хамгааллын энэ онцгой нөхцөлийн үеийн журмаа баталчихсан.

Хүүхэд хамгааллын кластер мэргэжлийн ангиуд ажилладаг ийм зохицуулалттай байгаа.

2017 онд болсон гамшигийн үеийн Сэндайн тунхаглал гээд гарсан юм. Яг энэ Сэндайн тунхаглалын үеэр энд Монгол Улсыг бас Онцгой байдлын ерөнхий газар хүүхдийн байгууллагатай хамтарч гамшигийн үеийн хүүхэд хамгааллын стандартыг батална гээд Засгийн газар, Их Хурлын тогтоолоор батлагдсан тэр тунхаглалыг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөнд байгаа. Тэгээд энэ дагуу бид нар олон улсын хүмүүнлэгийн үеийн хүүхэд хамгааллын гэсэн стандартыг Монголын хууль тогтоомж, эрх зүйн орчинтойгоо нийцүүлээд өнгөрсөн 2021 онд стандарт хэмжил зүйн газраар яамнаас Онцгой байдлын ерөнхий газартай хамтран боловсруулаад уг нь баталчихсан байгаа юм.

Тэгээд одоо нөгөө эрх зүйн зохицуулалтгүй мөртөө тэгээд энэ стандарт батлагдчихсан мөрдөгдөөд явж байгаа 2021 онд.

Ж.Чинбүрэн: Тэгэхээр 3.2 дугаар зүйлийн 5 дугаар хэсгийг хасах гэж нэмлээ шүү тийм ээ.

Санал хураалт 66.7 хувиар дэмжигдлээ.

Тэгээд 3.2 дугаар зүйлийн 5 дугаар хэсгийг хасах гэж санал хураасан шүү.

Төслийн 3.8 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу? Мөнх-Оргил гишүүн.

Ц.Мөнх-Оргил: Энэ их чухал заалт байгаа юм. Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа дахь хүүхэд хамгаалал гэж. Тэгэхээр энэ дээр манай ажлын хэсэг Баярмаа дарга та нэг ийм юм анхаараач.

Зөрчлийн хэрэг ч хянан шийдвэрлэж байна уу, Эрүүгийн хэрэг ч хянан шийдвэрлэж байна уу тэр чинь өөрөө тусдаа процесстой, хуультай. Яг тэр процессоороо явна. Тэрнээс биш мөрдөн байцаагч ч байдаг юм уу прокурор ч байдаг юм уу Хүүхэд хамгааллын тухай хуулийн 3.8.2-т ингээд заачихсан байна одоо би ийм ажиллагаа явуулна гэж явуулдаггүй байхгүй юу. Тэр чинь ерөөсөө зөвхөн процессын хуулиараа л явдаг юм. Тэр нь хүүхэд ч орсон байна уу, том хүн ч орсон байна уу тэрүүгээрээ л явна. Миний санааг ойлгож байна уу биш ээ. 3.8 хэрэг хянан шалгах ажиллагаан дахь хүүхэд хамгаалал гэж. Тэгэхээр энийг хэрвээ оруулах гэж байгаа бол Эрүүгийн процессын хуульдаа л нэмэлт, өөрчлөлт оруулах хэрэгтэй.

Ер нь оруул гэдэг шаардлагыг Хууль зүйн байнгын хороо Засгийн газарт санал оруулж байгаа юм.

Хоёр асуудал байгаа байхгүй юу. Хүүхэд өөрөө гэмт хэрэгт холбогдчихсон. Сэжигтэн яллагдагч болчихсон эсвэл хүүхэд гэмт хэргийн хохирогч болчихсон. 2 тусдаа юм байгаа байхгүй юу. Аль алиныг нь салгаж эрүүгийн процесст нь тусгаж ингэж оруулж ирэх ёстой юм байгаа юм. Тэрнээс биш Хүүхдийн эрхийг хамгаалах тухай хуульд процессын шинжтэй заалт ороод тэрийг нь прокурор мөрдөн байцаагч мөрдөж ажиллана гэж байхгүй. Боллоцоогүй тэгж болохгүй.

Зөвхөн мөрдөн байцаах энэ хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа зөвхөн эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааныхаа журмаар л явна.

Тийм учраас энэ бол заалтыг бүхэлд нь тэр процессын хуульд нь оруулах саналтай байна.

Ж.Чинбүрэн: Хэн хариулах вэ? 6 номерын микрофон.

Баттулга: Хүүхэд хамгааллын хуулийн төслийг дагалдуулаад тэр яг эрүүгийн хэрэг, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль, Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай энэ хуулиудад нэмэлт, өөрчлөлт оруулах яг тийм бас боломжгүй гэж Хууль зүйн яамнаас хэлсэн. Тэгэхээр тэр бие даасан яг үзэл баримтлалтайгаар боловсруулаад тэгээд орж ирэх ийм хуулийн төслүүд учраас бид нар дагалдуулаад боловсруулж чадаагүй.

Энэ дээр яах вэ бид нар энэ зарчмын шинжтэй заалтуудаа тусгачихъя. Тэгээд энэ дээр Хүүхдийн эрхийн хууль зүйн хороо гээд угаасаа бүтэц байгаа юм чинь тэрэн дээрээ энэ хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа, хүүхэд хамгааллын энэ холбогдолтой заалтуудаа бас хэрэгжүүлээд явах ийм нөхцөлийг нь бүрдүүлж өгч байгаа.

Ж.Чинбүрэн: Хууль зүйн яамнаас байгаа юм уу? Байхгүй. Тэгвэл ингэвэл яасан юм Мөнх-Оргил гишүүн ерөөсөө татан авах зарчмын зөрөөтэй санал гарвал яасан юм? Шууд яг тусгайлсан зүйлийг явуулчих уу? Ерөөсөө ингэвэл яасан юм? Энэ ХЗБХ-ноос дүгнэлт гаргуулах юм уу Мөнх-Оргил гишүүн ээ? Идэрбат гишүүн ажлын хэсгийн ахлагч.

Ц.Идэрбат: Тийм энэ хуулийн төсөл би Засгийн газраас өргөн барьсан хуулийн төсөл шүү дээ. Засгийн газар

хуулийн төслийг өргөн барихдаа Хууль зүйн яам энэ хуулийг төслийг хэлэлцэх нь зүйтэй гээд ингээд ороод ирж байгаа байхгүй юу. Боловсруулах ажлын хэсэгт нь ороод ажиллачихсан.

Тийм учраас би бол одоо энийг энэ яг хэрэг хянан шийдвэрлэхэд энэ хүүхдийн хамгааллын асуудлыг ингээд орхичихвол би боломгүй санагдаад байна. Боломгүй санагдаад байна. Ямар ч байсан хүүхэд хамгааллын хууль дээрээ бид энэ хэрэг хянан шийдвэрлэх энэ асуудал дээр чинь Хууль зүйн хороо эд нар гээд байгуулчхаад байгаа шүү дээ. Бүх аймгуудад байж байгаа. Бүх дүүргүүдэд байж байгаа.

Хэрвээ тийм процессын хуулиар бүгд явдаг юм бол тэнд Хууль зүйн хороо ч байхын хэрэггүй шүү дээ.

Тэгэхээр бид бол ямар ч байсан энэ хүүхэд хамгааллын хууль дээрээ бол энэ хэрэг хянан шийдвэрлэх үйл ажиллагаан дахь хүүхэд хамгаалал гэсэн энэ зүйл заалтыг би батлаад явъя л гэсэн ийм л саналтай байна. Энд би нэг их айхтар тэр процессын хууль руу нь ороод л хөндөөд л тухайн Эрүүгийн хуулиа хэрэгжүүлэхэд тэр хууль хяналтын байгууллагынханд ямар нэгэн байдлаар тийм хүндрэлтэй юм бол үүсэхгүй ээ. Зүгээр л нэг хүүхдийг 7 нас хүрсэн хүүхдээс зайлшгүй нэг тайлбар ав.

Тэр мөрдөн байцаалтын өрөө тасалгаа юмнуудыг нь хүүхдийн нас, хэл сэтгэхүйд нь тааруулаад өг. Аятай тухтай нөхцөл бүрдүүл. Тэр битгий хэл уулзалт дээр гарч байгаа нэг зүйл бол одоо жишээ нь эмэгтэй хүүхдийг эмэгтэй хэрэг бүртгэгч мөрдөн байцаагч мөрдмөөр байна гэсэн ийм зүйлүүд яг практик дээр бас гардаг юм байна лээ шүү дээ.

Нэг охины урд нэг эрэгтэй хүн суучхаад магадгүй өөрийнх нь ярьж чадахгүй тийм сэдвээр асуугаад байна гэдэг чинь өөрөө хэцүү юм байна лээ. Тэгэхээр энэ дээр би эрүүгийн тэр процессын хууль эд нарыг нэг их тийм ноцтой зөрчөөд тэр үйл ажиллагаа саатчих юм бол байхгүй гэж тэр ч утгаараа Хууль зүйн яам хандаж байгаа болов уу. Хандсан гэж. Зүгээр тэнд байгаа нэгж өрөө тасалгаа янзлах хүүхдээс нэг саналыг нь авах, гарах нөгөө үр дагаврыг тайлбарлаж өгөх эд нар гэсэн тийм л зүйлүүд байгаа. Одоо тэр нь би бол тэр процессын хуультайгаа нийцэж байгаа болоод энэ хууль боловсруулах энэнд оролцоо л гэж ингэж үзэж байгаа.

Тийм учраас ажлын хэсгийн ахлагчийн хувьд энэ хэрэг хянан шийдвэрлэх энэ үйл ажиллагаанд хүүхэд хамгааллын энэ асуудлыг явуулах нь зүйтэй л гэж ингэж хэлэх гэж байна.

Ж.Чинбүрэн: Тэгвэл санал хураачихъя.

23.Төслийн 3.8 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн “нас,” гэсний дараа “хүйс,” гэж нэмж, мөн хэсгийн “таатай орчинд” гэснийг “тусгай өрөөнд” гэж өөрчилж, мөн зүйлийн 7 дахь хэсгийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

55.6 хувиар дэмжигдлээ.

Төслийн 4.1 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу 4.1 алга байна. Ажлын хэсгээс бэлтгэсэн зарчмын зөрөөтэй нэг санал байна.

Төслийн “ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ” гэснийг “ХОЁРДУГААР БҮЛЭГ” гэж өөрчилж, 4.1 дүгээр

зүйлийн 2 дахь хэсгийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

77.8 хувиар дэмжигдлээ.

Төслийн 4.2 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу? Асуулт алга байна.

Ажлын хэсгээс бэлтгэсэн зарчмын зөрүүтэй нэг саналтай юм байна.

Төслийн 4.2 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн “30.1.1, 30.1.3” гэснийг “30.1” гэж өөрчилж, мөн зүйлийн 4 дэх хэсгийн “нөхцөл байдалд ороогүй” гэсний дараа “ нь аюулын зэргийн болон эрсдэлийн үнэлгээгээр тогтоогдсон” гэж нэмэх.

Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

Баярлалаа маш үнэтэй саналууд хэллээ.

55.6 хувиар дэмжигдлээ.

Төслийн 4.3 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу? Алга байна санал гараагүй.

Төслийн 4.4 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу? Алга байна. Ажлын хэсгээс бэлтгэсэн зарчмын зөрөөтэй нэг санал байна.

Төслийн 4.4 дүгээр зүйлийн 4 дэх хэсгийн “хүүхдийг гэр бүлээс нь түр тусгаарлах” гэснийг “Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 30.1-д” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт 66.7 хувиар санал дэмжигдлээ.

Төслийн 4.4 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу? Алга байна. Ажлын хэсгээс бэлтгэсэн зарчмын зөрүүтэй нэг саналтай. Аль билээ. Сая уншигчсан шүү дээ.

4.5 дугаар зүйлтэй холбогдуулан санал асуух гишүүд алга байна. Санал гаргаагүй байна.

Төслийн 4.6-тай зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу? Алга байна. Санал гаргаагүй. Төслийн 4.7 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу? Алга байна. Ажлын хэсгээс бэлтгэсэн зарчмын зөрүүтэй нэг саналтай юм байна.

Төслийн 4.7 дугаар зүйлийн 5 дахь хэсгийн “гэрээ байгуулж болохгүй хүн болох нь хожим илэрсэн,” гэснийг “гэрээг цуцлах үндэслэл” гэж, мөн хэсгийн “цуцалж, хүүхдийг буцаан авна” гэснийг “цуцална” гэж, мөн зүйлийн 6 дахь хэсгийн “цуцалж, хүүхдийг буцаан өгч” гэснийг “цуцалж” гэж тус тус өөрчлөх.

Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

66.7 хувиар дэмжигдлээ.

Төслийн 4.8 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу? Алга байна. Санал гараагүй байна.

Төслийн 4.9 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу? Алга байна. Ажлын хэсгээс зарчмын зөрүүтэй нэг санал байна.

Төслийн 4.9 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн “орон нутгийн байгууллага,” гэсний дараа “хамтарсан баг” гэж нэмж, мөн хэсгийн “кейс менежмент” гэснийг “тохиолдлын зохицуулалт” гэж, “кейс” гэснийг “тохиолдол” гэж тохиолдол бүрд өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

66.7 хувиар дэмжигдлээ.

Төслийн 4.10 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу? Алга байна. Санал гараагүй байна.

Төслийн 4.11 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу? Алга байна. Санал гараагүй байна.

Төслийн 4.12 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу? Алга байна. Санал гараагүй байна.

Төслийн 4.13 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу? Алга байна. Санал гараагүй байна.

Төслийн 4.14 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу? Алга байна. Санал гараагүй байна.

Төслийн 4.15 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу? Алга байна. Санал гараагүй байна.

4.16 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу? Алга байна. Санал гараагүй байна.

Төслийн 5.1 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу? Алга байна, санал гараагүй байна.

Төслийн 5.2 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу? Алга байна, санал гараагүй байна.

Төслийн 5.3 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу? Алга байна, санал гараагүй байна.

Төслийн 6.1 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу?

Идэрбат гишүүний микрофоныг нээе.

Ц.Идэрбат: Тийм 6.6 дээр байгаа энэ Засгийн газрын гишүүн бүр эрхлэх асуудлын хүрээнд гээд энийг татаж авъя.

29 дэх санал хураалт тэрийг татаад авчихъя.

Засгийн газрын гишүүн бүр эрхлэх асуудлын хүрээнд салбарын хүүхэд хамгааллын хэрэгжүүлэхэд шаардлагатай зардлыг гээд ингээд.

Ж.Чинбүрэн: 4 номерын микрофоныг нээе.

Н.Баярмаа: Хүүхэд хамгааллын бодлого дээр түрүүн тайлбар хэлчихсэн. Тэгээд хүүхэд хамгааллынх үйлчилгээ үзүүлж байгаа боловсролын салбар гэхэд хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлэх журамтай үйлчилгээ үзүүлээд явж байгаа. Боловсролын ерөнхий хуульдаа ч гэсэн хамгааллын зардалтай байна гээд тусчихсан.

Тэгэхээр яг энэ хүүхэд дээр тулж үйлчилгээ үзүүлж байгаа энэ Засгийн газрын гишүүд хүүхэд хамгааллын үйлчилгээний зардлаа төсөвтөө тусгадаг байх нь зөв гэж бодоод байгаа. Шууд сургуулийн орчинд хүүхдийн эрсдэлтэй нөхцөл гарлаа гэхэд кэйсээ нээгээд ажиллах нийгэм сэтгэл зүйн үйлчилгээгээ үзүүлэх энэ үйлчилгээг нь бид нар энэ хууль дээрээ батлаад оруулчхаж байгаа мөртөө зардалгүй

байна гэхээр Төсвийн хуулиа зөрчөөд манай хүүхдийн асуудал хариуцсан төсвийн ерөнхийлөн захирагчаас нөгөө захирагч руу шилжихгүй. Тийм учраас Боловсролын сайд боловсролын орчны хүүхэд хамгааллын зардлаа эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд Цахим хөгжлийн сайд ч гэсэн яг энэ цахим орчны хүүхэд хамгааллын зардлыг бол төсөвтөө тусгаад явах ийм нөгөө концепцтойгоор зохицуулалттайгаар оруулсан учир энэ нь байх ёстой л гэж үзэж байгаа.

Ж.Чинбүрэн: Идэрбат гишүүний микрофоныг нээе.

Ц.Идэрбат: Энэ маань нөгөө бид нөгөө Засгийн газрын гишүүн бүр эрхлэх асуудлын хүрээнд хүүхэд хамгааллын бодлого баталж хэрэгжилтэд хяналт тавина гэдэг маань санал хураалтаар уначхаад байгаа шүү дээ.

Засгийн газраас өргөн барьсан 3 дахь буюу төрийн байгууллага хуулиар хуулиар хүлээсэн чиг үүргийнхээ хүрээнд хүүхэд хамгааллыг дэмжих хэрэгжүүлэх үүрэгтэй гээд ингээд орчихсон байхгүй юу. Тийм тэгэхээр яах вэ зүгээр саяын юун дээр тэгвэл бид энэ Засгийн газраас өргөн барьсан энэ хувилбарынх нь хүрээнд найруулга хийгээд явж бас болох юм. Тэгэхгүй бол яг наад үг өгүүлбэрээрээ бас болохгүй л болчхоод зөрчилдөх гээд байгаа юм.

Ж.Чинбүрэн: Тэгвэл санал хураагаад найруулна гээд тэгээд ямар ч байсан энэ дээр санал хураачихъя. Энэ орох нь зүйтэй гэдэг санал.

Ц.Идэрбат: Тэгье, тийм.

Ж.Чинбүрэн: Засгийн газрын гишүүд гэж байгаа учраас.

Тэгвэл санал хураагаад тэгээд найруулна гэж ойлгоод санал хураачихъя тэгэх үү?

Санал хураалт.

Ер нь тэгээд энэ төсөвтэй байх нь чухал бас тэгж санаж байна. Төсөвтэй байх нь чухал тийм.

66.7 хувиар дэмжигдлээ.

Тэгээд найруулаад яагаарай. Тийм бодлого гэдэг үгийг нь хасахгүй бол болохгүй юм байна шүү. Тэр Засгийн газрын хүүхэд хамгааллын бодлого гэдэг угаасаа тэрэн дээр түрүүн өмнө нь хасагдсан шүү дээ тийм ээ. Идэрбат гишүүн ээ?

Тэгэхээр энэ дээр анхаараад найруулгуудаа зөв оруулчихъя.

Төслийн 6.2 дугаар зүйлд холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу? Алга байна, санал гараагүй.

Төслийн 6.3 дугаар зүйлд холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу? Алга байна. Ажлын хэсгээс бэлтгэсэн зарчмын зөрүүтэй нэг саналтай юм байна.

30.Төслийн 6.3 дугаар зүйлийн 1 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“1.Хүүхэд хамгааллын хууль тогтоомжийн хэрэгжилтэд дараах журмаар хяналт тавина:

1.1.аймаг, нийслэлийн Засаг дарга харьяалах нутаг дэвсгэрийн хэмжээнд, төрийн захиргааны төв болон нутгийн захиргааны байгууллага өөрийн хариуцсан салбарын хүрээнд хүүхдийн эрх, хүүхэд хамгааллын чиглэлээр тухайн жилд гүйцэтгэсэн ажлын тайланг дараа оны 2 дугаар сард

багтаан хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад хүргүүлэх;

1.2.хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага энэ зүйлийн 1-д заасны дагуу ирүүлсэн тайланд дүн шинжилгээ хийж, жил бүрийн 3 дугаар сард багтаан Хүүхдийн төлөө үндэсний зөвлөлөөр хэлэлцүүлэх;

1.3.Хүүхдийн төлөө үндэсний зөвлөл шаардлагатай тохиолдолд Засгийн газрын гишүүн, аймаг, нийслэлийн Засаг дарга, холбогдох төрийн байгууллагад чиглэл өгч, хэрэгжилтийг хангуулах.” Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

66.7 хувиар дэмжигдлээ.

Төслийн 6.4 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу? Алга байна. Санал гараагүй.

Төслийн 7.1 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу? Алга байна, санал гараагүй.

Төслийн 7.2 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу? Алга байна, санал гараагүй.

Төслийн 7.3 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу? Алга байна, санал гараагүй.

Төслийн 7.4 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу? Алга байна.

Энэ зарчмын зөрүүтэй нэг саналтай юм байна уншиж танилцуулъя.

31.Төслийн 7.4 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“1.Энэ хуулийг 2024 оны 09 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.” Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт 2024 оны хичээлийн жилтэй холбоотой яаж байгаа юм байна шүү дээ.

Санал хураалт.

Санал хураалт тийшээ хэлээд байгаа юм. Алхаа цохисон доо.

66.7 хувиар дэмжигдлээ.

Найруулгын саналаар санал хураалт.

Нэг саналтай.

1.Төслийн 3.4 дүгээр зүйлийн гарчгийн “мэдээлэл,” гэсний дараа “өргөн нэвтрүүлэг,” гэж нэмэх.

2.Төслийн 1.4 дүгээр зүйлийн 1.11 дэх заалтын “тодорхой” гэснийг “гэрээнд заасан” гэж, 2.9 дүгээр зүйлийн 1.3 дахь заалтын “жил бүрийн 4 дүгээр улиралд багтаан” гэснийг “жилд хоёроос доошгүй удаа” гэж, 3.2 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн “Боловсролын сургалтын байгууллагын хүүхдийн эрх, хамгааллын үйлчилгээ үзүүлэх нэгж нь хүүхэд сургалтын” гэснийг “Энэ зүйлийн 1-д заасан байгууллагын” гэж, мөн зүйлийн 2.3 дахь заалтын “хайрцаг байрлуулах” гэснийг “нээлттэй суваг ажиллуулах” гэж, мөн зүйлийн 5.5 дахь заалтын “агуулгыг бүх шатны боловсролын байгууллагын багш бэлтгэх, давтан сургах сургалтын хөтөлбөрт тусгаж,” гэснийг “агуулга туссан эсэхэд” гэж, 3.6 дугаар зүйлийн 7 дахь хэсгийн “дүүргийн” гэснийг “баг, дүүрэг, хорооны” гэж өөрчилж, 7.3 дугаар зүйлийн гарчгийн “Шилжилтийн үеийн”

гэснийг “Хууль дагаж мөрдөх журмын гэж тус тус өөрчлөх.

3.Төслийн 2.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн “хууль тогтоомж” гэснийг, мөн зүйлийн тайлбар хэсгийн “тухайн хуулийн этгээдийн ажилтны болон үйлчлүүлж байгаа” гэснийг, 2.2 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн “хувийн эрх зүйн” гэснийг, мөн зүйлийн 1.4 дэх заалтын “тогтмол хугацаанд” гэснийг, 4.3 дугаар зүйлийн 2.4 дэх заалтын “хөгжлийн, амьдрах ухааны” гэснийг, мөн заалтын “тохиромжтой үйл ажиллагаанд” гэснийг тус тус хасах санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

Бейсен гишүүн орсонгүй. Бейсен гишүүн.

Б.Бейсен: Энэ дэмжсэн боловч энэ төхөөрөмж буруу гараад л байна л даа дахиж санал хурааж өгнө үү.

Ж.Чинбүрэн: Саяын санал хураалтыг хүчингүй болгоё гэсэн томъёоллоор санал хураалт.

Санал хураалт.

55.6 хувиар дэмжигдсэн тул дахин санал хураалт.

Дахин санал хураалт.

66.7 хувиар дэмжигдлээ.

Одоо хуулийн төслийн хамт өргөн мэдүүлсэн *Хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг хийе ээ.*

Төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу? Алга байна. Санал гараагүй.

Төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу? Алга байна.

Хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлэг хийж, зарчмын зөрүүтэй саналаар санал хурааж дууслаа.

Хуулийн төслийн хамт өргөн мэдүүлсэн *Хүүхдийн эрхийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг хийе ээ.*

Төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу? Алга байна. Ажлын хэсгээс бэлтгэсэн 2 саналтай 2 саналыг уншиж танилцуулъя аа.

1.Төслийн 1 дүгээр зүйлийн 7 дахь заалтын 20.8 дахь хэсгийн “хяналт шалгалт хийхдээ Төрийн хяналт шалгалтын тухай хуулийг баримтлах” гэснийг “хүүхэд аюултай нөхцөл байдалд орсон, орсон байж болзошгүй тохиолдолд хяналт шалгалт явуулах аж ахуйн нэгж, байгууллага, барилга байгууламж, ажлын байр, орон байранд урьдчилан мэдэгдэхгүйгээр чөлөөтэй нэвтрэх эрхтэй” гэж өөрчилж, мөн зүйлийн 7 дахь заалтад доор дурдсан агуулгатай 20.9 дэх хэсэг нэмэх:

“20.9.Хүүхдийн эрхийн улсын байцаагчийн ажиллах дүрмийг Засгийн газар батална.”

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүд Идэрбат Анужин, Баярсайхан, Бейсен, Жаргалмаа цаашид ажлын хэсэг гэнэ ээ.

Санал хураалт 66.7 хувиар дэмжигдлээ.

2.Төслийн 1 дүгээр зүйлд доор дурдсан агуулгатай 8 дахь заалт нэмэх:

8/20¹ дугаар зүйл:

“20¹ дугаар зүйл. Хүүхдийн эрхийн олон нийтийн байцаагч

20¹.1. Сум, дүүргийн Засаг дарга баг, хороо бүрд хүүхдийн эрхийн олон нийтийн байцаагч ажиллуулж болно.

20¹.2. Хүүхдийн эрхийн олон нийтийн байцаагч тухайн сум, хорооны байнгын оршин суугч байна.

20¹.3. Сум, дүүргийн Засаг даргын захирамжийг үндэслэн Тамгын газрын дарга хүүхдийн эрхийн олон нийтийн байцаагчтай гэрээ байгуулах бөгөөд гэрээнд талуудын эрх, үүрэг, хариуцлага, ажил тайлагнах журам, урамшуулал, гэрээ цуцлах үндэслэлийг тусгана.

20¹.4. Хүүхдийн эрхийн олон нийтийн байцаагчтай байгуулсан гэрээг ажлын үр дүнг харгалзан жил бүр сунгана.

20¹.5. Хүүхдийн эрхийн олон нийтийн байцаагч дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

20¹.5.1. эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдийг илрүүлэх, мэдээлэх;

20¹.5.2. хүүхэд эрхээ хэрэгжүүлэхэд нь зөвлөгөө өгөх, туслалцаа үзүүлэх;

20¹.5.3. хүүхдийн сайн сайхан байдлыг хангахад чиглэсэн санал, санаачилга гаргаж хэрэгжүүлэх;

20¹.5.4. хүүхдийн эрх зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх, гарсан зөрчлийг арилгуулах арга хэмжээ авах;

20¹.5.5. хүүхдийн эрхийн зөрчлийн талаар эрх бүхий этгээдэд мэдэгдэж, шийдвэрлүүлэх.

20¹.6. Хүүхдийн эрхийн олон нийтийн байцаагч чиг үүргээ хэрэгжүүлэхдээ хамтарсан баг, хүүхэд, гэр бүлийн нийгмийн ажилтантай хамтран ажиллана.

20¹.7. Хүүхдийн эрхийн олон нийтийн байцаагч нь ажлын улирал тутмын төлөвлөгөөг сум, дүүргийн Засаг даргаар батлуулна.

20¹.8. Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан орон нутгийн байгууллага хүүхдийн эрхийн олон нийтийн байцаагчийг чадавхжуулах сургалтыг зохион байгуулна.

20¹.9. Хүүхдийн эрхийн олон нийтийн байцаагч сум, дүүргийн Засаг даргаас олгосон албаны үнэмлэхтэй байна. Албаны үнэмлэхийн загварыг хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага батална.

20¹.10. Сум, дүүргийн Засаг дарга хүүхдийн эрхийн олон нийтийн байцаагчид олгох урамшууллын зардлыг орон нутгийн төсвийн төсөлд тусгаж, тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар батлуулж, үр дүнг тайлагнана.”

Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

66.7 хувиар дэмжигдлээ.

Төслийн 3 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу? Алга байна. Ажлын хэсгээс бэлтгэсэн нэг саналтай юм байна.

3.Төслийн 4 дүгээр зүйлийн “15 дугаар зүйлийн 15.1.9 дэх заалтын дугаарлалтыг “15.1.10” гэж,” гэснийг хасаж, мөн зүйлийн ““20.5, 20.6, 20.7” дахь хэсгийн дугаарлалтыг “20.9, 20.10, 20.11”” гэснийг “20.5 дахь хэсгийн дугаарыг “20.9” гэж, 20.7 дахь хэсгийн дугаарыг “20.11” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

66.7 хувиар дэмжигдлээ

Төслийн 4 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу? Алга байна. Ажлын хэсгээс бэлтгэсэн нэг саналтай юм байна. Аан сая хураачихсан.

Төслийн 5 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу? Алга байна. Ажлын хэсгээс бэлтгэсэн нэг саналтай байна.

Төсөлд доор дурдсан агуулгатай 5 дугаар зүйл нэмэх:

“5 дугаар зүйл.Хүүхдийн эрхийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.6 дахь хэсгийг хүчингүй болсонд тооцугай.” Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

66.7 хувиар санал дэмжигдлээ.

Хүүхдийн эрхийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг хийлээ.

Хуулийн төслийн хамт өргөн мэдүүлсэн *Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг хийе* ээ.

Төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу? Алга байна. Ажлын хэсгээс бэлтгэсэн нэг сана саналтай юм байна. Унишиж танилцуулъя.

1.Төслийн 1 дүгээр зүйлд доор дурдсан агуулгатай 2, 3 дахь заалт нэмэх:

“2/30 дугаар зүйлийн 30.11 дэх хэсэг:

“30.11.Хүүхдийн түр хамгаалан байрлуулах үйлчилгээг төрөлжүүлэн зохион байгуулж болно.”

3/35 дугаар зүйлийн 35.2 дахь хэсгийн 2 дахь өгүүлбэр:

“Төрийн байгууллагын харьяанд байгуулсан түр хамгаалах байрны урсгал зардал, түр хамгаалан байрлуулж энэ хуульд заасан үйлчилгээ үзүүлэх зардлыг тухайн байгууллага хариуцна.” Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

66.7 хувиар санал дэмжигдлээ.

Төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу? Алга байна, санал гараагүй.

Төслийн 3 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу? Алга байна, санал гараагүй.

Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг хийлээ.

Хуулийн төслийг хамт өргөн мэдүүлсэн *Нийгмийн халамжийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай төслийн анхны хэлэлцүүлгийг хийе* ээ.

Төслийн 1 дүгээр зүйл зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу? Алга байна. Ажлын хэсгээс бэлтгэсэн нэг саналтай юм байна.

Хүүе орхичихсон байна. Сая 1 зүйл орхичихлоо. Энэ чинь давхар эргэчихсэн байна шүү уучлаарай.

Хүн худалдаалах тухай хууль чинь ороогүй байна шүү.

2.Төслийн 2 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 1, 2 дахь заалт нэмэх:

1/18 дугаар зүйлийн 18.1.2 дахь заалт:

“18.1.2.Засаг даргын өргөн мэдүүлснээр харьяалах нутаг дэвсгэртээ хэрэгжүүлэх гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх үйл ажиллагааны зардал, нэг цэгийн үйлчилгээний төв, түр хамгаалах байрны урсгал зардал, хамтарсан багийн үйл ажиллагааны зардал, хохирогчид үйлчилгээ үзүүлэхтэй холбоотой зардлыг тухайн орон нутгийн төсөвт тусган батлах, гүйцэтгэлийн тайланг хэлэлцэх;”

2/19 дүгээр зүйлийн 19.1.5 дахь заалт:

“19.1.5.тухайн шатны жилийн төсвийн төсөлд нэг цэгийн үйлчилгээний төв, түр хамгаалах байрны урсгал зардал, хамтарсан багийн үйл ажиллагааны зардал, хохирогчид үйлчилгээ үзүүлэхтэй холбоотой зардлыг тусгаж иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн мэдүүлэх, гүйцэтгэлийг тайлагнах;” санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

66.7 хувиар санал дэмжигдлээ.

3.Төслийн 2 дугаар зүйлийн 20.1 дэх хэсгийн “сургуулийн,” гэсний дараа “нийгмийн” гэж, мөн хэсгийн “тухайн сум,” гэсний дараа “баг,” гэж нэмэх.

Санал хураалт.

66.7 хувиар дэмжигдлээ.

4.Төслийн 3 дугаар зүйлийн “хуулийн” гэсний дараа “5 дугаар зүйлийн 5.1.4 дэх заалтын “гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх хамтарсан баг” цаашид “хамтарсан баг” гэх/” гэснийг “хамтарсан баг” гэж,” гэж нэмэх. Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

66.7 хувиар дэмжигдлээ.

Төслийн 4 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу? Алга байна. Ажлын хэсгээс бэлтгэсэн нэг саналтай.

Төслийн 4 дүгээр зүйлийг хасах.

Санал хураалт.

55.6 хувиар дэмжигдлээ.

Төслийн 5 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу? Алга байна. Санал гаргаагүй байна.

Төслийн 6 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу? Алга байна, санал гараагүй байна.

Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг хийж дуусгалаа.

Хулийн төслийн хамт өргөн мэдүүлсэн [Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах](#)

тухай хууль төслийн анхны хэлэлцүүлгийг хийе ээ.

Төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу? Алга байна. Ажлын хэсгээс бэлтгэсэн нэг саналтай.

1.Төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалтын 5.2.5 дахь заалтын “байгуулах” гэснийг “байгуулж, ажиллах журмыг батлах” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

66.7 хувиар дэмжигдлээ.

Төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу? Алга байна, санал гараагүй байна.

Төслийн 3 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу? Алга байна, санал гараагүй байна.

Хүн худалдаалах тэмцэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг хийлээ.

Хуулийн төслийн хамт өргөн мэдүүлсэн [Нийгмийн халамжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг хийе ээ.](#)

Төслийн 1 дүгээр зүйлд холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу? Алга байна. Ажлын хэсгээс бэлтгэсэн нэг саналыг уншиж танилцуулъя.

1.Төслийн 1 дүгээр зүйлийн 19¹.2 дахь хэсгийн “хувь хүн,” гэснийг хасаж, мөн зүйлд доор дурдсан агуулгатай 2 дахь заалт нэмэх:

“2/13 дугаар зүйлийн 13.13, 13.14 дэх хэсэг:

13.13.Нийгмийн халамжийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага дараах тохиолдолд хүүхдийн тэтгэмжийг эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчид олгохыг түдгэлзүүлэх шийдвэр гаргана:

13.13.1.эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч нь сураггүй алга болсон;

13.13.2.эцэг, эх нь хүүхдээ асран хамгаалах, тэжээн тэтгэх үүргээ биелүүлээгүй, эсхүл эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч нь хүүхдийн эрхийг зөрчсөн талаар аймаг, дүүргийн хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан байгууллага, хүүхдийн эрхийн улсын байцаагчийн дүгнэлт гарсан, хүүхдийн эсрэг гэмт хэрэг үйлдсэн нь тогтоогдсон.

13.14.Энэ хуулийн 13.1.6-д заасан хүүхдийн мөнгөн тэтгэмжийг зээл, өр төлбөрт суутгахыг хориглоно. Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

66.7 хувиар дэмжигдлээ.

Төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу? Алга байна. Санал гаргаагүй.

Төслийн 3 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүн байна уу? Алга байна, санал гараагүй.

Төслийн 4 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу? Алга байна ажлын хэсгээс бэлтгэсэн нэг саналтай.

2.Төслийн 4 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулж, 3 дугаар зүйл болгох:

“3 дугаар зүйл. Нийгмийн халамжийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.9 дэх заалтын, 19 дүгээр зүйлийн 19.1.3, 19.2.3 дахь заалтын “хүнд нөхцөлд” гэснийг “эрсдэлт нөхцөлд” гэж, 13 дугаар зүйлийн 13.13 дахь хэсгийн дугаарыг “13.15” гэж тус тус өөрчилсүгэй.” Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

66.7 хувиар дэмжигдлээ.

Төслийн 5 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу? Алга байна. Ажлын хэсгээс бэлдсэн нэг саналтай.

3.Төслийн 5 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулж, 4 дүгээр зүйл болгох:

“4 дүгээр зүйл. Энэ хуулийг 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.” Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

66.7 хувиар санал дэмжигдлээ.

Ингээд хамт өргөн мэдүүлсэн Нийгмийн халамжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай анхны хэлэлцүүлэг хийж дуусгалаа.

Хуулийн төслийн хамт өргөн мэдүүлсэн Гэр бүлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг хийе ээ. Гэр бүлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл хэлэлцэгдэж байгаатай холбогдон төслийг хууль санаачлагчид буцаах.

Санал хураалт.

Дэмжигдсэнгүй ээ.

Булгантуяа сайд хэлэх үү? Тийм байна горимын санал. Булгантуяа сайд.

Х.Булгантуяа: Дарга сая санал хураалтад тоног төхөөрөмж ажилласангүй. Саяын санал хураалтыг хүчингүй болгож дахин санал хураалт явуулж өгнө үү.

Ж.Чинбүрэн: Саяын санал хураалтыг хүчингүй болгох санал хураалт.

66.7 хувиар дэмжигдлээ.

Дахин санал хураалт явуулья.

Төслийг хууль санаачлагч буцаах санал хураалт 66.7 хувиар дэмжигдлээ.

Хуулийн төслийн хамт өргөн мэдүүлсэн Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг хийе ээ.

Төслийн 1 дүгээр зүйлд холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу? Алга байна.

Төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу? Алга алга байна.

Хамт өргөн мэдүүлсэн Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг хийж дууслаа.

Хуулийн төслийн хамт өргөн мэдүүлсэн эрүүл мэндийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг хийе ээ.

Төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу? Алга байна. Нэг санал байна аа.

1.Төслийн 1 дүгээр зүйлийн “сурагчдад” гэсний өмнө “оюутан,” гэж, мөн зүйлийн “хүүхдэд” гэсний өмнө “дээд боловсролын сургалтын байгууллагын суралцагч, эрсдэлт нөхцөлд байгаа” гэж тус тус нэмэх. Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

44.4 хувиар санал уначихлаа.

Баярсайхан гишүүн санал хэлэх үү? Санал уначихлаа. Баярсайхан гишүүн.

Б.Баярсайхан: Сая тоног төхөөрөмж ажилласангүй дарга аа. Саяын санал хураалтыг хүчингүй болгоод дахиад явуулж өгнө үү? Баярлалаа.

Ж.Чинбүрэн: Баярсайхан гишүүний саналаар санал хүчингүйд тооцох санал хураалт.

66.7 хувиар дэмжигдлээ.

Дахин санал хураалт.

Төслийн 1 дүгээр зүйлтэй Эрүүл мэндийн хуульд.

66.7 хувиар дэмжигдлээ.

Төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу? Алга байна.

Хамт өргөн мэдүүлсэн эрүүл мэндийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг хийж дууслаа.

Хуулийн төслийн хамт өргөн мэдүүлсэн Хууль зүйн туслалцааны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг хийе ээ.

Төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу? Алга байна.

Төслийн 2 дугаар зүйлтэй холбоотой асуулт асуух гишүүд байна уу? Алга байна.

Хамт өргөн мэдүүлсэн Хууль зүйн туслалцааны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг хийж дуусгалаа.

Хуулийн төслийн хамт өргөн мэдүүлсэн Гамшигаас хамгаалах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг хийе ээ.

Төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу? Алга байна.

Төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу? Алга байна.

Хамт өргөн мэдүүлсэн Гамшигаас хамгаалах тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлэг хийж дууслаа.

Хуулийн төслийн хамт өргөн мэдүүлсэн Онц байдлын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлэг хийе ээ.

Хууль санаачлагчид нь буцаах гэсэн ийм санал байна.

Санал хураалт.

66.7 хувиар дэмжигдлээ.

Хамт өргөн мэдүүлсэн Гамшигаас хамгаалах тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлэг хийж дууслаа.

Хуулийн төслийн хамт өргөн мэдүүлсэн Төрийн хэмнэлтийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг хийе ээ.

Төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу? Алга байна.

Энэ төслийн 1 дүгээр зүйл дээр гарчиг дээр санал орсон юм байна.

Төслийн гарчгийн өөрчлөлт гэснийг оруулах гэж өөрчилж, 2 дугаар зүйлийг хасах. Санал гарсан ажлын хэсэг.

Санал хураалт.

66.7 хувиар дэмжигдлээ.

Төслийн 3 дугаар зүйлтэй холбоод холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу? Алга байна.

Хамт өргөн мэдүүлсэн Төрийн хэмнэлтийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлэг хийж дууслаа.

Иргэний бүртгэлийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг хийе.

Хууль санаачлагчид нь буцаах гэсэн ийм санал байна.

Санал хураалт.

3-ыг буцааж байгаа.

66.7 хувиар дэмжигдлээ.

Хуулийн төслийн хамт өргөн мэдүүлсэн Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ

худалдан авах тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг хийе.

Төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу? Алга байна.

Төслийн 2 дугаар зүйлтэй холбоотой асуулт асуух гишүүд байна уу? Алга байна.

Хамт өргөн мэдүүлсэн Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлэг хийж дууслаа.

Хүүхэд хамгааллын тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн бусад хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг хийж дууслаа.

Байнгын хороогоор анхны хэлэлцүүлэг явсан талаарх санал дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Идэрбат гишүүн чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулна аа.

14.50 цагт

3 дахь асуудал аягүй хурдан

Монгол Улсын Их Хурлын 2023 оны 6 дугаар сарын 30-ны өдрийн 60 дугаар тогтоолоор байгуулсан Эмийн үнийн өсөлтийн шалтгаан нөхцөлийг хянан шалгах түр хорооны ажиллах хугацааг сунгах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэж эхэлье ээ.

Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Их Хурлын 2023 оны 6 дугаар сарын 30-ны өдрийн 60 дугаар тогтоолоор эмийн үнийн өсөлтийн шалтгаан нөхцөлийг хянан

шалгах түр үүрэг бүхий түр хороо байгуулагдан ажиллаж байгаа бөгөөд Хянан шалгах түр хорооны даргаар Улсын Их Хурлын гишүүн Чинбүрэн Түр хорооны гишүүдээр Улсын Их Хурлын гишүүн Батлут, Бейсен, Жаргалмаа, Оюунчимэг, Сандаг-Очир, Туваан нар ажиллаж байна аа.

Хянан шалгах түр хороо нь одоогоор нийт 5 хянан шалгагч 4 шинжээчийг томилон ажиллуулж байгаа бөгөөд тусгай шалгалтын сэдвийн хүрээнд дараах асуудлаар нотлох баримтыг цуглуулж шинжлэн судалж байна.

Үүнд: Зайлишгүй шаардлагатай эмийн жагсаалтыг батлах шийдвэр өнөөгийн нөхцөл байдалд тулгамдаж байгаа асуудал.

2.Тус жагс жагсаалт дахь эмийн чанар, аюулгүй байдал, чанарын баталгаажуулалтын нөхцөл байдал.

3.Эмийн чанарыг хянах тогтолцоо эмийн чанарыг үнэлэх биологийн сорил эмнэл зүйн судалгааны байдал.

4.Зах зээлд худалдаалагдаж байгаа зайлишгүй шаардлагатай эмийн үнийн өсөлтийн бодит шалтгаан нөхцөлийг тодорхойлж ялангуяа тендер шалгаруулах татвар гэх мэт асуудлыг авч үзэж дүн шинжилгээ хийх.

5.Зайлишгүй шаардлагатай эмийн нэр төрөл зонхилон тохиолдох өвчнийг эмчлэх үр дүн чиглэж чадаж байгаа эсэхийг тодорхойлж практик хэрэглээ шаардлагыг тодорхойлох, эмийн хүртээмж судалгаа хийх.

6.Зайлишгүй шаардлагатай эмийн жагсаалтад ороогүй бусад нэр төрлийн эм, бэлдмэл, нэмэлт бүтээгдэхүүн, уламжлалт эм, түүний түүхий эд, тан

зэргийг цахимаар эмийн сангаар болон хувь хүн худалдаалж байгаа өнөөгийн байдалд дүн шинжилгээ хийж цаашид бүртгэх чанар аюулгүй байдалд хяналт тавих талаар авах арга хэмжээний санал боловсруулах зэрэг болно оо.

Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.8 дахид заасны дагуу Хянан шалгах түр хорооны ажиллах хугацаа 2023 оны 11 дүгээр сарын 30-ны өдөр дуусгавар болж байгаа бөгөөд цаашид тусгай шалгалтын хүрээнд нарийвчлан цуглуулах зайлишгүй шаардлагатай нотлох баримтыг гаргуулан авах, холбогдох этгээдээс тайлбар авах, эмийн хадгалалт хамгаалалтын стандартын шаардлагыг хангаж байгаа эсэх талаар зарим аймаг сумын эмийн сангийн нөхцөл байдал газар дээр нь танилцах зэрэг ажлуудыг хийхээр төлөвлөж байна аа.

Түүнчлэн Монгол Улсын хүн амын дунд өндөр үнэлгээтэй зайлишгүй шаардлагатай эмийн 10 дугаар жагсаалт болон ЭМД-ын сангаас хөнгөлөлттэй олгох эмийн жагсаалтад орсон хатуу зохицуулалттай орноос бусад бусад үйлдвэрлэсэн зарим нэр төрлийн эмийг түүвэрлэн авч чанарыг шалгуулах эмийн чанарын хяналтын лабораторийн шинжилгээнд өгсөн бөгөөд шинжилгээний хариу гарахад тодорхой хугацаа шаардагдаж байна аа.

Байнгын хорооны гишүүд ээ,

Монгол Улсын Их Хурлын хянан шалгах тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.8-д шаардлагатай мөн хугацаагаар нэг удаа сунгаж болох бөгөөд бид заасны дагуу Улсын Их Хурлын 2023 оны 6 дугаар сарын 30-ны өдрийн 60 дугаар тогтоолын байгуулагдсан эмийн үнийн өсөлтийн шалтгаан нөхцөлийг хянан шалгах үүрэг бүхий Хянан шалгах түр

хорооны ажиллах хугацааг сунгах Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэн шийдвэрлэж дэмжиж өгөхийг та бүхнээс хүсье.

Анхаарал хандуулсанд баярлалаа.

Ингээд Улсын Их Хурлын тогтоолын төслийг та бүхэнд тараасан байгаа. Хянан шалгах түр хорооны ажиллах хугацааг сунгах тухай санал тогтоолын төсөлтэй холбогдуулан асуулт асууж, үг хэлэх гишүүд байна уу? Алга байна.

Хянан шалгах түр хорооны ажиллах хугацааг сунгах тухай тогтоолын төсөлтэй холбогдуулан асуулт асууж, үг хэлэхээр гишүүд нэр өгсөнгүй ээ. Ингээд гишүүд асууж асуулт асууж, үг хэлэх шаардлага үүссэнгүй.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 93 дугаар зүйлийн 93.1 дэх хэсгийг үндэслэн Хянан шалгах түр хорооны ажиллах хугацааг сунгах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг

чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэхийг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя.

Санал хураалт явуулж дууслаа.

Тогтоолын төслийг хэлэлцсэн талаар байнгын хорооноос гаргах санал, дүгнэлтийг нэгдсэн хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн Чинбүрэн би өөрөө уншъя.

55.6 хувиар дэмжсэн байна.

Нийгмийн бодлогын байнгын хорооны хуралдааны хэлэлцэх асуудал дууссан тул энэ өдрийн хуралдаан өндөрлөлөө. Идэвхтэй оролцсон гишүүддээ баярлалаа.

14.54 цагт

Дууны бичлэгээс буулгасан:
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
ХӨТЛӨХ АЛБАНЫ ШИНЖЭЭЧ
П.МЯДАГМАА